

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах							
1.1	Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангахтай холбоотой Монгол Улсын авсан үүрэг амлалтыг биелүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагаас Монгол Улсын Худалдааны бодлогыг хянасан 2023 оны дүгнэлтийн хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр	1-2.Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хүргүүлж 2023 онд 85.3 хувьд хүрсэн.	1.Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн “7 дугаар зүйлийн 5 дахь заалт Бүрдүүлэлтийн дараах шалгалтын биелэлтийг хүргүүлсэн байна. Барааны урьдчилсан шийдвэртэй холбоотой биелэлтийг хүргүүлнэ. Нийт хэрэгжилт 94 хувьтай байна.	ДГБ-ын “Меркатор” хөтөлбөр болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх онош зүйн шинжилгээний тайланг ГЕГ-ын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэл /Зүйл 7.5/-ээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг ГХЯ-нд хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын тус хэлэлцээрийн хүрээнд авсан үүрэг амлалтыг 87.5 хувьд хүргэсэн. Бүрдүүлэлтийн дараах шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр Дэлхийн гаалийн байгууллагын бүрдүүлэлтийн дараах шалгалт, барааны гарал үүслийн сургалт, мөн Олон улсын валютын сангаас зохион байгуулсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх сургалтад тус тус хамруулсан. Үнэлгээ: 74.5 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	41.5 хувь
					2.Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд	Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт 2020 онд 26.5 хувь байсан. Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгасны дагуу худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, 2021 онд 56.3 хувь, 2022 онд 79.8 хувь, 2023	

				Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 2 заалт (7.4. Эрсдэлийн удирдлага, 10.3. Олон улсын стандарт ашиглах)-ын биелэлтийг хүргүүлсэн байна. Нийт хэрэгжилт 73 хувьтай (67.4+5.6) байна.	онд 85.2 хувьд хүрсэн ба 2024 оны эхний хагас жилд Бүрдүүлэлтийн дараах шалгалтын хэрэгжилтийг хүргүүлснээр Монгол Улсын үүрэг амлалт 87 хувьд хүрсэн. Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хүргүүлсэн бол 10.3 дахь заалтын хэрэгжилтийг 2025 онд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт 87 хувьтай байна. Үнэлгээ: 2-50 хувь, эрчимжүүлэх шаардлагатай, 3-0 хувь, үр дүнгүй.	
			3.ГЕГ-ын 2021 онд худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2023 онд хэрэгжилт хангах үүрэг амлалт авсан арга хэмжээний тайлан хүргүүлж хэрэгжилтийг ханган ажилласан.	3.Монгол Улсын Худалдааны бодлогыг дүгнэсэн 2021 оны тайлангийн хэрэгжилтийг хангасан байна.		
1.2	Гадаад орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны мэдээлэл солилцох үйл ажиллагааг хөгжүүлэх	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.“Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааны судалгаа”-г 2023 онд хийсэн. Дээрх судалгааны дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахаар нэгтгэж байна.	1.Боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, бараа, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэх цаг хугацаа буурсан байна. Гаалийн шинэчлэлийн хүрээнд автозамын хилийн боомтуудыг үе шаттайгаар өргөтгөн шинэчилснээр: - БНХАУ-тай хил залгаа боомтуудаар 2024 оны эхний 11 сард 646668 тээврийн хэрэгслээр экспортын эрдэс бүтээгдэхүүн тээвэрлэж, өнгөрсөн оны мөн үеэс 17.2 хувиар нэмэгдсэн. -ОХУ-тай хиллэдэг авто замын боомтоор 2024 оны 11 дүгээр сарын байдлаар суудлын 270438, ачааны 61225 тээврийн хэрэгсэл тус тус хилээр нэвтэрсэн нь суудлын тээврийн хэрэгслийн тоо 7.8 хувиар, ачааны тээврийн хэрэгслийн тоо 8.6 хувиар нэмэгдсэн. Гаалийн шинэчлэлийн хүрээнд боомт руу орох, гарах гарц дээр ухаалаг гарцын системийн тоног	78 хувь

					төхөөрөмжүүдийг суурилуулж, боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн хэрэгслийн бүртгэлийг цахимжуулах ажлыг Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтын бүтээн байгуулалттай уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлснээр тээврийн хэрэгслийг дунджаар 3-5 секундэд бүртгэж, нэвтрүүлж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			2.Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 10-р хуралдааныг 2023.09.07-ны өдөр цахимаар амжилттай зохион байгуулсан. Хуралдаанаар “Хяналт шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх туршилтыг хэрэгжүүлэх төсөл”-ийг цаашид үргэлжлүүлэх боломжгүй учраас цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж шинэчлэх асуудлыг судлахаар тохиролцсон.	2.Хөрш орны гаалийн байгууллагатай хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор хамтарсан шалгалт хийх, харилцан бичиг баримтыг хүлээн зөвшөөрөх, гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлтийн чиглэлээр хамтын ажиллагааг үнэлж, дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлсон байна.	Хөрш орны гаалийн байгууллагатай хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор хамтарсан шалгалт, холбоо баригч дарга нарын уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан боловч ОХУ-ын Холбооны гаалийн алба, БНХАУ-ын ГЕГ-аас 2024 оны уулзалтуудыг зохион байгуулаагүй хойшлуулсан болно. 1.Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын 2024 оны хилийн хамтарсан шалгалтын уулзалтыг БНХАУ-ын ГЕГ-аас зохион байгуулах ээлжтэй боловч, өнөөдрийн байдлаар уулзалтын товтой холбоотой мэдээлэл ирүүлээгүй байна. Хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 10-р хуралдааныг 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр цахимаар амжилттай зохион байгуулж, 4 асуудлаар Протоколд гарын үсэг зурсан. Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын 2023 оны хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 9-р хуралдааны Протоколын Монголын талын хэрэгжилт 94.2, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээтэй төлөвлөгөөний биелэлт 86.6 хувьтай байна. 2.БНХАУ-ын ГЕГ-аас 2024 оны хамтарсан шалгалтын уулзалтын бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2024.06.05-ны өдөр цахимаар “Хяналт, шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх” төслийг ирүүлсэн. Дээрх төсөлтэй танилцаж, саналаа БНХАУ-ын ГЕГ-т хүргүүлэн хариу хүлээж байна. 3.Монгол Улсын ГЕГ болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн гаалийн газар, Алс Дорнодын гаалийн газар хоорондын хилийн холбоо баригч дарга нарын 2023 оны уулзалтын Протоколын Монголын талын хэрэгжилт 95, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээний биелэлт 98.8 хувьтай байна.	

					4.ОХУ-ын ХГА-аас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн “Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын рентген тоног төхөөрөмж ашиглан мэдээлэл солилцох тухай хэлэлцээр”-ийг шинэчлэх төсөлтэй танилцаж, саналаа 2024 оны 6 дугаар сард ОХУ-ын ХГА-д хүргүүлсэн. 5.Монгол улс - БНХАУ Засгийн газар хоорондын 1993 онд байгуулсан хэлэлцээр, Монгол улс - ОХУ Засгийн газар хоорондын 1993 онд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх протоколын дагуу 2 орны зэрэгцүүлэлтийн ажлыг 2013 оноос хийж эхэлсэн. Монгол улс, БНХАУ-ын хилийн гаалийн байгууллагын холбоо баригч дарга нарын 2023 оны 10 дугаар сард болсон уулзалтын протоколын дагуу Монгол улс, БНХАУ-ын ӨМӨЗО-той хиллэж буй 5 боомтын (Замын-Үүд – Эрээн, Бичигт – Зүүн хатавч, Ханги – Мандал, Гашуунсухайт – Ганцмод, Шивээхүрэн – Сэхээ) 2022 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлтийн хуралдааныг БНХАУ-ын Эрээн хотод 2023 оны 12-р сарын 18-20-ны өдрүүдэд хийсэн. Зэрэгцүүлэлтийг хоёр талын солилцсон мэдээллийн үндсэн дээр боомт тус бүрээр, БТКУС-ийн ангиллын дагуу хийсэн. Уг ажлын тайлан, танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, цаашид авах арга хэмжээ, зөвлөмжийг гаргасан. Зэрэгцүүлэлтийн ажлын үр дүнд: БНХАУ-ын боомтуудаар дамжуулан гуравдагч улсад экспортолдог Чулуун нүүрсний асуудлыг тодорхой болгож ГЕГ-ын даргын удирдамжаар ажлын хэсэг байгуулагдан хүлээн авагч улс нь БНСУ, Сингапур, Хонконг байсан 2022, 2023 оны нийт 16785 гаалийн мэдүүлгийг БНХАУ болгон засварласан. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.
			3.БНХАУ-ын зүгээс биечлэн зэрэгцүүлэлт хийх боломжгүй гэх хариуг ирүүлсэн. - БНХАУ-ын 5	3.БНХАУ-тай 2023 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийсэн байна.	Монгол улс - БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2023 онд хоёр улсын хооронд хийгдсэн гадаад худалдааны гаалийн статистикийн зэрэгцүүлэлт хийх мэдээллийг БНХАУ-д хүргүүлсэн ба БНХАУ-ын талаас 2023 оны гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлтийг хийх боломжгүй гэж

				боомтын зэрэгцүүлэлтийг хийсэн.		хариу мэдэгдсэн. Үнэлгээ: 30 хувь, үр дүнгүй.
				4.ОХУ-ын зүгээс биечлэн зэрэгцүүлэлт хийх боломжгүй гэх хариуг ирүүлсэн.	4.ОХУ-тай 2023 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийсэн байна.	Монгол улс - ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2023 онд хоёр улсын хооронд хийгдсэн гадаад худалдааны гаалийн статистикийн зэрэгцүүлэлт хийх мэдээллийг ОХУ-д хүргүүлсэн ба ОХУ-аас 2023 оны мэдээллийг ирүүлсэн. ОХУ-аас ирүүлсэн мэдээллийг өөрийн мэдээлэлтэй БТКУС-ийн 2, 4, 6 орноор зэрэгцүүлэлт хийх файлыг бэлэн болгож, Монгол улс, ОХУ хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны барааг БТКУС-ийн орон тус бүрээр зөрүүг гаргах, их зөрүүтэй барааг тогтоох, зөрүүг нарийвчлан шалгах, учир шалтгааныг тогтоох зэрэгцүүлэлтийн ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс хийж эхэлсэн. Зэрэгцүүлэлт хийх барааг сонгон БТКУС-ийн 4 орны түвшингээр /экспортын 6 бараа, импортын 9 бараа / гарган ОХУ-ын Холбооны гаалийн албанд хүргүүлсэн бөгөөд ОХУ-ын талаас экспортын 4, импортын 3 барааны жагсаалт ирүүлсэн. Монгол улс, ОХУ-ын хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлт хийх экспертүүдийн 4 дүгээр уулзалт 2024 оны 10 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд 2 талын санал солилцсон экспортын 10, импортын 12 барааны зэрэгцүүлэлтийг хийж, зөрүү үүссэн шалтгааныг нарийвчлан тогтоож хамтын ажиллагааг үнэлж, дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлсон. Үнэлгээ: 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.

				5.БНХАУ болон ОХУ-тай 2022 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийж, зөрүүний учир шалтгааныг тогтоож, зөрүү ихтэй барааны жагсаалтыг гарган, барааг сонгон тус бүрээр зөрүүний учир шалтгааныг тогтоож, танилцуулга бэлдсэн.	5.Өмнөх оны зэрэгцүүлэлтийн зөрүүний учир шалтгааныг тогтоож, зөрүүг багасгахтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Өмнөх оны зэрэгцүүлэлтийн зөрүүний учир шалтгааныг тогтоож, зөрүү ихтэй барааны жагсаалтыг гаргасан. Үүнд: -Чирэгч толгойг манай тал (HS: 8704)-оор ангилдаг бол хятадын тал (HS: 8701) ангилдаг. Иймд чирэгч толгойны ангиллыг тодорхой болгож ангиллын зөрүүг арилгах, -Монгол улс хөнгөн цагааны хайлш (HS: 7601.20)-ыг экспортлохыг хориглосон тул бараандаа тодорхой хэмжээний боловсруулалт хийн хөнгөн цагаанаар хийсэн бусад эдлэл (HS: 7616.99)-ээр экспортолдог байна. Хятадын тал уг барааг шинжилгээнд хамруулж агууламжийг тодорхойлсны үндсэн дээр (HS: 7601.20) кодоор гаалийн бүрдүүлэлтийг хийдэг байна. Иймд энэ төрлийн барааны шинжилгээнд анхаарах. -Гашуунсухайт, Шивээхүрэн дэх гаалийн газраар гуравдагч орон луу гаргаж байгаа чулуун нүүрс (HS: 2701)-ний гаалийн бүрдүүлэлт хийхэд гаалийн мэдүүлгийн 11-р хүснэгт буюу гэрээт улсын код, нэрийг тухайн гуравдагч орноор, гаалийн мэдүүлгийн 12-р хүснэгт буюу хүлээн авагч улсын код, нэрийг БНХАУ (CN) байхаар нөхөн бичихэд анхаарах, -Ханги боомтын импортын тоо хэмжээ хятадын экспортын тоо хэмжээнээс 21.2 мян.тн-оор бага байна. Энэ сөрөг зөрүү нь төмөр зам болон трамвайн зам, төмөр (HS: 7302) болон цемент, бетон эсхүл хиймэл чулуун бүтээгдэхүүн (HS: 6810)-д үүссэн. Мэдээллийг тулгаж үзсэний үндсэн дээр тухай 2 төрлийн бараа нь Ханги боомтод төмөр зам тавьсан аж ахуйн нэгжийн бүрдүүлэлттэй холбоотой байх тул бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах. -Гашуунсухайт дахь гаалийн газарт бүрдүүлэлт хийсэн (HS: 7308.40)-ийн бүрдүүлэлтийг нарийвчлан шалгуулах. -Хятадын талд торго (HS: 5007) экспортолсон мэдээлэл бүртгэгдсэн бол манай талд бүртгэлгүй байсан. Иймээс БНХАУ-ын гаалийн ерөнхий газраас торго (HS: 5007) экспортолсон аж ахуй нэгжийн мэдээллийг нарийвчлан авах. Мөн ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодод: Бичигт дэх гаалийн газарт:
--	--	--	--	---	--	--

						- Барааны жинд анхаарч бүрдүүлэлт хийх Ханги дахь гаалийн салбарт: - Цахилгаан эрчим хүч (HS: 2716)-ний бүрдүүлэлтийг хийж байх. Шивээхүрэн дэх гаалийн газарт: - Чулуун нүүрсний “хүлээн авагч улс”-ыг гаалийн мэдүүлэгт зөв бөглөхөд анхаарах. Гашуунсухайт дахь гаалийн газарт: - Чулуун нүүрсний “хүлээн авагч улс”-ыг гаалийн мэдүүлэгт зөв бөглөхөд анхаарах. - 55-р бүлэгт хамаарах даавууны гаалийн бүрдүүлэлтэд анхаарах. /Монголын тоо хэмжээ Хятадын талаас их хэмжээгээр бага байсан./ - БТКУС-ийн 7308.40 кодоор бүрдүүлэлт хийсэн мэдээлэл Хятадын талаас тоо хэмжээний хувьд маш их зөрүүтэй байгаа тул анхаарах. Замын-Үүд дэх гаалийн газарт: - Торгоны (HS: 5007) бүрдүүлэлтэд илүү анхаарах - Боржин чулуу (HS: 6802.23), Гипс (HS: 6809), (HS: 6902) бараануудын бичиг баримт болон биет шалгалтыг илүү анхаарч ажиллах талаар зөвлөмж чиглэл хүргүүлсэн. Үүний дагуу: - Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас 417.1 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийг ногдуулж, Нийслэлийн прокурорын газарт шалгуулахаар шилжүүлсэн. - ГЕГ-аас БНХАУ-ын талд мэдээлэл авах талаар хандсан боловч нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлээгүй байна. Ирүүлсэн мэдээллээр бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх боломжгүй байна. Зэрэгцүүлэлтийн ажлын үр дүнд зөрүүг багасгахтай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: 1.Нүүрсний экспортын зөрүү үүсэх шалтгаан нь хүлээн авагч улсыг гаалийн мэдүүлэгт буруу бичиж байсныг тогтоосон бөгөөд алдааг залруулах ажлын хэсгийг ГЕГ-ын даргын тушаалаар байгуулан Гашуунсухайт, Шивээхүрэн дэх гаалийн газруудад
--	--	--	--	--	--	--

						нүүрсний экспортын бүрдүүлэлт хийгдсэн 2022, 2023 оны гаалийн мэдүүлгүүдийг засварласан. Мөн цаашид нүүрсний экспортын гаалийн мэдүүлгийг нөхөн бичихдээ хүлээн авагч улсыг зөвхөн "БНХАУ" байх талаар чиглэл өгсөн албан тоот явуулсны үндсэн дээр 2024 онд энэ алдаа давтан гараагүй нь ач холбогдолтой ажил болсон. 2.Ханги гаалийн газарт өгсөн чиглэлийн дагуу тус гаалийн газар арга хэмжээ авч цахилгаан эрчим хүчний гаалийн бүрдүүлэлтийг 2024 оны 8 дугаар сараас эхлэн мэдүүлж эхэлсэн ба төсөвт 52.2 сая төгрөгийн татварыг оруулсан байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.
--	--	--	--	--	--	---

1.3	Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох	Үйл ажиллагаа	Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар	1-2.Гаалийн байгууллага эрсдэлийн дүн шинжилгээ хийж, хууль сахилтын түвшингээр үнэлж, 593 эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулж, программд оруулсан. Нийт 1416 эрсдэлийн шалгуурын үр дүнд тухайн шалгуурт баригдсан гаалийн бүрдүүлэлтийн бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээ экспортын гаалийн бүрдүүлэлтийн хувьд 22.7 хувиар, импортын гаалийн бүрдүүлэлтийн хувьд 9 хувиар нийт гаалийн бүрдүүлэлтэд бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 15.45%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.	1.Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг 30 хувиар нэмэгдүүлнэ. 2.Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг 65 хувьд хүргэнэ.	2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар нийт 1,169,113 гаалийн бүрдүүлэлт хийснээс бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 63% байна. Үүнээс: - Экспортын гаалийн бүрдүүлэлт: Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 88% болж, өмнөх оны мөн үеэс 4%-аар өссөн байна. - Импортын гаалийн бүрдүүлэлт: Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 18% байна. Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувийг суурь түвшинтэй харьцуулж үзвэл: 2020 онд 55.37%, 2021 онд 46.06%, 2022 онд 49.3%, 2023 онд 64.28%, 2024 онд 63.19% тус тус байна. Энэ нь 2020 оны суурь түвшнээс 7.82%-аар өссөн үзүүлэлттэй байна. Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ суурь түвшнээс өссөн ч дараах хүчин зүйлсээс шалтгаалж удаашралтай байна: -Эрх зүйн орчин: Гаалийн тухай хууль шинэчлэн батлагдаагүй; -Гаалийн лабораторийн дүгнэлт: Заавал шинжилгээнд хамрагдах барааны тоо ихэссэн; -Хорио цээрийн хяналт: Хорио цээрийн хяналтад хамрагдах барааны шаардлага; -Зөвшөөрөл, лицензийн асуудал: Хориглосон, хязгаарласан бараа, -ОАТ бараа; Төсвийн орлого бүрдүүлэх гэх зэрэг. Үнэлгээ: 73 хувь, тодорхой үр дүнд хүрсэн. ДХБ-ын Нарийн бичгийн даргын газарт хүргүүлэх 2021-2023 онд “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах үүрэг амлалт авсан 20, 2024 онд 2 арга хэмжээний хэрэгжилтийг хүргүүлснээр Монгол Улсын ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг болсон. ДГБ, НҮБ, Их түмэн санаачилгатай хамтран ажиллаж, 7.4 Эрсдэлийн удирдлага; 7.5 Бүрдүүлэлтийн дараах шалгалт; 10.9.1. Барааг түр хугацаагаар оруулах, барааг дотоодод болон гадаадад боловсруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах чадавхыг	70.75 хувь
-----	--	---------------	--	--	---	---	-------------------

						бэхжүүлсэн. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг бүрэн хангаж, биелэлтийг хүргүүлсэн. Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт 85.3 хувьтай байна. Үнэлгээ: 30 хувь, үр дүнгүй.	
				3.Гадаад худалдаа эрхлэгчийн хууль сахилтын түвшинг тодорхойлох загварыг боловсруулж, Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмын төсөлд оруулсан.	3.Аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.	Гаалийн харилцаанд оролцогчийн “Хууль сахилтыг тодорхойлох”-д хэрэглэх “3 бүлэг, 11 үзүүлэлт”-ийн алгоритмыг эксель программд тооцоолж иргэд, хуулийн этгээдийн хууль сахилтыг механикаар тодорхойлж байна. Энэхүү ажлыг цахимжуулах зорилгоор Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд “Хилийн хяналтын удирдлагын систем төсөл”-ийг автоматжуулах ГЕГ-ын ажлын хэсэг Интерактив компанитай хамтран ажиллаж байна. “Хилийн хяналтын удирдлагын систем төсөл”-ийн ажлын даалгаварт CAIS-ийн өгөдлийн сантай холбон “Хууль сахилтыг тодорхойлох”, “Эрсдэлийн профайл”-ыг системээр хийх шаардлагын тодорхойлолтыг гаргаж, эхний хөгжүүлэлтийг хийж тестлэх шатанд явагдаж байна. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
				4.Зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцож ажиллаж байна. Эрсдэлийн мэдээллийн санд 2023.11.30-аар 247 эрсдэлтэй зорчигч, 2022 онд 218 эрсдэлтэй зорчигч тус тус бүртгэгдсэн. Бүртгэсэн эрсдэлтэй зорчигчийн тоо нь өмнөх оны мөн	4. Бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд эрсдэл тооцох боломжийг судалсан байна. 4.Төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээллийг ашиглан эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэхийн тулд “Эрсдэлтэй	Бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд ОХУ-ын Гаалийн албанаас гаалийн мэдүүлэг, рентген зургийн мэдээллийг авч, гаалийн хяналтад ашиглаж байна. Гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үе шатыг эрчимжүүлэн ОХУ-ын гаалийн байгууллагатай мэдээлэл солилцох чиглэлээр Монгол Улсын ГЕГ болон ОХУ-ын гаалийн алба хоорондын Эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай хэлэлцээрийг зохион байгуулж ажилласан. Үр дүнд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын засгийн газар хоорондын комиссын 25 дугаар хуралдаан зохион байгуулагдсан. Тус хуралдаанаар ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал, ОХУ-ын Холбооны гаалийн албаны орлогч дарга В.В.Ивин нар “МУ-ын ГЕГ, Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба хоорондын “Эрсдэлийн удирдлагын	

				үетэй харьцуулахад 11.7 хувиар өссөн. Эрсдэлийн мэдээллийн санд гаалийн байгууллага эрсдэл тооцсоны үр дүнгээр 78.9%, бусад байгууллагын 21.1%-ийн мэдээллийн эх сурвалжид үндэслэн бүртгэсэн байна. Одоогоор төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээлэлд эрсдэл тооцох боломж бүрдээгүй байна.	зорчигчийг онилох систем"-ийн хөгжүүлэлтийг хийсэн байна.	хүрээнд хамтран ажиллах тухай хэлэлцээр” болон “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тус тус гарын үсэг зурсан. БНХАУ-тай манифест солилцон гаалийн хяналт шалгалтад ашиглаж байна. БНХАУ, Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын эрсдэлийн мэдээлэл солилцох, хамтран ажиллах хэлэлцээрийн төслийг боловсруулж, харилцан санал солилцсон. ОХУ-ын экспортын гаалийн мэдүүлэг болон БНХАУ-тай солилцох манифестийн мэдээллийг үр дүнтэй ашиглах программын хөгжүүлэлтийг БНСУ-ын (КОЙКА)-ийн буцалтгүй тусламжийн багаар хийлгэхээр болсон. БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-ийн буцалтгүй тусламжаар “Монгол улсын Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох, шинэчлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл” шалгарсан бөгөөд 2025-2028 онд хэрэгжихээр болсон. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Эрсдэлийн удирдлагын программын “Эрсдэлийн мессеж сан”-ын хөгжүүлэлтийг хийсний үр дүн харьяа гаалийн газар, хороод эрсдэл бүхий бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчийн мэдээллийг солилцох боломжтой болсон. Эрсдэлийн удирдлагын программын “Зорчигч онилох модуль”-ийн “Эрсдэлтэй зорчигчийн мэдээллийн сан”-г шалгалтын үр дүнгийн санал болон бусад эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн эрсдэлтэй байх магадлалтай 153 зорчигчийн мэдээллээр баяжуулсан. Агаарын тээврийн зорчигчийн мэдээллийг АПИС программаар урьдчилан авч эрсдэл тооцсон байдал: Шалгалтын үр дүнгээр зөрчил илрүүлэлт 12 байсан бол 2024 онд 88 болж, өссөн байна. ГЕГ,Зорчигчийн мэдээллийн төвтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ”-г 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан. Үүний үр дүнд: Зорчигчийн	
--	--	--	--	--	--	---	--

						мэдээллийн төвтэй ГЕГ мэдээлэл солилцох санамж бичгийн хүрээнд API болон PNR мэдээлэл солилцох боломж бүрдсэнтэй холбоотойгоор тухай мэдээллийг Кайс системд хөрвүүлэн ажиллуулах программыг нэвтрүүлснээр өөрсдөө эрсдэл тооцох боломж бүрдэх, бусад орны гаалийн байгууллагын ашигладаг программ хангамжийг авч API болон PNR мэдээлэлд ажиллах боломжийг бүрдүүлсэн. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
1.4	Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх арга зүйг боловсронгуй болгон, бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа, хувиар, Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	1.2019 оны Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна. "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа"-г 2023 онд хийсэн. 2.2019 онд хийгдсэн "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах судалгаа"-ны дүнтэй 2023 онд хийсэн судалгааг харьцуулж байна.	1.Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг хийж дуусгасан, тайлан гарсан байна. 2.2019 онтой харьцуулахад бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа 5 хувиар буурсан байна.	ГЕГ-ын дэд даргын 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгаа"-г хийж, 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр тайлангаа гаргаж танилцуулсан. Энэхүү судалгааны шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8%-аар бууруулсан дүн гарсан. -Импортын суудлын автомашины бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааг шалгах зорилгоор 807 суудлын автомашины бүрдүүлэлтийг сонгож, судлахад 2023 онд 70 минут зарцуулдаг байсан. ГЕГ-ын даргын 2024 оны А/533 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Суудлын автомашины гаалийн үнийг системээс шалгах түр заавар"-ыг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс мөрдөж, tableau програм ашиглан хянасанаар дээрх хугацааг 48 минут болгож, 31%-аар бууруулсан. -Барааг улсын хилээр оруулсанаас эхлээд эзэнд нь олгоход 2023 онд 1993 минут зарцуулж байсан бол 2024 онд гаалийн байгууллагын бичиг баримт шалгах хугацаа, хорио цээрийн шалгалтын хугацаа, мөн гадаад худалдаанд оролцогч нарын татвар төлөх хугацаа буурсантай холбоотойгоор 929 минут зарцуулж, дээрх хугацааг 53.3%-аар бууруулсан үзүүлэлт гарсан. -Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааны судалгаа, тайланг Tableau Software ашиглан тогтмол хяналт тавих санал боловсруулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна. -ДГБ-ын ITDM хөтөлбөрийн хүрээнд харьяа гаалийн	100 хувь

						газар, хороодын 40 албан хаагчдыг танхим болон цахимаар “Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт хийх судалгааны арга зүй” чиглэлээр 2024 оны 11 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд “Цаг хугацааны хэмжилт хийх судалгааны арга зүй”, “Хиймэл оюун ухаан, Tableau ашиглан бүрдүүлэлтийн цаг хугацааг хэмжих нь”, “Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт 2024” сэдвээр танилцуулга хийлээ. Мөн сургалтад оролцогчдоор өгсөн мэдээлэл, зөвлөмжид тулгуурлан өөр өөрийн харьяалах гаалийн газар, хороодын 2023-2024 онд хийсэн гаалийн бүрдүүлэлтийн мэдээллээс гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааны хэмжилт хийх практик дасгал хийлгэсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
1.5	Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг олон улсын стандартын дагуу бүрэн хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд байгуулсан “Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, Туршилт хийсэн болон шалгаруулсан аж ахуйн нэгжийн тоогоор	1. ОХУ-тай гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах арга суурь тавигдсан.	1.Гаалийн итгэмжлэлийг гадаад худалдаанд оролцогчдын бусад төрлөөр олгох ажлыг зохион байгуулсан байна. “Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр” байгуулах орны тоог 1-2-оор нэмэгдүүлэх саналыг хүргэж, бэлтгэл ажлыг хангасан байна.	1.ГИААН-ийг “Харилцан хүлээн зөвшөөрөх” чиглэлээр БНХАУ, БНСУ, ОХУ-ын Гаалийн байгууллага, АХБ, Төв Азийн Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Их түмэн санаачилгатай хамтран ажиллаж, 8 уулзалт, 1 сургалтыг зохион байгуулж, гадаад худалдаа эрхлэгч нарыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан. БНСУ-ын Гаалийн байгууллагын ГИААН хөтөлбөр хариуцсан нэгжийн албан хаагчидтай цахим хэлбэрээр уулзан, ГИААН-ийн мэдээллийг харилцан солилцон ажиллаж байна. Эхний ээлжид БНСУ-ын гаалийн байгууллагаас гурван ГИААН-ийн мэдээллийг Монгол Улсын гаалийн байгууллагад илгээж, Хэлэлцээрийг туршилтаар хэрэгжүүлж, үр дүнд үндэслэж 2 талаас албан ёсоор хэрэгжүүлэх хугацааг товллохоор тохиролцсон. Улаанбаатар хотноо 2023 онд зохион байгуулагдсан Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны 25 дугаар хуралдааны үеэр ГИААН-ийн ХХЗХ байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2 тал гарын үсэг зурсан. ОХУ-ын ХГА-ны Гаалийн хяналт бүрдүүлэлтийг зохион байгуулах төв газар, Гадаад хамтын ажиллагааны нэгжтэй 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр цахим уулзалт зохион байгуулсан. Энэхүү	75 хувь

					уулзалтаар 2 талын ГИААН хөтөлбөрийн талаар харилцан мэдээлэл солилцсон. Мөн Монголын гаалийн байгууллагын 3 төлөөлөгч 2024 оны 12 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд ОХУ-ын ГИААН хөтөлбөрт хамрагдах аж ахуйн нэгжийн өөрийн үнэлгээг үнэлж, баталгаажуулах туршлагаас газар дээрээс нь суралцсан. Европын холбоо Монгол Улсын худалдааг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэгч багтай хамтран ажиллаж, ИААН хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх техникийн туслалцаа авах саналаа хүргүүлсэн. Их түмэн санаачилгын Гаалийн дэд хорооны болон Худалдаа хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаан 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулагдсан. Тус хуралдаанд ГЕГ-аас “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн чадавхыг бэхжүүлэх” төслийг Монголын гаалийн байгууллагаас танилцуулсан. “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн чадавхыг бэхжүүлэх” төсөл нь Гаалийн дэд хорооны 2024-2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан. ОХУ-ын гаалийн байгууллага, Европын холбооны Монгол Улсын худалдааг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэгч баг, Их түмэн санаачилга зэрэг байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн хүрээг нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Үнэлгээ: 50 хувь, эрчимжүүлэх шаардлагатай.	
			2. ГЕГ-ын даргын 2021 оны А/118 тушаалаар батлагдсан “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох	2.Итгэмжлэгдсэн 1-2 аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна.	“Говь” ХК, “АПУ” ХК, “Ханбогд Кашимер” ХХК-д Гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулсан. Баталгаажуулалтын үр дүнд 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 09/02 дугаар шийдвэрээр тус аж ахуйн нэгжүүдийн экспорт, импортын үйл ажиллагаанд 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар гаалийн итгэмжлэл олгохоор шийдвэрлэсэн. Шийдвэрийн дагуу ГЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/661, А/662,	

				журам"-ын дагуу "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" төрийн өмчийн үйлдвэрийн газарт үйл ажиллагаанд 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр "Гаалийн итгэмжлэл" олгосон.		A/663 дугаар тушаалаар Гаалийн итгэмжлэл олгосон бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр ГИААН-ийн гэрчилгээг гардуулах арга хэмжээг зохион байгуулсан. ГИААН-үүдтэй "Хамтран ажиллах гэрээ" байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
1.6	Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүнийг зохицуулсан үйл ажиллагаа, гадаад худалдааны статистик мэдээллийг монгол, англи хэл дээр түгээх, гадаад худалдааны нэгдсэн портал бий болгох, хэрэглэгчдэд холбогдох мэдээллийг түргэн шуурхай, энгийн байдлаар хүргэх	Үйл ажиллагаа	Цахим хуудсаар лавлах цэгээр түгээсэн мэдээллийн тоо, Цахим хуудасны хандалтын тоо, Лавлах цэгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоо, хувиар, Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	1.Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр цахим хуудсаар дамжуулан түгээсэн.	1.Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр түгээсэн байна.	Тайлант хугацаанд https://customs.gov.mn -д дараах журмуудыг байршуулан санал авсан. 1.ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-ын төсөл, 2.ГЕГ-ын даргын 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн "Журам батлах тухай" 680 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Бараа устгах горим хэрэгжүүлэх журам"-ын төсөл, 3."Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам"-ын төсөл, 4.ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан "Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан төсөл, 5."Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам"-ын төсөл, 6."Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын төсөл. ГЕГ-аас 24 удаа давхардсан тоогоор 57 хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гаалийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, гаалийн улсын байцаагч нарын мэдээлэл, шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүний мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээсэн гадаад худалдаа, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын асуудлаар цахимаар түгээж, сурталчилсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	83.3 хувь

				2."E-Mongolia" системд "Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа /иргэн/"-г 2022 оны 11 дүгээр сард 6808 байсан бол 2023 оны 11 сарын байдлаар 19705 болсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 189 хувиар өссөн үзүүлэлт гарсан.	2.Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч /хандалт/, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.	Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл"-ийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 481 аж ахуйн нэгж, иргэн авсан хандалт хийсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1867 аж ахуйн нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1386 хэрэглэгчээр буюу 4 дахин өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: www.Gaali.mn Статистик цонхон дахь хандалтын тоогоор/ Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/ -ээс “Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа” авахаар 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 19934 аж ахуйн нэгж, иргэн хандсан бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 39754 аж ахуйн нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: И-Монголиа академи / Мөн гаалийн цахим үйлчилгээний системээр цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 96%-аар өссөн байна. <table><tr><th>№</th><th>Цахим лавлагаа</th><th>2023 он</th><th>2024 он</th></tr><tr><td>1</td><td>Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (ААН)</td><td>379</td><td>434</td></tr><tr><td>2</td><td>Гаалийн зөрчлийн лавлагаа (Иргэн)</td><td>94</td><td>171</td></tr><tr><td>3</td><td>Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (ААН)</td><td>7360</td><td>8223</td></tr><tr><td>4</td><td>Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (Иргэн)</td><td>293</td><td>379</td></tr><tr><td>5</td><td>Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (Иргэн)</td><td>1933</td><td>10674</td></tr><tr><td>6</td><td>Гаалийн зөрчлийн лавлагаа (ААН)</td><td>298</td><td>377</td></tr><tr><td colspan="2">Нийт</td><td>10357</td><td>20258</td></tr></table> Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	№	Цахим лавлагаа	2023 он	2024 он	1	Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (ААН)	379	434	2	Гаалийн зөрчлийн лавлагаа (Иргэн)	94	171	3	Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (ААН)	7360	8223	4	Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (Иргэн)	293	379	5	Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (Иргэн)	1933	10674	6	Гаалийн зөрчлийн лавлагаа (ААН)	298	377	Нийт		10357	20258
№	Цахим лавлагаа	2023 он	2024 он																																			
1	Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (ААН)	379	434																																			
2	Гаалийн зөрчлийн лавлагаа (Иргэн)	94	171																																			
3	Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (ААН)	7360	8223																																			
4	Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (Иргэн)	293	379																																			
5	Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (Иргэн)	1933	10674																																			
6	Гаалийн зөрчлийн лавлагаа (ААН)	298	377																																			
Нийт		10357	20258																																			

				3.Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын программын судалгааг хийж, программ хангамжийг боловсруулж, туршин бүрэн ашиглалтад оруулсан.	3.Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авдаг, хүргүүлдэг болсон байна.	Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авсан хэрэглэгчийн тоо өмнөх үеийн мөн үетэй харьцуулахад 44.4%-аар өссөн. <table><tr><td>Төрөл</td><td>2023 он</td><td>2024 он</td></tr><tr><td>Авто тээвэр</td><td>1463826</td><td>2405856</td></tr><tr><td>Агаар</td><td>6684</td><td>9319</td></tr><tr><td>Төмөр зам</td><td>20444</td><td>21181</td></tr><tr><td>Импорт манифе тодорхой үр дүнд хүрсэн. стын тоо</td><td>147797</td><td>181415</td></tr><tr><td>Транзит манифестын тоо</td><td>190601</td><td>197078</td></tr><tr><td>Дотоодын дамжин өнгөрүүлэх манифест</td><td>79080</td><td>151761</td></tr><tr><td>Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг</td><td>814080</td><td>952224</td></tr><tr><td>Автомашинны гаалийн мэдүүлэг</td><td>102103</td><td>161513</td></tr><tr><td>Нийт</td><td>2824615</td><td>4080347</td></tr></table> Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	Төрөл	2023 он	2024 он	Авто тээвэр	1463826	2405856	Агаар	6684	9319	Төмөр зам	20444	21181	Импорт манифе тодорхой үр дүнд хүрсэн. стын тоо	147797	181415	Транзит манифестын тоо	190601	197078	Дотоодын дамжин өнгөрүүлэх манифест	79080	151761	Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг	814080	952224	Автомашинны гаалийн мэдүүлэг	102103	161513	Нийт	2824615	4080347	
Төрөл	2023 он	2024 он																																			
Авто тээвэр	1463826	2405856																																			
Агаар	6684	9319																																			
Төмөр зам	20444	21181																																			
Импорт манифе тодорхой үр дүнд хүрсэн. стын тоо	147797	181415																																			
Транзит манифестын тоо	190601	197078																																			
Дотоодын дамжин өнгөрүүлэх манифест	79080	151761																																			
Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг	814080	952224																																			
Автомашинны гаалийн мэдүүлэг	102103	161513																																			
Нийт	2824615	4080347																																			
			4.Гадаад худалдааны нэгдсэн порталд оруулах үйл ажиллагаа жигдрэн, хэрэглэгчид монгол, англи хэл дээр мэдээлэл хүлээн авах боломжтой болсон.	4.Гадаад худалдааны порталд “Автомат хариулагч”-аар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлсэн байна.	Утасны дуудлагын тоог багасгах, гадаад худалдаа эрхлэгчдийг мэдээллээр хангахын тулд гаалийн холбогдолтой асуултад хариулт өгөх хиймэл оюун ухаанд суурилсан чатботыг хөгжүүлж эхэлсэн. Энэ чатбот нь урьдчилан бэлтгэсэн текст, асуулт, хариултаар OpenAI, API-г ашиглан хэрэглэгчдийн асуултад хариулт өгөх систем юм. Гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээр, мэдээллийн технологийн чиглэлээр байнгын давтамжтай ирдэг асуултуудыг гаргаж, хариулт бэлтгэн модель сургалт хийсэн. Чатботын туршилтын хувилбарыг 2024 оны 09 дүгээр сард гарган туршиж эхэлсэн бөгөөд өмнө нь бэлтгэсэн асуултуудын хариултын чанарыг сайжруулах чиглэлээр дахин модель сургалт хийж хөгжүүлж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.																																
			5.Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа	5.Гаалийн байгууллагаас олгож буй	-Гаалийн байгууллагаас “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-тай хамтран ГЕГ-аас олгож байгаа 6 төрлийн тусгай, 1 төрлийн энгийн																																

				эрхлэх зөвшөөрөл, түр агуулах ажиллуулах зөвшөөрөл, гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог итгэмжлэл авах ААН-ийн хүсэлтийг тусгай зөвшөөрлийн цахим систем license.mn-ээр хүлээн авч шийдвэрлэж байна. ОУАТХ-ны программ хангамжийн багтай 2023.12.04-ний өдөр цахимаар холбогдож, хоёр талын хугацаа нь дууссан эрх /certificate/-ийг 2023 оны 12 дугаар сард багтаан нээж, мэдээлэл солилцож эхлэхээр тохирсон.	Гаалийн түр агуулах ажиллуулах зөвшөөрөл, ТИР горимоор тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл олгох, Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн бүртгэлд бүртгэх, Экспортлогч, импортлогч аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох зөвшөөрлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлснээр аж ахуйн нэгжээс гаалийн байгууллагад гаргасан хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, олгох явцыг ил тодорхой болгож, хяналтыг сайжруулна.	зөвшөөрөл болон гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл шинээр авах болон сунгуулах хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна. Тусгай зөвшөөрлийн license.mn-ээр 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хооронд шинээр ирүүлсэн 121, хугацаа сунгуулах 67 буюу нийт 188 хүсэлтийг хүлээн авч, 139 хүсэлтийг шийдвэрлэсэн ба 49 хүсэлтийг хянаж байна. Тусгай зөвшөөрлийн license.mn-ээр дээр дурдсан хүсэлтийг цахимаар хүлээн авч хянаж, шийдвэрлэснээр аж ахуйн нэгжүүд цаг хугацаа, орон зайнаас хамаарахгүйгээр хүсэлтээ тусгай зөвшөөрлийн цахим системийг ашиглан илгээх мөн хүсэлтийг нь гаалийн байгууллагын албан хаагч нар хүлээн аваад хянаж, шийдвэрлэх бүх үйл явцыг цахимаар харах боломжтой болсон. -Олон улсын авто тээврийн холбоо /IRU/-ны зөвлөх Вахтанг Зарандиятай 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр уулзаж тохиролцсоны дагуу 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн IRU-тай TIR-EPD-ийн 6 элементийг туршиж, гаалийн байгууллагын автоматжуулсан системд /CAIS/ нэмэлт үйлдлүүдийг хийсэн. Тус ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд Алтанбулаг, Замын-Үүд боомтод ажиллаж CAIS-д ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбох туршилтыг хийж, 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр амжилттай нэвтрүүлсэн. -Оюуны өмчийн эрхэд хамаарах барааны хяналтыг сайжруулах зорилгоор дээрх барааг бүртгүүлэх хүсэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс gaali.mn-ээр хүлээж аваад Sims-т бүртгэдэг болгосон. Өнөөдрийн байдлаар CAIS-д дээрх мэдээллийг татаж, гаалийн хяналтад ашиглуулах, мөн бүртгүүлэх хүсэлт илгээхэд өмнө нь гаальд бүртгэгдсэн барааны мэдээллийг хардаг болгох хөгжүүлэлтийг хийхээр ажиллаж байна. Уг программыг туршилт хийсний дараа нэвтрүүлэхээр төлөвлөж байна. -Экспортлогч, импортлогч ААН-д гаалийн итгэмжлэл	
--	--	--	--	---	--	--	--

					олгох зөвшөөрлийн программд дараах засвар өөрчлөлтийг хийсэн. - Cims.gaali.mn системийн ИААН-ийн программд ажлын байрны шалгалтын үнэлгээ өгөх модуль, нэмэлт шаардлагатай засвар өөрчлөлтийг оруулсан. - Шалгуур үзүүлэлтэд нэмэлтээр файл хавсаргах боломжтой болгох; - ААН шалгуур үзүүлэлтийн файл оруулах хэсэгт 1 файл оруулдаг байсныг олон файл оруулах боломжтой болгосон; - ИААН-г хянан шалгаж буй гаалийн улсын байцаагч нь шаардлагатай файлыг нэмэлтээр ААН-ээс авч, бүртгэлийн мэдээллийг буцаах шаардлагагүйгээр шууд хавсаргах боломжийг бүрдүүлэх; Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			6. Тусгай зөвшөөрлийн цахим системд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өөрийн үнэлгээний хуудсыг нэвтрүүлэх ажлын даалгавар болон Гаалийн зөрчилтэй эсэх лавлагаа, Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн эсэх лавлагааны маягтын загваруудыг боловсруулж хүргүүлсэн. “Өөрийн үнэлгээний хуудас”-ыг цахимд нэвтрүүлэх ажлыг бодит орчинд	6.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний “Өөрийн үнэлгээний хуудас”-ыг тусгай зөвшөөрлийн цахим системд амжилттай нэвтрүүлж, 2023 оны сүүлийн хагас жилээр 270, 2024 оны эхний хагас жилээр 345 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнийг дүгнэж ажилласан. Өөрийн үнэлгээний хуудсаар 7 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд хугацаатай үүрэг даалгавар өгч, дахин үнэлсэн. Дахин үнэлгээгээр 90-ээс доош үнэлгээ авсан 1 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг хүчингүй болгосон. 2019 онд гаалийн байгууллагаас “Гаалийн зуучлагчийн стандарт”-ыг боловсруулж, Стандартчилал хэмжил зүйн газарт хүргүүлж байсан ч тухайн үед стандартыг танайхаас боловсруулахгүй гэдэг хариуг ирүүлсэн. ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын шинэчлэн найруулсан журмын төслийн 3 дугаар зүйлд гаалийн зуучлагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд тавигдах шаардлагын талаар дэлгэрэнгүй тусгаж, оруулсан бөгөөд ГЕГ-ын даргын тушаалаар батлуулахад бэлэн болсон. Үнэлгээ: 0 хувь, үр дүнгүй.	

				нэвтрүүлэхэд бэлэн болгож, туршилтыг хийсэн.			
1.7	Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/184 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт албан хаагч нар ажиллаж байна. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэгжээс "Цахим нэг цонхны систем"-ийг бий болгоход удирдаж явах болон цаашид дараа авч явах агентлагийг сонгох ажил хүлээгдэж байгаа. Цахим нэг цонх бий болоогүй байна.	"Цахим нэг цонхны систем"-тэй гаалийн байгууллагын үйл ажиллагааг холбох туршилтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.	Нэг. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/138 дугаар тушаалаар байгуулагдсан МУ-ын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт гаалийн байгууллагын төлөөлөл ажиллаж байна. "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийг хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан хугацааг шинэчилж, үйл ажиллагаа нь зохион байгуулагдана. Төслийн нэгжээс "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системд оролцогч 19 байгууллагын 40 албан хаагчийг оролцуулсан 2024 оны 03 дугаар сарын 21, 25, 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан уулзалтуудад тус тус оролцож, гаалийн байгууллагаас холбогдох мэдээллүүдийг хүргүүлсэн. "Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" МУ-ын Засгийн газрын 178 дугаар тогтоолын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр ГЕГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх төлөвлөгөөний 2024 оны 1 дүгээр сар, 3 дугаар сар, хагас жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан 14 арга хэмжээний биелэлтийг 01/1638, 2769, 4114 дугаартай албан бичгийн хавсралтаар ЭЗХЯ-ны ТНБД-д хүргүүлсэн. Энэ тогтоолын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд: 1.Засгийн газрын Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023 оны 178 дугаар тогтоолын 1.1."Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн	100 хувь

					системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээг ЦХХХЯ-тай хамтран хэрэгжүүлэхийг МУ-ын Шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайд, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, ГЕГ-т даалгасны дагуу дээрх тогтоолын 1.1, 1.4, 3.1-р заалтын биелэлтийг сар бүр тогтмол гаргаж хүргүүлэн ажиллаж байна. 2.Сангийн яаманд хүргүүлэх Засгийн газрын 178 дугаар тогтоолын 1.1, 1.4, 3.1 дүгээр заалтын биелэлтийг сар бүр тогтмол гаргаж, холбогдох нэгжид хүргүүлэн ажилласан. 3.Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан CEPS, CAIS-д системд нэмэлт хөгжүүлэлт хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг E-mongolia болон эмийн бүртгэл, мэдээллийн Licemed системээс цахимаар татаж, гаалийн бүрдүүлэлт хийдэг болгосон. 4.Онцгой албан татвартай барааны хяналтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрөл, онцгой албан татварын тэмдэгтэй холбоотой мэдээллийг ХХААХҮЯ, Татварын Ерөнхий газартай солилцох системийн хөгжүүлэлтийг хийж байна. Үүний үр дүнд гадаад худалдаанд оролцогч нар согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг цаасаар гаалийн байгууллагад гаргаж өгөх шаардлагагүй болж, бүрдүүлэх бичиг баримтын тоо багасна. 5.Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан, ашигласан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг цахимжуулан, КАИС-т холбож, мэдээлэл солилцох системийн туршилтыг 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэвтрүүлэхээр БОУАӨЯ-ны ОУА-тай хамтран ажиллаж байна. Хоёр. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйн биржээс хэрэгжүүлж буй цахим нэг цонхны систем /export.mofa.gov.mn/-д	
--	--	--	--	--	---	--

					гаалийн хорио цээрийн arqs.gaali.mn системийг холбож ААН-ийн экспортод зарцуулах цаг, хугацааг багасгасан. БНХАУ-ын ГЕГ-тай мах, махан бүтээгдэхүүний экспортын мэдээг Нэг цонхны үйлчилгээний хүрээнд цахимаар солилцож хамтран ажилласан. Гадаад худалдааны нэг цонхны системийг бий болгох хүрээнд ДХБ-ын Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний хэлэлцээр (SPS)-ийн хэрэгжилтийг хангаж, БНСУ-ын ХХААЯ-тай “Чөлөөт худалдааны гэрээ”-г байгуулах ажлын хэсгийн ээлжит хурлыг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Гэрээний зорилго нь худалдааны урсгалыг жигд, үр ашигтай явуулахын тулд тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг бууруулах, худалдааг хөнгөвчлөх, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх хоёр талын хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан ашигтай эдийн засгийн түншлэлээ өргөжүүлэн хөгжүүлэх, хоёр орны бизнес эрхлэгчид, иргэдэд шинэ боломжуудыг бий болгоход чиглэгдсэн. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд орсон 2023 оны өөрчлөлтийн дагуу 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн e-phytosanitary болон мал эмнэлгийн цахим экспортын гэрчилгээг хөрш зэргэлдээ улсуудтай тохирох асуудал нь Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шилжсэн. Үүнтэй холбогдуулан тус яамнаас “Цахим нэг цонх систем”-д гэрчилгээ, мэдэгдлийн холболтуудыг хийсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй Хөдөө аж ахуйн биржтэй хамтран төрийн болон төрийн бус байгууллагын экспортын нэг цонхны систем /Export.mofa.gov.mn-д гаалийн хорио цээрийн системийн холболтын үйл ажиллагааг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэн гаалийн хорио цээрийн Caps.gaali.mn системийг холбож ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсээс олгож буй “Экспорт, импорт хорио цээрийн гэрчилгээ,	
--	--	--	--	--	--	--

						мэдэгдлийн систем”, “Экспортын нэг цонхны систем”-тэй уялдуулан шинэчлэгдэж, ААН-ийн экспортод зарцуулах цаг, хугацааг багассан. Export.mofa.gov.mn цахим нэгдсэн системээр итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож гаалийн мэдээллийн систем рүү дамжуулан мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ 2-4 цаг, өдөртөө шийдвэрлэгдэж ажилласан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх							
2.1	Шуурхай хяналтын төвийг гаалийн хяналт, шалгалтад үр бүтээлтэй ашиглах	Үйл ажиллагаа	Зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нэгдсэн системийг ашиглан илрүүлсэн зөрчлийн тоо, хэрэгжилт, хувиар	1.Телехяналтын нэгдсэн системийг ашиглан, мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, зөвлөмж мэдээллээр ханган ажилласнаар, гаальд мэдүүлсэн барааны нэр төрөл, тоо хэмжээ зөрүүтэй 58 зөрчил илэрсэн тул зөрчлийн арга хэмжээгээр 454,713,822.26 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 241,006,480.34 төгрөгийн торгууль ногдуулан төлүүлсэн.	1.Шуурхай хяналтын төвийг ашиглан гаалийн хяналт шалгалтад эрсдэл тооцож, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оныхоос 3 хувиар өссөн байна.	Шуурхай хяналтын төв нь гаалийн автоматжуулсан мэдээллийн систем CAIS-д мэдүүлсэн бараа тээврийн хэрэгслийн бодит цагийн өгөгдөл, рентген төхөөрөмжөөс өгөгдсөн мэдээлэлд Табльдэ дата аналитик программ болон Телехяналтын нэгдсэн системийг ашиглан дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож, CAIS-ийн онилгооны программаар тайлант хугацаанд 112 зөвлөмжийг гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үе шатанд илгээсэн байна. Үүнээс 87 буюу 77.68% -д нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлэх шаардлагатай хориглосон, хязгаарласан барааг хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг тус тус илрүүлсэн. Тайлант хугацааны үр дүнг 2023 оны мөн үетэй харьцуулахад: Зөвлөмжийн оновчтой байдал буюу Шуурхай хяналтын төвийг ашиглан илрүүлсэн зөрчлийн тоо 5.18%-аар өссөн үзүүлэлттэй байна. Зөвлөмжийн дагуу илрүүлсэн 87 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.21 дүгээр зүйлийн 1.1, 1.2 заалтын дагуу арга хэмжээ авагдаж, 510.77 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 246.57 сая төгрөгийн торгууль ногдуулан төлүүлсэн нь өмнөх оноос нөхөн төлүүлсэн татварын дүн 12.3%-аар, торгуулийн дүн 2.3 %-аар тус тус өссөн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	100 хувь
				2.Гаалийн	2.Төрийн бусад	АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн 06/10415,	

				телехяналтын нэгдсэн системийг ашиглан төрийн бусад байгууллагуудтай хамтран хууль сахиулах үйл ажиллагаанд 7 удаа оролцож, хамтран ажилласан байна.	байгууллагуудтай хамтран хууль сахиулах үйл ажиллагаанд телехяналтын нэгдсэн системийг ашиглан үр бүтээлтэй ашигласан байдал өмнөх оныхоос 3 хувиар өссөн байна.	06/11363, ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албанаас ирүүлсэн 14-5/840, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн 01/5152 дугаартай албан бичгүүдээр хууль сахиулах ажиллагааны хүрээнд нотлох баримт бэхжүүлэх хүсэлтийн дагуу Телехяналтын нэгдсэн системийн өгөгдлийн сангаас улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн холбогдох бичлэгийг хуулбарлан баримтжуулж 4 удаагийн албан бичгээр хариу хүргүүлсэн. Мөн Зөрчилтэй тэмцэх газраар дамжуулан бусад төрийн байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу бичлэгийг хуулбарлан баримтжуулан 4 удаа хүргүүлж хууль сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 14%-аар өссөн үзүүлэлттэй байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
2.2	Дэлхийн худалдааны байгууллагын “Гаалийн үнэлгээний хэлэлцээр” болон гаалийн үнэлгээтэй холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.ГЕГ-ын даргын 2012 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан “Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох заавар”-ын төслийг боловсруулсан боловч бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэн хийдэг болсонтой холбоотойгоор төслийг шинэчлэх шаардлага гарсан.	1.Эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах, гаалийн үнийн хяналтын тогтолцоонд шинэ хандлага төлөвшүүлсэн байна.	1.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат, Эрээн хотуудын зах зээлийн үнийн судалгаа хийх, бодит байдалтай танилцах зорилгоор ГЕГ-ын даргын тушаалаар 2024 оны 05 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, Бүрдүүлэлтийн цахим төв, Замын-Үүд дэх гаалийн газрын бүрдүүлэлт, үнэлгээний асуудал хариуцсан албан хаагч нар болон МҮХАТ-ийн төлөөлөгчийн хамт үнийн судалгааг хийж, дараах үр дүн гарсан. Үүнд: -Эрээн хотын барилгын захуудаар улирлын чанартай үнэ хэлбэлздэг барилгын материалын үнийн судалгааг хийж, нэгтгэн хянаж, 88 барааны үнийг шинэчлэн CAIS системийн “хил орчмын үнийн судалгаа” хэсэгт 0320240300002 дугаартай хавтсанд байршуулан, 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн үнийн хяналтын зорилгоор ашиглаж байна. Хил орчмын үнийн судалгааны үнээр нийт 110,035 барааны гаалийн үнийг тодорхойлсон бөгөөд нэмж төлүүлсэн татварын зөрүү 21.8 тэрбум төгрөг байна. Судалгааны ажлын явцад гаалийн үнийн хяналт тавих, мэдээлэл солилцох дараах боломжийг бүрдүүлсэн. Үүнд: -БНХАУ-ын Бээжин хотын Lange Cloud Business Technology Co.,Ltd компанитай холбогдож төмрийн	100 хувь

					нээлттэй биржийн цахим хуудас www.lgmi.com-т хандах 1 жилийн албан ёсны эрхийг авч, үнийн хяналтын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлсэн. Тус сайтаас төмрийн өдөр бүрийн үнийн мэдээллийг хотуудаар болон 6 сар, 1 жилээр харах, мөн тээврийн зардлыг тээврийн төрөл бүрээр харах боломжтой. Цаашид сайтад хандах эрхийн санхүүгийн асуудлыг жил бүрийн гаалийн байгууллагын төсөвт оруулан батлуулах ажлыг хэвшүүлснээр гаалийн үнэлгээний гомдлын ихэнх хувийг эзэлдэг төмрийн өдөр тутмын үнийн мэдээллийг харах боломжтой болж, үнийн хяналт сайжирна. -Бугатын төмрийн үйлдвэр болон “Norinco group”-ийн хүнд машин механизмын үйлдвэр, Beiben Truck-ийн гадаад харилцаа борлуулалт хариуцсан нэгжийн удирдлага, албан хаагч нартай уулзсан бөгөөд цаашид үнийн хяналтын зорилгоор тухай бүр үнийн мэдээлэл авах холбоо барих боломжийг бүрдүүлсэн. 2.Япон улсад экспортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн хуучин автомашины марк, арлын дугаар болон гаалийн үнийн мэдээллийг цахимаар ирүүлэх боломжтой эсэх, мөн биржээр арилжаалагдаж байгаа автомашины үнийн болон холбоотой мэдээллийг хэрхэн авах талаар зөвлөгөө авах хүсэлтийг Япон улсын гаалийн байгууллагад цахимаар хүргүүлсэн. Япон улсын гаалийн байгууллагаас цахимаар хариу ирүүлэхдээ гаалийн үнийн мэдээллийг ирүүлэх боломжгүй талаар дурдаж, статистик мэдээллийн вэбсайтын хаягыг ирүүлсэн. Япон улсад дуудлага худалдаагаар арилжаалсан хуучин тээврийн хэрэгслийн мэдээллийг харах боломжтой сайтуудын талаар холбогдох мэдээллийг судалсны үндсэн дээр ОХУ-ын aleado.ru цахим хаягийн Монгол дахь төлөөлөгчид албан бичгээр хандсаны дагуу Алеадо ХХК-ийн гүйцэтгэх захирал Бороков И.В-аас 20241115/11 албан бичгээр хариу мэдээлэл ирүүлсэн. Тус компанийн төлөөлөгч М.Жаргалсайхантай 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр албан уулзалтыг хийсэн. Уулзалтаар тухайн сайтын талаар тодорхой мэдээлэл авсан бөгөөд бусад орнуудтай хэрхэн хамтарч ажилладаг талаар	
--	--	--	--	--	--	--

					болон сайтын эрхийн үнийн саналыг албажуулан ирүүлэхээр болсон. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				2.Харьяа гаалийн 18 газар, хороодын бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэн хийдэг болсон.	2.“Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна.	Зарим нэр төрлийн импортын суудлын автомашинд бичиг баримтын гаалийн бүрдүүлэлт хийхэд тухайн иргэн, ААН-ийн хэлцлийн үнийг үндэслэн Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем CAIS-с гаалийн үнийг автоматаар хянах программыг нэвтрүүлэх, “Автомашины гаалийн үнийг системээс шалгах түр заавар”-ыг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн ээлжит 5 дугаар хурлаар хэлэлцүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу дараах арга хэмжээг авсан. Үүнд: -Гаалийн үнийн судалгааг Toyota, Prius автомашины сүүлийн 3 сарын хугацаанд 400 горимын, 110 хэлцлийн кодтой, дуудлага худалдааны бичиг баримттай, эвдрэлгүй байх нөхцөлийг хангасан, хэлцлийн үнийн аргаар үнэлсэн гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг үндэслэн, барааны гарал үүслийн улс, илгээгч улс, үйлдвэрлэгч, марк, кузовын төрөл, хөдөлгүүрийн төрөл болон багтаамж, үйлдвэрлэсэн он, БТКУС-ийн ангиллын код гэсэн үзүүлэлтээр гаалийн үнэ, тээврийн зардал, нэмэгдэх зардлыг тооцон гаргаж, гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн "Автомашин өөрөө үнэлэх жагсаалт" цэсэд нийт 69 үнийн мэдээллийг оруулж, баталгаажуулсан. -“Автомашины гаалийн үнийг системээс автоматаар хянах түр заавар”-ыг ГЕГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/533 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. -Программыг 3 сарын хугацаатайгаар 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн туршилтаар нэвтрүүлсэн. Дараах үрр дүн гарсан: -2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ний өдрүүдэд Япон улсаас импортолсон, улаан төлөвт сонгогдсон нийт 7507 мэдүүлгийн 48%-ийг системээс автоматаар шалгаж, бичиг баримтын шалгалт хийгдсэн. -Урьдчилан оруулсан шалгуур үзүүлэлтийг тооцож

					системээс автоматаар шалгасан мэдүүлэг бичиг баримтын шалгалт дууссан төлөвт орох хугацаа 0 минут болсон, -Ажлын 1 өдөрт 1 гаалийн улсын байцаагчид 46 бүрдүүлэлт ногдож байгаа бөгөөд 1 өдөрт 150 мэдүүлгийг системээс автоматаар шалгасан нь 3 бичиг баримтын гаалийн улсын байцаагчийн ажилтай тэнцүү буюу 3 бичиг баримтын гаалийн улсын байцаагчийн ажлыг хэмнэсэн байна. -Мэдээ тайлан гаргах зорилгоор CAIS программд нэмэлт цэс гаргаж, дүн шинжилгээ хийж, өдөр тутмын хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. “Автомашины гаалийн үнийг системээс автоматаар хянах түр заавар”, Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем CAIS-аас гаалийн үнийг шалгах програмын хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, “Зарим барааны гаалийн үнийг системээс шалгах заавар”-ыг ГЕГ-ын даргын тушаалаар батлуулсан. Мөн ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-д 2 заалт, ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”-т 4 заалт, ГЕГ-ын даргын 2012 оны А/30 дугаар тушаал батлагдсан “Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох заавар”-т 8 заалт нэмж оруулах тушаалын төсөл боловсруулсан. Биржээр арилжаалагдаж байгаа экспортын эрдэс баялгийн бүтээгдэхүүний судалгааг хийж, CAIS-д “гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим”-той /горимын код /, БТКУС-ийн Зүйл 2701, 2702 кодоод хамаарах, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, 2601 кодоод хамаарах төмрийн хүдэр, төмрийн баяжмалын гаалийн бүрдүүлэлтэд “биржийн гэрээ”-тэй гэж мэдүүлсэн тохиолдолд бичиг баримтын байцаагч хуваарилагдахгүй, мэдүүлэг бичиг
--	--	--	--	--	--

						баримтын шалгалт хийгдсэн төлөвт ордог байх программын даалгаврыг боловсруулсан ба 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
2.3	Гаалийн зөрчлийн мэдээллийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлэх	Үйл ажиллагаа	Мэдээлэлд дүн шинжилгээ хийж илрүүлсэн зөрчлийн тоо, хувиар, Илрүүлж, шийдвэрлэсэн нийт зөрчилд нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүн тоо, хувиар	1.Мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийж, эрсдэл тооцон онилгоо хийж илрүүлсэн зөрчлийн тоо 42.	1.Мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийж, илрүүлсэн зөрчлийн тоог өмнөх оныхоос 3 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.	Харьяа гаалийн газар, хороодод хийгдэж буй гаалийн бүрдүүлэлтэд зөрчилд холбогдсон барааны бүтэц, татвараас зайлсхийх зөрчилд хийсэн судалгаа, дүн шинжилгээ, гомдол, мэдээлэлд тулгуурлан 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар “татвар төлсөн”, “гааль зөвшөөрөв” төлөвт нийт 36 удаагийн онилгоог хийж, онилгооны мөрөөр харьяа гаалийн газар, хороодод дахин шалгалтыг зохион байгуулж, үр дүнг ирүүлэх чиглэлийг 03.15-ны 01-2/977, 03.25-ны 01-2/1115, 03.26-ны 01-2.1/1136, 03.27-ны 01-2.1/1153, 03.26-ны 01-2.1/1143, 04.04-ний 01-2.1/1293, 05.01-ны 01-2/1695, 05.03-ны 01-2/1762, 05.06-ны 01-2/1787, 05.10-ны 01-2/1886, 06.05-ны 01-2/2277, 07.02-ны 01-2/2707, 08.28-ны 01-2/3444, 08.30-ны 01-2.1/3464, 09.16-ны 01-2/3745, 09.20-ны 01-2/3833, 10.01-ний 01-2/3982, 01-2/3983, 01-2/3984, 10.22-ны 01-2/4329, 01-2/4326,10.24-ний 01-2/4365, 11.12-ны 01-2/4696, 01-2/4697, 11.19-ний 01-2/4801 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн. -Карго ачаанд хар тамхи, мансууруулах бодисыг нуувч болгон ашиглаж улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдаж байж болзошгүй гэж үзэн БНТУ-аас сүүлийн 3 жилд импортолсон барааны гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж түүний үр дүнд Улаанбаатар хот дахь гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газар, Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын зөрчилтэй тэмцэх албыг мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажиллаж 2024 оны 06, 07, 08, 10-р саруудад 4 удаагийн онилгоо дахин шалгалтыг хийсэн. Үүний үр дүнд гаалийн болон бусад татвараас зайлсхийсэн 4, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчсөн 1, эмнэлгийн хэрэгсэл хууль бусаар нэвтрүүлсэн 1 зөрчил тус тус илрүүлсэн. Мөн гаалийн хяналтын улбар шар төлөвтэй бүрдүүлэлтэд дахин шалгалтад 4 удаа хийж, үүнээс 3 бүрдүүлэлтэд	95 хувь

					зөрчил илэрсэн бөгөөд нийт улбар шар төлөвт сонгогдсон гаалийн бүрдүүлэлт, түүнээс зөрчилд холбогдсон ААН-ийн гаалийн бүрдүүлэлтийн давтамж, мэдүүлсэн барааны онцлог, итгэмжлэгдсэн төлөөлөгч зэрэг үзүүлэлтээр судалгаа хийгдэж байна. -“Гааль зөвшөөрөв” “татвар төлсөн” төлөвт хийсэн дахин шалгалтаар гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн 31 зөрчил илрүүлж 291.5 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 145.7 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчлийн тоо 16.6%-иар буурч, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн тус тус 70.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ онд дахин шалгалтын тоо буурсан нь өнгөрсөн 2023 онд хууль бус барааны эргэлт, худалдааны луйвар, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ГЕГ-ын хэмжээнд Төв болон бусад арга хэмжээг зохион байгуулснаар илрүүлсэн зөрчлийн тоо өссөнтэй холбоотой. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
			2.Гаалийн байгууллагын хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 2050 зөрчил илрүүлснээс: -1981 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, -35 зөрчлийн хэрэг бүртгэл хийж, -34 гэмт хэргийн шинжтэй хэрэг харьяалал тогтоолгож шалгуулахаар прокурорт шилжүүлсэн.	2.Эрүүгийн хэргийн тоо, мөн зөрчлийн хэргийн нөхөн төлбөрийн дүн, зөрчлийн тоог суурь түвшингээс тус бүр 5-аас дээш хувиар нэмэгдүүлсэн байна.	Гаалийн байгууллагын хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2306 зөрчил илрүүлж 5093.5 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 3511.4 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулж, 18.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 3026.6 сая төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн шинжтэй үйлдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна. Үүнээс: - 2209 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, 4678.2 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 3277.1 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан. - 42 зөрчлийн хэрэг бүртгэлт хийж, 415.3 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 234.2 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан. - 55 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Илрүүлэн шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.11%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс:	

				Зөрчлийн улмаас 5 тэрбум 304.46 сая төгрөгийн торгууль ногдуулж, 9 тэрбум 373.12 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, гэмт хэргийн шинжтэй хэрэгт хойшлуулшгүй ажиллагаа явуулж 550.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий барааг хууль хяналтын байгууллагад түр хураах баримт үйлдэж шилжүүлсэн байна		- Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.17 %-аар өссөн бол торгуулийн дүн 31.4 хувиар, нөхөн төлүүлсэн татварын дүн 44.9 %-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. - Зөрчлийн хэрэг бүртгэлт 35.5 %-аар, торгуулийн дүн 123.9 %-аар, нөхөн төлүүлсэн татварын дүн 142.1 %-аар өссөн үзүүлэлттэй байна. - Гэмт хэргийн шинжтэй 55 үйлдэл илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 61.76 %-аар өссөн үзүүлэлттэй байна. Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчлийн улмаас ногдуулсан торгуулийн дүн, нөхөн төлүүлсэн татварын дүн буурсан шалтгаан нь Прокурорын байгууллагын шийдвэрээр Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.1."их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно гэсний дагуу 50 сая төгрөгөөс дээш хохирлын дүнтэй бүрдүүлэлтийн дараах шалгалтаар илрүүлсэн зөрчлийг эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаатай холбоотой. Харин гэмт хэргийн шинжтэй үйлдлийн илрүүлэлт өссөн нь гаалийн байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлж, гэмт явдалтай тэмцэх ажил үр дүнтэй оновчтой зохион байгуулагдаж байгаагийн илрэл юм. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
2.4	Гаалийн харилцаанд оролцогчдын хууль сахилтын түвшинг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах	Үйл ажиллагаа	Гүйцэтгэл, нэгжээр, Зөрчлийн тоо, хувиар	1.Гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн зөрчлийн судалгааг хийж, Төв-1, Төв-2 арга хэмжээ зохион байгуулсан.	1.Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчилд ихээр өртдөг эд зүйлсийг судалгааны үндсэн дээр тодорхойлно.	Улсын хилээр бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлэх зөрчил, гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх зөрчилд холбогдсон бараа, эд зүйлсийн судалгаа, дүн шинжилгээг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын байдлаар буюу сүүлийн 3 жилийн байдлаар хийж, судалгааны дүнг албан хаагчдад танилцуулж мэдээллээр хангах, гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээллийг гаалийн харилцаанд оролцогчдод түгээх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	100 хувь

					чиглэлийг 01-2/1732 албан бичгээр харьяа гаалийн газар, хороодод хүргүүлж, CAIS системийн зөрчлийн программд бүртгэгдсэн мэдээлэл болон харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн дүн шинжилгээнд тулгуурлан улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчилд ихээр өртдөг эд зүйлсийг тодорхойлсон. Судалгаанд хамруулсан зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг харахад улсын хилээр эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх төрлийн 1150 зөрчил илрүүлэн шийдвэрлэснээс 992 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, 74 зөрчил хэрэг бүртгэлтийн ажиллагаа хийж, 84 гэмт хэргийн шинжтэй зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Нийт зөрчлийн 35.1 хувийг Замын-Үүд дэх гаалийн газар, 21.21 хувийг Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, 16.34 хувийг Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газар, 11.73 хувийг Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, 15.59 хувийг бусад гаалийн газарт илрүүлэн шийдвэрлэсэн ба зөрчилд холбогдсон барааны нэр төрлийн хувьд гаалийн газар, хороо бүрт өөр өөр байгаа нь тухайн орон нутаг, хил залгаа хөрш орны онцлогоос хамаарч байна. Замын-Үүд дэх гаалийн газарт гэмт хэргийн шинжтэй болон зөрчлийн шинжтэй үйлдэлд холбогдсон бараа нь: Экспортын чиглэлд: -Ховордсон ан амьтны эд эрхтэн, алт, түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн/сархинаг, өлөн, дотор гэдэс/, малын мах, байгалийн чулуу, сум гэх мэт Импортын чиглэлд: -Согтууруулах ундааны зүйлс, эм, эмнэлгийн хэрэгсэл, нийлэг хальсан уут, хөрстэй суулгац гэх мэт бараа эд зүйл бүртгэгдсэн байна. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын хувьд улсын хилээр орох чиглэлд голчлон зөрчил илэрдэг бөгөөд эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, согтууруулах ундааны зүйлс, сум зэрэг бараа,	
--	--	--	--	--	---	--

					Чингис Хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын хувьд гарах чиглэлд алт, ховордсон ан амьтны эд эрхтэн, ургамал, орох чиглэлд эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, сум, тамхи, алт, мөнгөн эдлэл, бэлэн мөнгө зэрэг бараа, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газарт орох чиглэлд согтууруулах ундааны зүйлс, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг бараа, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт метамфетамин, каннабис, экстази, шаттер зэрэг мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис байх магадлалтай эмийн зүйлс гэж тодорхойлсон. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			2-3.Гаалийн байгууллагын илрүүлсэн зөрчлийн талаарх мэдээллийг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 3 удаа мэдээлж, сэрэмжлүүлэн, гаалийн зөрчил болон холбогдох бусад 12 мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар түгээсэн.	2.Зөрчилд ихээр өртөгдсөн бараа, эд зүйлийн талаарх мэдээлэл, холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан сэрэмжлүүлнэ.	ГЕГ-ын www.customs.gov.mn цахим хуудсанд “Бусдын дайвар ачаа авахаас татгалзах” тухай сэрэмжлүүлэг, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх улсын хилээр бэлэн мөнгө (валют)-ийг нэвтрүүлэхэд анхаарах” асуудлын талаар сэрэмжлүүлэг мэдээ бэлтгэн хүргүүлсэн, Монголын Үндэсний олон нийтийн телевизтэй хамтран хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчихдоо бусдаас дайвар ачаа авахгүй байх тухайн дайвар ачаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, МУ-ын эмийн жагсаалтад бүртгэлгүй эм, тариа зэрэг хориглосон, хязгаарласан бараа байгаа тохиолдолд тухайн хүн өөрөө хуулийн хариуцлага хүлээх тухай анхааруулга мэдээллийг “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. -Гаалийн байгууллагын хэмжээнд илрүүлэн шийдвэрлэсэн МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, тариа, архи согтууруулах ундааны зүйлсийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх гэсэн зөрчлийн мэдээллийг Хэвлэл мэдээлэл, сургалт, судалгааны төвөөр дамжуулан гаалийн байгууллагын албан ёсны сошиал хуудас Монголын гааль пэйж хуудсанд 2 удаа нийтэлсэн. -Хамтын ажиллагааны хүрээнд ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газарт ашиглагдаж байсан “Body scan” буюу зорчигчийн биед биет үзлэг хийх зориулалт бүхий	

					тоног төхөөрөмжийг Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын зорчигчийн ирэх талд 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр суурилуулан гаалийн хяналт шалгалтад ашиглаж байна. Мөн уг арга хэмжээг МҮОНРТ сурвалжилж олон нийтэд түгээснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг биедээ нууж улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй болж байна гэх урьдчилан сэргийлэх, анхааруулга мэдээллийг нийтэд түгээсэн. -Харьяа гаалийн газар, хороодод гаалийн харилцаанд оролцогч иргэд, ААН, тээвэрлэгч нарт анхааруулга, сэрэмжлүүлэг, гарын авлага бэлтгэн тараах, мэдээллийг агуулсан хулдаасан хэвлэл бэлтгэж гаалийн хяналтын бүсүүдэд байршуулах, холбогдох сургалтыг хийх, видео шторк бэлтгэж нийтлэх, цахим хуудсанд мэдээллийг байршуулан түгээх, иргэд ААН-тэй уулзалт хийх, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах, орон нутгийн телевизээр мэдээлэл өгөх зэргээр зөрчилд ихээр өртөгдөж байгаа бараа, эд зүйлсийн талаарх мэдээллийг түгээх ажлыг тус тусын хариуцах нутаг дэвсгэрт зохион байгуулсан байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				3.Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж болзошгүй, эрсдэлтэй бараа, эд зүйлсийн судалгааг хийж, холбогдох мэдээлэл, эрх зүйн зохицуулалтын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сэрэмжлүүлнэ.	-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бодис тэдгээрийн түүхий эдийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн тохиолдолд хүлээх хариуцлага, -Галт зэвсгийн сумыг санамсар болгоомжгүй байдлаар биедээ болон эд зүйлдээ авч явснаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсоноор хүлээх хариуцлага, - Цаг үеийн шинжтэй нэмэгддэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд протехникийн хэрэгсэл /салют/ хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн тохиолдолд хүлээх хариуцлагыг анхааруулсан зурагт танилцуулгыг тус тус бэлтгэн Монголын гааль цахим хуудсаар түгээсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			4.Зөрчлийн тухай хуульд заасан	4.Зөрчлийн тухай хуульд заасан	2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Зөрчлийн тухай хуульд заасан нэгжээр тооцогдох	

				нэгжээр тооцогдох торгуультай зөрчлийн тоо 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1138 байна.	нэгжээр тооцогдох торгуультай зөрчлийн тоо хэмжээг өмнөх оны мөн үеэс 5 хүртэл хувиар бууруулсан байна.	торгуультай 1545 зөрчил илрүүлэн шийдвэрлэснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35.7 %-аар /өнгөрсөн онд 1138 нэгжээр тооцогдох торгуультай зөрчил/ өссөн үзүүлэлттэй байна. Нэгжээр тооцогдох зөрчилд холбогдогчийг төрлөөр нь харахад иргэдийн холбогдсон зөрчил 1142 буюу нийт зөрчлийн 73.9 %-ийг эзэлж байгаа бөгөөд 51.2 % нь Замын-Үүд, Сэлэнгэ дэх гаалийн газарт бүртгэгдсэн, 49.2 % нь эд зүйлийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн зөрчил байна. Хэдийгээр харьяа гаалийн газар, хороодод гаалийн харилцаанд оролцогчдод гаалийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөрчилд холбогдохгүй байх, хуулийг сахин биелүүлж байх талаар тодорхой ажлуудыг тогтмол зохион байгуулж байгаа ч иргэдийн хууль тогтоомж, эрх зүйн мэдлэг сул, бараа, эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх үйлдлийг амьжиргааны эх үүсвэрээ болгож байгаа нь энэ төрлийн зөрчил буурахгүй байгаа гол шалтгаан болж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
Зорилт 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх							
3.1	Улсын төсвийн гаалийн орлогыг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй бүрдүүлэх	Үйл ажиллагаа	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт төгрөгөөр, хувиар	Гаалийн байгууллага нь 2023 онд 5720.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5327.2 тэрбум төгрөг оруулж, 93.1 хувь байна. -Татварын орлого 5,173.8 тэрбум төгрөг, -Хураамжийн орлого 123.5 тэрбум төгрөг, -Өөрийн орлого 29.97 тэрбум төгрөг	Төсвийн тухай хуульд заасан гаалийн байгууллагын улсын төсөвт оруулах 6727.9 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна. Гүйцэтгэл 100 хувьтай байна.	Тайлант хугацаанд буюу 2024 онд 6792.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс Улсын төсөвт нийт 6743.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 99.3 %-ийн биелэлттэй байна. Орлогын төлөвлөгөөний биелэлт тус бүрээр авч үзвэл. -Татварын орлого 6642.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 6583.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.2 %-аар өссөн үзүүлэлттэй байна. -Хураамжийн орлого 135.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 146.3 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.5 %-аар өссөн үзүүлэлттэй байна. -Өөрийн орлого 15.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 13.8 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1414.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн буюу 26.5 %-ийн өсөлттэй байна. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	90 хувь

3.2	Гадаад худалдаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагад эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийх	Үйл ажиллагаа	Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулсан аж ахуйн нэгжийн тоо, улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн, төгрөгөөр	2023 оны эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр 87 аж, ахуйн нэгжид бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, 7.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.	143 аж ахуйн нэгж, байгууллагад бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгөн, илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж, улсын төсөвт 4 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.	Тайлант хугацаанд өмнөх оны удирдамж (он дамнасан)-аар 10 ААН, байгууллага, 2024 онд шинээр батлагдсан удирдамжаар 101 ААН, байгууллага, нийт 111 ААН, байгууллагад бүрдүүлэлт дараах шалгалт хийснээс 4 ААН, байгууллагын шалгалт хойшилж, 96 ААН, байгууллагад хийсэн шалгалт бүрэн дууссан бөгөөд 11 ААНБ-ын шалгалт үргэлжилж байна. Тайлант хугацаанд хийсэн шалгалтын үр дүнгээр нийт 69 ААН, байгууллагад холбогдох 34.3 тэрбум төгрөгийн дүн бүхий зөрчил илрүүлж шийдвэрлэсэн: 1. 12 ААН, байгууллагад холбогдох 18.8 тэрбум төгрөгийн зөрчил нь татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжтэй байсан тул Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлийн дагуу хууль, хяналтын байгууллага руу шилжүүлсэн; 2. 57 ААН, байгууллагад холбогдох 15.6 тэрбум төгрөгийн дүн бүхий зөрчлийг Захиргааны журмаар шалган шийдвэрлэж, нийт 3.8 тэрбум төгрөгийн нөхөн татвар, хохирол, торгуулийг оногдуулснаас 3.3 тэрбум төгрөг (өмнөх оны өр төлбөртэй нийлээд)-ийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Нөхөн оногдуулсан үлдэгдэл төлбөр хуульд заасан хугацаанд төсөвт төвлөрнө. Үнэлгээ: 80 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.БДШ-ээр 143 ААН орохоос 111 ААН орсон төлөвлөгөө 4 тэрбум төгрөг орохоос 3,8 тэр бум төгрөг орсон.	80 хувь
3.3	“Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулах талаар судалгаанд оролцох	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах ажлын хэсэг болон 14 дэд бүлэгт гаалийн байгууллагын төлөөлөгчид оролцсон. БНСУ-ын Сөүл хотноо 2023 оны 12 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион	Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах дараагийн хэлэлцээрт оролцох бэлтгэл ажлыг хангаж, оролцсон байна.	-Хэлэлцээрийн Барааны худалдааны бүлгийн бэлтгэл ажлын хуралд 2024 оны 01-р сарын 18, 06-р сарын 06-ны өдрүүдэд биеэр, 05-р сарын 17-ны өдөр онлайнаар оролцсон. -МУ, БНСУ хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хоёр дахь шатны хэлэлцээний Барааны худалдааны бүлгийн хурал 2024 оны 05-р сарын 21-22-ны өдрүүдэд болж барааны худалдааны зах зээлд нэвтрэх эрх болон хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн. Хурлын үеэр БНСУ-ын талаас манай талаас хүргүүлсэн тарифын жагсаалтын зарим барааны ангиллын кодтой холбоотой тодруулж асуусан асуултуудад хариулт	100 хувь

				байгуулагдсан Монгол Улс, БНСУ хоорондын ЭЗТХ-ийн эхний шатны хэлэлцээнд ГЕГ-аас 5 албан хаагч оролцсон.		өгсөн. Талууд эмзэг бараа бүтээгдэхүүний жагсаалтыг солилцох, эмзэг барааны жагсаалтдаа үндэслэн барааны жагсаалтын анхны саналаа солилцох, 2023 оны гадаад худалдааны статистикаа солилцохоор тохиролцсон. -3 дахь шатны хэлэлцээр 2024 оны 09 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Барааны худалдааны бүлгийн хуралдаанаар хэлэлцээрийн текст болон 2 талын тарифын жагсаалтын “Эмзэг бараа”-ны талаар санал солилцсон. -4 дэх шатны хэлэлцээр 2024 оны 11 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, Барааны худалдааны бүлгийн хэлэлцээрийн текстэд оруулах саналаа 2 тал хэлэлцэн, 1 заалтаас бусад хэсгээ ерөнхийд нь тохиролцсон. Барааны тарифын жагсаалтын 2 дахь удаагийн саналын хувьд БНСУ-ын тал гарал үүслийн бүлэгтэйгээ харилцан ярилцаж саналаа өгнө гэж мэдэгдсэн Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх							
4.1	Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Монгол Улсын Япон Улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, 2017 онд шинэчлэн батлагдсан Төрийн албан тухай хууль, 2019 онд батлагдсан Татварын ерөнхий хууль	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн.	1.Гаалийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиудыг батлуулах арга хэмжээг авсан байна.	ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг нь Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналтын тухай хуулийн гаалийн байгууллага хэрэгжүүлэн ажиллах холбогдох заалтуудыг тусган хуулийн төсөл боловсруулсан. Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг “Санал шийдвэрлүүлэх тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн болно. Үнэлгээ: 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.Төлөвлөгөөнд тусгасан хуулиуд батлагдаагүй.	70 хувь
				2.Ургамал хамгааллын тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн	2.Хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг	Эрүүл мэндийн яаманд 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр 02/679 дугаартай албан бичгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2 санал, дагалдан гарах хуулийн төсөлд 4 саналыг хүргүүлсэн. Гаалийн байгууллагын албан хаагчид уг хуульд нэмэлт,	100 хувь

	болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн "Гаалийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах			гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.	хүргүүлсэн байна.	өөрчлөлт оруулах төслийг боловсруулах УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дэргэдэх дэд ажлын хэсэгт ажиллаж, ажлын хэсгийн хуралдаанд 4 удаа, Байнгын хорооны хуралдаанд 2 удаа, УИХ-ын Чуулганы хуралдаанд 1 удаа орж ажилласан. Тус хуульд нэмэлт, өөрчлөлтийн оруулан тухай хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн батлагдаж, 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үе шаттайгаар хэрэгжиж эхэлсэн. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан. Тус хуулийг байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 3 удаагийн хурлаар, УИХ-ын чуулганы 2 удаагийн хурлаар тус тус хэлэлцүүлэн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр эцэслэн батлуулж, хэрэгжүүлсэн. Монгол Улсаас БНХАУ-д экспортлох тэжээлийн зориулалттай уураг болон өөх, тосны мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протоколыг боловсруулж, Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон БНХАУ-ын ГЕГ хооронд 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсан. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаанд хяналт тавих тухай” хуулийн төсөлд 6 саналыг хүргүүлсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				3.Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар 2019-2022 онуудад батлагдсан захиргааны хэм	3.Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд	Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд нийцүүлэн дараах журам, заавруудыг боловсруулсан. Хууль батлагдаагүй байгаа тул хүлээгдэж байна. Үүнд: 1. Дотооддоо дагаж мөрдөхөөр батлагдсан: - “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/123	80 хувь

				хэмжээний актуудад хяналт- шинжилгээ, үнэлгээ хийсэн.	нийцүүлэн журам, заавруудыг боловсруулсан байна.	- “Аргачлал, тайлагнах хугацааг шинэчлэн батлах тухай” А/190 - “ТҮ албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай” А/204. - “ГЕГ-ын зохион байгуулалтын нэгжийн индекс шинэчлэн батлах тухай” А/127 - “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод “Журамд өөрчлөлт оруулах” А/192 - “Нөхөх төлбөр шинэчлэн тогтоох тухай” А/193 2. ХЗДХЯ-д бүртгүүлэхээр хүргүүлсэн болон хүргүүлэхэд бэлэн болсон: - ГЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Бараа устгах горим хэрэгжүүлэх журам” №А/338 - “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам” А/315. - 2024 оны 07 дугаар сард “Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам”-ын шинэчилсэн төслийг ХЗДХЯ-руу бүртгүүлэхээр төлөвлөсөн байна. - “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тушаалын төсөл А/338. 3. Олон нийтээс санал авахаар цахим хуудсанд байршуулсан: - Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ын төсөл (2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 11-ний өдөр хүртэл) - Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын төсөлд (2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 12-ны өдөр хүртэл) санал авахаар Гаалийн байгууллагын https://customs.gov.mn цахим хуудсанд байршуулсан. - “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар” А/82 (2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хүртэл)	
--	--	--	--	--	--	--	--

						- "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар" (2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хүртэл) санал авахаар гаалийн байгууллагын https://customs.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Үнэлгээ: 80 хувь тодорхой үр дүнд хүрсэн. Төлөвлөгөөнд тусгасан хуулиуд батлагдаагүй.	
4.2	Байгууллагын архив, бичиг хэргийг цахимжуулах	Үйл ажиллагаа	Хадгаламжийн нэгжийн цахимжилт, хувиар, Хэрэгжилт, хувиар	1. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 910 хадгаламжийн нэгж буюу 180080 хуудас байнга хадгалах хадгаламжийн нэгжийг цахимжуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 410 хадгаламжийн нэгжээр буюу 82%-аар илүү, 265 хадгаламжийн нэгж 70 жил хадгалах баримтыг цахимжуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 157-оор илүү буюу 2.5 дахин илүү цахимжуулсан байна.	1.Түр болон 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн 40 хувь нь цахимжсан байна.	ГЕГ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журмын хүрээнд өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Гаалийн байгууллагад хадгалагдаж байгаа байнга хадгалах хадгаламжийн нэгж дараах байдлаар цахимжсан байна. Үүнд: - ГЕГ-т- 85%, - Харьяа гаалийн газар, хороодод -100% цахимжсан бөгөөд дундаж үзүүлэлт 92.5%-тай байна. Гаалийн байгууллагад хадгалагдаж байгаа түр болон 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 100% бүрэн цахимжсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	100 хувь
				2.Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 1998-2020 оны 910 баримт, Түр хадгалах хадгаламжийн нэгжийн 2001-2020 оны 11072 баримт, 70 жил хадгалах	2.Архивын лавлагааг /Гаалийн мэдүүлгээс бусад/ 100 хувь цахимжуулсан байна.	Архивын лавлагааг цахимжуулах ажлын хүрээнд албан хэрэг хөтлөлтийн https://edoc.ecustoms.mn программыг 2022 оноос эхлэн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, 19 гаалийн газар, хороо болон ГЕГ-т ирсэн, явсан албан бичиг нь цахим бичиг хэрэг хөтлөлтийн И-Док системээр дамжиж байгаа тул бүрэн цахим архивд орсон. https://edoc.ecustoms.mn программын архивын санд хадгалагдсан баримт бичгийн лавлагааг цахим	100 хувь

				хадгаламжийн нэгжийн 1961-2000 оны 265 хадгаламжийн нэгж тус бүрийн бүртгэлийг дахин боловсруулалт хийж, УТАГ-т хянуулахаар хүргүүлсэн		хэлбэрээр олгоход бэлэн болсон. Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг бүрэн ашиглалтад оруулсны дараа гаалийн байгууллагын архивын цахим лавлагааг олгох ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй	
				3.“Гаалийн байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийг 100 хувь цахимжуулан Edoc программыг ашиглаж байна.	3.Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороод хоорондын албан бичиг хүлээн авах, хүргүүлэх ажил бүрэн хийгдсэн, 100 хувь цахимжсан байна.	Гаалийн байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийг 100% цахимжуулан https://edoc.ecustoms.mn программыг ашиглаж, системийн хэмжээнд албан бичиг цахимаар солилцох, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдөж ажиллаж байна. ГЕГ-ын хэмжээнд https://edoc.ecustoms.mn/ программаар 12868 албан бичиг, өргөдөл, гомдол бүртгэснээс 7442 хариутай, 7160 хариу явуулсан, 282 судлагдаж байгаа, 96.2%-ийн гүйцэтгэлтэй байна. Нийт 712 өргөдөл, хүсэлт ирснээс хариу явуулсан 673 өргөдөл, хугацаа болоогүй 39 өргөдөл байна.Тайлангийн хугацаанд 157 гомдол ирснээс 150 гомдлын хариу явуулсан, хугацаа нь болоогүй 7 гомдол байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй	100 хувь
4.3	Гаалийн төв болон салбар лабораторийг олон улсын жишигт нийцүүлэх	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, хувиар	1.Гаалийн төв лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр Олон улсын итгэмжлэлд хамруулах ажлын хүрээнд БНХАУ-ын	1.Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лабораторийг нефтийн бүтээгдэхүүн, ноос ноолуурын шинжилгээний чиглэлээр, Дорнод аймаг дахь гаалийн	1.Гаалийн төв лаборатори нь БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгуулга CNAS-ийн төлөвлөгөөний дагуу уул уурхайн эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний магадлан шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн эрхээ баталгаажуулах хяналтын шатны үнэлгээнд амжилттай хамрагдаж, илэрсэн 9 үл тохирлыг залруулан, баримтжуулж, цахимаар болон шуудангаар илгээж, тус байгууллагаар үнэлүүлж, итгэмжлэлийн эрхээ 2025 он хүртэл амжилттай сунгав.	96.7 хувь

				итгэмжлэлийн үнэлгээний байгууллага/CNAS/-ын цахим үнэлгээнд амжилттай хамрагдаж, эрдсийн бүтээгдэхүүнд 14 үзүүлэлтээр, нүүрсэн бүтээгдэхүүнд 8 үзүүлэлтээр, газрын тосны бүтээгдэхүүнд 19 үзүүлэлтээр итгэмжлэхээр шийдвэрлэсэн. - Олон улсад шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрүүлэх ажлын хүрээнд Лондоны металлын биржтэй уулзалт хийж, бүртгүүлэх саналыг хүргүүлэхэд Гаалийн лабораторийн бүтэц, зохион байгуулалт, чадавхаас үл хамааран, Монгол улсын металлын борлуулалт, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл байдлаас хамааран Гаалийн төв лаборатори нь	газрын салбар лабораторийг хими, нефтийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөж, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Гаалийн салбар лабораторийг согтууруулах ундаа, хими, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр, Гашуунсухайт, Шивээхүрэн, боомтуудын салбар лабораториудыг нүүрсний чиглэлээр, Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын салбар лабораторийг нефтийн чиглэлээр дотоодын итгэмжлэлд хамруулсан байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.	2.Гаалийн салбар лабораториудыг Үндэсний итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд дотоод аудит хийх төлөвлөгөө гарган, баталж, MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу 05 дугаар сард Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, 06 дугаар сард Замын-Үүд дэх гаалийн газар, 10 дугаар сард Орхон аймаг дахь гаалийн газар, 12 дугаар сард Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар болон Сайншанд дахь гаалийн газруудын салбар лабораториудад тус тус дотоод аудит хийж, илэрсэн үл тохирлыг залруулах арга хэмжээ авах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч, стандарт арга, аргачлалыг зөв ашиглаж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор холбогдох шинжилгээг хийлгэж, шинжилгээний үр дүнгийн чанар хангалтын хэрэгжилтийг хянаж, холбогдох мэргэжил арга зүйгээр хангаж, “Салбар лабораторийн үйл ажиллагааны дотоод журам”-ыг хянаж, засварлан, тухайн гаалийн газрын удирдлагаар батлуулан ажилласан. /Дорнод аймаг болон Гашуунсухайт гаалийн газрын Оюутолгой дах салбар лабораториудын хувьд магадлан шинжилгээний нөхцөлийн дагуу лабораторийн барилгад агааржуулалтын засвар үйлчилгээний ажил явагдаж байсан тул газар дээр нь аудит хийх боломжгүйгээс түр хугацаагаар хойшлуулан, “Салбар лабораторийн үйл ажиллагааны дотоод журам”-ыг хянаж, засварлан, тухайн гаалийн газрын удирдлагаар батлуулан ажилласан./ 3.ГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу гаалийн салбар лабораториудад дотоод аудитыг зохион байгуулж, чанарын удирдлагын бичиг баримт болох “Салбар лабораторийн үйл ажиллагааны дотоод журам”-ыг хянаж, засварлан, тухайн гаалийн газрын удирдлагаар батлуулснаар Үндэсний итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажил хангагдсан бөгөөд одоогийн байдлаар Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лаборатори нь хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар аюулгүй үзүүлэлт,	
--	--	--	--	---	--	---	--

				ЛМБ-д бүртгэлтэй дээжлэгч, Шинжлэгч байгууллагаар элсэх боломжгүй гэсэн хариуг ЛМБ-ээс албан ёсоор ирүүлсэн.		ургамал хорио цээрийн магадлан шинжилгээгээр 2026 оныг хүртэл Үндэсний итгэмжлэл хамрагдсан бөгөөд тус салбар лаборатори нь химийн бодис, мансууруулах бодисын шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээ өргөтгөхөөр мөн Орхон аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газрын салбар лабораториуд нь шинээр итгэмжлүүлэхээр итгэмжлэлийн өргөдлийг холбогдох бичиг баримтын хамт Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлэн, тус төвийн албан хаагч чанарын удирдлагын тогтолцооны бичиг баримтын шалгалтыг хийж байна. Үнэлгээ: 1-100 хувь, 2-90 хувь, 3-90 хувь Дундаж 93.33 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.
			2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг гаалийн төв лабораторийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.	2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лаборатори, Дорнод аймаг дахь гаалийн газрын салбар лаборатори, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын салбар лаборатори, Гашуунсухайт, Шивээхүрэн, Увс аймаг дахь гаалийн газрын	Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг дараах салбар лабораториудад бүрэн нэвтрүүлсэн байна. Үүнд: - Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын салбар лаборатори, - Орхон аймаг дахь гаалийн газар, - Сайншанд дахь гаалийн газар, - Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой дах салбар, - Шивээхүрэн боомтын салбар лаборатори - Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Цагааннуур, - Дорнод аймаг гаалийн газрын төв - Дорнод аймаг гаалийн газрын Баянхошуу боомт дахь салбар лабораториудад бүрэн нэвтэрсэн. - Замыг-Үүд дэх гаалийн газрын салбар лаборатори - Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лаборатори бүрэн нэвтэрсэн. Гаалийн төв болон салбар лабораторийн үйл ажиллагаа бүрэн цахимжсан. Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын салбар лабораторид хүний нөөцийн дутагдалтай байгаа тул энэ системийг нэвтрүүлэх ажлыг 2025 онд хийхээр хойшлуулсан хүний нөөцийг бүрдүүлсэн тохиолдолд энэ системийг бүрэн нэвтрүүлэх	

					Боршоо боомтуудын салбар лабораториудын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, дууссан байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.	боломжтой болно. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.4	Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх	Урсгал зардал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд албан хаагчдыг томилох, чөлөөлөх, дэвшүүлэн томилох, шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.	1.Төрийн албаны чадахуйн зарчимд нийцүүлэн томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан байна.	Гаалийн байгууллагын сул орон тоог нөхөн хангахаар ТАЗ-ийн дэргэдэх ГЕГ-ын Салбар зөвлөлөөс тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn, гаалийн байгууллагын www.ecustoms.gov.mn цахим хуудсаар олон нийтэд, нээлттэй зарласан. Тусгай шалгалтыг 1, 4, 7, 11 дүгээр саруудад буюу нийт 4 удаа зарлаж, бүртгэлд цахимаар 619 иргэн хүсэлт ирүүлснээс дараах үзүүлэлттэй байна. Үүнд: - 107 иргэн анкет илгээгээгүй (анкет хадгалсан) тул хянаагүй, - 512 иргэний материалыг хянан үзсэн. Үүнээс: - Шаардлага хангаагүй гэж үзэн 184 бүртгэлээс хасаж, - Шаардлага хангасан 328 иргэнийг бүртгэлд хамруулсан. Нийт удирдах 3, гүйцэтгэх 180 иргэн зарлагдсан ажлын байранд тэнцэж зарлагдсан 533 ажлын байрны 183 сул орон тоо буюу 34,3 хувийг нөхсөн. Шинээр томилогдсон албан хаагчдын 30 буюу 16,7 хувь нь Улаанбаатар хотод, 150 буюу 83.3 хувь орон нутагт томилогдсон. Төрийн тусгай албан тушаалын сул орон тооны нөхөн хангалтын чиглэлээр нийт 455 сул орон тоог иргэн, албан хаагчийг томилох, түр орлон гүйцэтгүүлэх замаар нөхсөн бөгөөд үүнээс 159 буюу 35 хувийг гадаад эх үүсвэрээс, 296 буюу 65 хувийг дотоод эх үүсвэрээс нөхсөн байна. Нийт 235 албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасны дагуу гаалийн байгууллага нэгж хооронд шилжүүлэн томилсон бөгөөд үүнээс 82 албан хаагч нэгж дотроо,	98.3 хувь

					153 албан хаагч өөр харьяа гаалийн газар, хороодод шилжин ажилласан. Нэгж дотроо шилжин ажилласан албан хаагчдын 69 буюу 45 хувь нь Улаанбаатар хотод, 11 буюу 7 хувь нь Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт, 42 буюу 27 хувь нь хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод, 31 буюу 20 хувь нь хөдөө орон нутгаас хөдөө орон нутагт шилжсэн. Шагналд нэр дэвшүүлж ирүүлсэн 383 албан хаагчдын материалыг нэгтгэн, удирдлагад танилцуулж 315 албан хаагчийг шагнаж урамшуулах, шагналд нэр дэвшүүлж дээд шатны байгууллагад уламжлахаар шийдвэрлэсэн. Нийт шагналд нэр дэвшигдэж ирсэн албан хаагчдын 82,2 хувийг дэмжиж шийдвэрлэсэн: Үүнд: 1.“Хүндэт гаальчин” тэмдгээр 20, Гаалийн ерөнхий газрын даргын “Жуух бичиг”-ээр 58, албан тушаалын үндсэн цалингийн 50, 100 хувиар шагнах 14, нийт 92 албан хаагчийг ГЕГ-ын даргын тушаалаар, 2.“Гаалийн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 23, “Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 1, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр 64, нийт 88 албан хаагчийг Сангийн яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлж, холбогдох материалыг Сангийн яаманд хүргүүлэн нийт 87 албан хаагчийг шагнуулсан. Мөн Үндэсний их баяр наадам, Улс тунхагласны ойн баяр, Гаалийн байгууллагын тэмдэглэлт өдрийг тохиолдуулан “Үйлчилгээний гавьяат ажилтан” 1, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 25, “Алтангадас” одонгоор 29, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 80, нийт 135 албан хаагчийг төрийн одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлж Сангийн яаманд хүргүүлсэн. “Гаалийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан нийт 155 албан хаагчид цол олгуулах саналтай холбогдох материал ирүүлснийг нэгтгэн удирдлагуудад танилцуулж, 61 албан хаагчид цол олгох болон сэргээн олгохоор шийдвэрлэсэн. Энэ нь нийт цол олгуулах саналтай ирсэн албан хаагчдын 39,4 хувьд цол олгохоор шийдвэрлэсэн. 36 албан хаагчид “гаалийн зөвлөх”, 22 албан хаагчид “гаалийн итгэмжит зөвлөх” цол шинээр олгож, 2 албан хаагчийн
--	--	--	--	--	--

		урьд авсан “гаалийн зөвлөх”, 1 албан хаагчийн “гаалийн итгэмжит зөвлөх” цолыг сэргээн олгосон. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.
2.Хилийн боомтуудад ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн дундаж цалин 2020 оноос 1,001,600 төгрөгөөр нэмэгдсэн байна. -Өндөр насны тэтгэвэрт гарсан 27 албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж болгон нийт 631.1 сая төгрөг; Ар гэрийн гачигдал гарсан 77 албан хаагчдад нийт 42.3 сая төгрөгийн буцалтгүй тусламж; Нас барсан 3 албан хаагчийн ар гэрт нийт 53.6 сая төгрөгийн тэтгэмж; Гаалийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан нийт албан хаагчдад үндэсний баяр цагаан сараар хүндэтгэл үзүүлэх зардалд 123.5 сая төгрөг; Төрийн үйлчилгээний 27 албан хаагчид нийт 27.0 сая төгрөгийн	2.Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлыг хэрэгжүүлсэн байна.	Албан хаагчдын нийгмийн асуудлыг хангах чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлсэн.Үүнд: -Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлийн 280.7 дэх хэсэгт Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ГЕГ-ын даргын 27 удаагийн тушаалаар нийт 552 албан хаагчид 7.2 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгуулахаар шийдвэрлэсэн. -ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэхээр ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа газар хороодын 367 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоох жагсаалтыг гаргасан. -ГЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Албан хаагчдад зэрэг дэв олгох” Б/10 дугаар тушаалаар 59, 11 дүгээр сарын 07-ны өдрийн Б/794 дүгээр тушаалаар 65 албан хаагчийн зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон. Холбогдох журмын дагуу 862 албан хаагчийн зэрэг дэв, төрийн алба хаасан хугацаа болон бусад нэмэгдлийг шинэчлэн тогтоосон байна. Өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор албан тушаалаас чөлөөлөгдсөн 33 төрийн тусгай, 14 төрийн үйлчилгээний, нийт 47 албан хаагчид 1,359,643,695.78 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, нас барсан 8 албан хаагчийн ар гэрт 104,548,400 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, Хөдөлмөрийн дотоод журмын 11.2.2-т заасны дагуу ар гэрийн гишүүн нас барсан 84 албан хаагчид 55,440,000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, Ахмадын хорооноос уламжилсан буцалтгүй тусламж хүссэн Гаалийн ахмадын байгууллага, ахмад настануудтай хамтран ажиллах журмын 3.7, 3.8-д заасны дагуу 58 ахмад настанд 22,800,000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг холбогдох хууль

урамшуулал; Нийт төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнгийн урамшуулалд 3,602.5 сая төгрөгийг тус тус олгосон байна. -Нэг албан хаагчид нийт 600,000 мянган төгрөгийн үнэтэй дүрэмт хувцасны хангалтыг зохион байгуулсан.		тогтоомжийн дагуу олгох асуудлыг шийдвэрлүүлсэн. Мөн 1 ахмад настны гэр бүл бөгөөд гаалийн байгууллагад /ЗҮГГ-ийн ТҮ-слесариар 26 жил ажиллаж байгаад элэгний хорт хавдар/ өвчний улмаас ажлаас чөлөөлөгдсөн тул мөнгөн дэмжлэг хүссэн өргөдөл ирүүлснийг өмнөх байгууллагад /албан хаагчдаа танилцуулахаар/ шилжүүлснийг тус газраас сайн үйлсийн хандиваар 3.9 сая төгрөг цуглуулж гэр бүлд нь хүлээлгэн өгсөн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
3."Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр /2024-2029 он/-ийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж ажиллаа	3.Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулж, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна.	"Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг "Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" болгон дахин өөрчилсөн. Мөн төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. Тус хөтөлбөрийн төслийг эцсийн байдлаар 4 хэсэг 14 заалт бүхий 3 зорилт арга хэмжээний хүрээнд боловсруулан Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4. Эрт илрүүлгийн үзлэгт нийт 1506 албан хаагч үүнээс ГЕГ-ын зохион байгуулалтын нэгж, дэргэдэх байгууллага 189 буюу 83.26% хувь, харьяа газар, хороод 1317 буюу 85.79% хамрагдав.	4.Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа бүрэн хамруулсан байна.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, ЗГ-аас орон даяар зохион байгуулж байгаа Эрүүл монгол хөтөлбөр төсөл "Эрт илрүүлэг үзлэг"-ийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан гаалийн байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сувилалд хамруулах асуудалд төсвийн хязгаарлалт хийсэн. Тусгай шалгалтад тэнцсэн нийт 145 иргэдийг Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулан, өөрийн хүсэлтээр татгалзсан 7, эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй 9 иргэнийг томилохоос татгалзаж бусад иргэдийг холбогдох журмын дагуу тухайн албан тушаалд нь томилон шийдвэрлэсэн.	

					Гаалийн байгууллагад шинээр ажилд орж байгаа албан хаагчдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн шинжилгээний хуудсыг хувийн хэрэгт нь хадгалуулж хэвшүүллээ. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
			5.Гаалийн байгууллагын хэмжээнд 2023 онд: 1. ГЕГ-ын Сургалтын төвөөс, 2. ГЕГ-ын ЗББНДБ-ын, 3.Харьяа гаалийн газар, хороодын, 4.ДГБ-ын E-Learning цахим сургалтын гэсэн 4 чиглэлээр нийт 962 сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 12391 албан хаагч хамрагдсан байна.	5.300 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна.	Гаалийн байгууллагын хэмжээнд 2024 онд нийт 915 сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 36189 албан хаагч хамрагдсан байгаа нь 2023 оны мөн үетэй харьцуулахад сургалтын тоо 47-оор буюу 4.9 хувиар буурсан боловч хамрагдсан албан хаагчийн тоо 23931-ээр буюу 195.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд: -Удирдах албан тушаалтан 1737, -Гүйцэтгэх, туслах албан тушаалтан 34452 тус тус хамрагдсан байна. 2024 онд нийт 915 сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 36189 албан хаагч хамрагдсан тоон үзүүлэлт нь гаалийн байгууллагад 2000 орчим албан хаагч ажилладаг тоон үзүүлэлттэй харьцуулах юм бол 1 албан хаагч дунджаар 18 сургалтад хамрагдсан гэсэн үзүүлэлт юм. Энэ нь харьяа гаалийн газар, хороодын хэрэгцээнд нийцүүлэн гол сургалтуудаа төвлөрүүлэн зохион байгуулж, хамрагдах албан хаагчийн тоогоо нэмэгдүүлсэнтэй холбоотой. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах төлөвлөгөө батлагдан гарсан.	6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	Гаалийн байгууллагын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах төлөвлөгөөний биелэлтийг дараах байдлаар хангаж ажилласан. Үүнд: - Замын-Үүд дэх гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газарт Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй саадгүй авах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээний орчны тохижилтыг хийсэн. - “Бүрдүүлэлтийн цахим төв, Шуурхай хяналтын төв болон 1800-1281 гаалийн лавлах утас, GAALI.MN гаалийн цахим үйлчилгээний системийн үйл	

					ажиллагааны талаар, Боршоо болон Замын-Үүд боомтын талаар хийсэн 2 ширхэг видео контент дээр сонсголын бэрхшээлтэй иргэд чөлөөтэй ойлгож, мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх үүднээс 3 минутын видео шторкийг дохионы хэлмэрчээр орчуулуулан гаалийн байгууллагын “Монголын гааль” пэйж хуудас, “Монголын гааль” твиттер, customs.gov.mn веб хуудас, youtube хуудсанд байршуулсан. - Замын-Үүд дэх гаалийн газар нь дараах 8 минутын 3 шторк танилцуулгыг дохионы хэлний хэлмэрчээр хэлмэрчлүүлэн авто замын шалган нэвтрүүлэх цогцолборын гаалийн хяналтын бүсийн Зорчигчийн терминалын “Гарах”, “Орох” хэсэг дэх 14 дэлгэцээр нэвтрүүлэн сурталчилж байна. Үүнд: 1. “Зорчигч улсын хилээр гарахад анхаарах зөвлөмж” 2. “Gaali mn”-д өөрөө мэдүүлэхэд анхаарах зөвлөмж 3. “Тоон гарын үсэг ашиглах заавар -Гаалийн байгууллагаас “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам” болон “Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, хиймэл эд эрхтэн, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын авто тээврийн хэрэгсэлд үзүүлэх татварын чөлөөлөлт”-ийн талаарх мэдээлэл агуулсан номыг “Хараагүйчүүдийн үндэсний төв”-ийн дэргэдэх брайл хэвлэлийн газарт хэвлүүлсэн. Тус журам брайл стандартын хэмжээгээр 19 хуудастай бөгөөд Гаалийн ерөнхий газрын харьяа 19 гаалийн газар хороодод хүргүүлж орох, гарах чиглэлд тус тус байршуулснаар зорилтот бүлгийн хэрэглэгч шаардлагатай мэдээллийг авах боломж бүрдсэн. -Гаалийн байгууллагын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчид, гэр бүлийн гишүүд, эрүүл мэндийн байгууллагын хяналтад тогтмол хамрагддаг гишүүдийн төрөлжсөн судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд гаалийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй 35 албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй	
--	--	--	--	--	--	--

					хүүхэдтэй 28 албан хаагч тус тус ажиллаж байна. Судалгааны мөрөөр байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, эсвэл гэр бүлийн гишүүнээ асардаг ажилтныг орон нутагт томилолтоор болон илүү цагаар ажиллуулахгүй байж, дэмжлэг, тусламж үзүүлэх ажлыг хэрэгжүүлэн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна. -ГЕГ-ын даргын 2023 оны А/367 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах журам”-д дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, шилжих асуудлыг шийдвэрлэж байна. Тухайлбал: 3.6.2-т “Гаалийн улсын байцаагч, түүний эхнэр, нөхөр төрсөн эх, эцэг, хүүхэд болон үрчилсэн хүүхэд нь байнгын асаргаа шаардлагатай өвчин, гэмтэл, хөгжлийн бэрхшээлтэйг нь эрх бүхий эмнэлгийн байгууллагаас тодорхойлсон”; -“Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-т хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй албан хаагчид дэмжлэг үзүүлэх талаар 3 заалтыг тусгасан. -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрлөх эрхийг хангаж Гаалийн байгууллагын сул орон тооны тусгай шалгалтад оролцох эрхээр хангаж ажиллах боломжийг бүрдүүлснээр энэ оны 11 дүгээр сард зарлагдсан тусгай шалгалтад 4 иргэн тэнцэж, гаалийн хэргийн мэдлэг олгох богино хугацааны чиглүүлэх сургалтад хамрагдаж байна. -ГЕГ-ын Олон нийттэй харилцах албаны гаалийн улсын байцаагч Н.Солонгыг тус төвийн дохионы хэлний анхан, дунд шатанд сургахаар сургалтын гэрээг байгуулсан бөгөөд тус сургалтад амжилттай суралцаж 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр төгссөн. Улмаар сонсголын бэрхшээлтэй иргэд ГЕГ-ын дурын газар, хэлтэс дээр очиж, мэдээлэл, үйлчилгээ авах боломж бүрдсэн. -Гаалийн байгууллагын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагаанд зарцуулах 216.0 сая төгрөгийн төсвийг Гаалийн байгууллагын 2025 оны урсгал үйл ажиллагааны	
--	--	--	--	--	--	--

						төсөвт тусгаж ажилласан. -2024 оны байдлаар гаалийн татвараас чөлөөлөгдсөн тусгай зориулалтын автомашины бүрдүүлэлт хийгдээгүй болно. Харин тэргэнцэр, протез, сонсголын аппарат, нүдний болор, зэрэг 71 нэр төрлийн нийт 3,898,375.94 ам.долларын үнийн дүн бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бараанд ногдох 1,385.2 сая төгрөгийн гаалийн татвар, 2,04 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар нийт 3.4 тэрбум төгрөгийн татварын чөлөөлөлтийг 29 аж ахуйн нэгж, иргэнд олгож ажилласан. -2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ГЕГ-т Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хиймэл эд эрхтэн импортолдог аж ахуйн нэгжийн төлөөллийг хүлээн авч уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэглээнд зориулсан хиймэл эд эрхтэн импортлоход учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар болон шийдвэрлэх боломжийн талаар ярилцсан. Уулзалтад 8 компанийн төлөөлөл оролцсон. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.5	Гааль судлалыг хөгжүүлэх	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр	1.“Гаалийн хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг ГЕГ-ын төв байранд зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт гаалийн асуудлаар нийт 11 бүтээл ирүүлсэн бөгөөд шилдэг бүтээл шалгаруулах комиссын шийдвэрийг үндэслэн эрдэмтэн, судлаач багш болон гаалийн алба хаагч, оюутан	1.Эрдэм шинжилгээний хуралд шилдэг бүтээлээр дэвшүүлсэн санал, санаачилгыг гаалийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, үр дүнг тооцно.	2024 онд ГЕГ-аас МУИС болон ХААИС-тай хамтран ажиллах “Санамж бичиг” байгууллаа. Энэ хүрээнд гаалийн хүний нөөцийг бэлтгэх, тус сургуулийн тусгай зөвшөөрлийг харгалзан элсэгчдийн хяналтын тоог тогтоох, дунд, урт хугацааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гаалийн албан хаагчийн ажлын байрны сургалт дээр дэмжлэг үзүүлэх, зэрэг энэ чиглэлээр олон талт ажлуудыг хамтран хэрэгжүүлэх юм.. “Санамж бичиг”-ийн хүрээнд ГЕГ-ын даргын тушаалаар “Гааль” сэтгүүлийн редакцийн 8 гишүүнтэй зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнд нь ГЕГ, МУИС-ийн эрдэмтэн, доктор, профессорууд багтсан байна. “Гааль” сэтгүүл нь өөрийн албан ёсны бар кодтой болсноор цаашид МУИС-ийн багш нарын дэмжлэгтэйгээр сэтгүүлээр дамжуулан гаалийн байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлаар өгүүлэл, нийтлэл, судалгаа, бүтээл гарган, асуудлыг шийдэх боломжийн талаар санал боловсруулж, гаалийн албан хаагчдыг шинжлэх ухааны	100 хувь

				гэсэн хоёр ангиллаар, ангилал тус бүрээс гурав, нийт зургаан бүтээлийг байр эзлүүлэн шалгаруулсан болно.		үндэслэлтэй мэдээллээр хангах боломж бүрдэж байна. Монгол Улсад худалдааны салбарын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 100 жил, Гаалийн байгууллага үүсэж, хөгжсөний 112 жил, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тохиолдуулан “Глобал бизнес дэх шинэ хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг МУИС-тай хамтран 2024 оны 10 дугаар сарын 25-нд зохион байгуулсан. Тус хуралд худалдаа, гааль, глобал бизнесийн шинэ хандлагын талаар нийт 100 гаруй олон улсын болон дотоодын эрдэмтэн, судлаач, экспертүүд болон гаалийн байгууллагын албан хаагч, бусад байгууллагын төлөөлөл илтгэлүүдээ хэлэлцүүлэн оролцсон. ГУАБ Л.Олонбаярын МУИС-ийн доктор Н.Отгонсайхан, доктор Ө.Номинцэцэг нарын хамт бичсэн “Tariff Negotiations Under Free Trade Agreements: The Case of Mongolia and the Republic of Korea” судалгааны өгүүлэл нь нэр хүнд бүхий “World Customs Journal” сэтгүүлд 2024 оны 10 дугаар сарын дугаарт хэвлэгдсэн болно. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				2.Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024” хөтөлбөр”-ийн дагуу “Гааль судлал-2” эмхэтгэлийн ажил бүрэн дуусан бөгөөд хэвлэлийн санхүүжилтийн асуудал болон цахим хувилбарыг судалж байна.	2.Гааль судлалын нэгдсэн санг гаалийн харилцаанд оролцогчдод нээлттэй болгоно.	“Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024” хөтөлбөр”-ийн дагуу ГЕГ болон харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдын 2012-2023 оны хугацаанд хийсэн доктор /Ph.D/, магистрын бүтээл, эрдэм шинжилгээний илтгэл, эрдэмтэн судлаачидтай хамтарсан бүтээл, судалгаа шинжилгээний ажлын хураангуйг авч, 200 хуудас бүхий “Гааль судлал-2” эмхэтгэлийг 30 ширхгийг хэвлүүлэн, ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон харьяа гаалийн газар, хороодод тараасан. Эмхэтгэлд УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, ахмад гаальчин Л.Минжин, Т.Лхагваа, Ж.Чимгээ, Ч.Жаргалсайхан /доктор Ph.D/, Д.Даваасүрэн /доктор Ph.D/ , Д.Цэндсүрэн /доктор Ph.D/, У.Отгонбаяр /доктор Ph.D/ нараас гадна ГЕГ болон харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдын 50 бүтээл, судалгаа шинжилгээний ажлын хураангуй багтсан байна.	“Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024” хөтөлбөр”-ийн
				3.“Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024” хөтөлбөр”-ийн дагуу хийгдэх ёстой ажлын гүйцэтгэл 2023 оны	3. 4 жилийн хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна.		

				эцсийн байдлаар 80 хувьтай явагдаж байна.		хүрээнд хийгдэх эрдэм шинжилгээний ажил, ном, бүтээлийг бүртгэлжүүлэх, нэгдсэн сан үүсгэх ажлыг дараах дөрвөн чиглэлээр материал цуглуулж, CERP программд “Гааль судлал” дэд цэс үүсгэн байршуулсан.Үүнд: а.“Гааль судлал-1 /2002-2011/” эмхэтгэлд орсон материал, б.“Гааль судлал-2 /2012-2022/” эмхэтгэлд орох материал, с.“Гаалийн хөгжлийн чиг хандлага” олон улсын онол, практикийн бага хурлын хүрээнд шалгарсан бүтээл, д.“Гааль” сэтгүүлүүдэд нийтлэгдсэн материал /2009 – 2022 он/. Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024” хөтөлбөр”-ийн хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.6	“Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний арга хэмжээг жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг холбогдох дээд шатны	Үйл ажиллагаа	Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээгээр, хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.“Гаалийн байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний нэмэлт өөрчлөлтийн төслийг Сангийн сайдаар 2023 оны 03 дугаар сарын 21 өдөр батлуулсан. -“Гаалийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний төслийг Сангийн сайдаар батлуулсан. -Гаалийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 2023	1.Стратеги төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөн, эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавин, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох дээд шатны байгууллагад тайлагнана.	Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлалын дагуу 2023 оны жилийн эцсийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн 75 ажилд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, Гаалийн байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд тусган 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01-4/329 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн ба Сангийн яамнаас 88.2 хувь буюу Сайн гэж үнэлэгдсэн. Уг үр дүнтэй холбоотой 6 зөвлөмжийг ирүүлсний дагуу ГЕГ-ын удирдлагаас үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. “Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний дагуу “Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөө нь 4 зорилтын хүрээний 37 арга хэмжээнээс бүрдсэн. Гаалийн байгууллагын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01-1/2679 албан бичгээр СЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжилд хүргүүлсэн. Мөн Гаалийн ерөнхий газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ	93.3 хувь

байгууллагад тайлагнах, дүгнүүлэх				оны 06 дугаар сарын 30-ний 01-1/2445 албан бичгээр СЯ-д хугацаанд нь хүргүүлэн, ажилласан.		хийсэн 305 хуудас тайланг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01-4/2688 албан бичгээр Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. Гаалийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны жилийн эцсийн биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр тайлагнахаар ажиллаж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				2.Гаалийн байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үнэлгээ 92.28 хувь буюу 90.7 оноо.	2.Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг “А” үнэлгээгээр дүгнүүлсэн байна.	ГЕГ-ын 2023 оны үйл ажиллагааны нийт 9 бүлэг, 312 хуудас хавсралт тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт 2024 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн 01-4/397 албан бичгээр хүргүүлж, 88.2 %-аар дүгнүүлсэн. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
				3.“Гаалийн байгууллагын 2020-2024 оны стратеги төлөвлөгөө”-г боловсруулж, Сангийн сайдаар батлуулсан ба 2023 онд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан.	3.“Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г оновчтой төлөвлөж, батлуулсан байна.	“Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/548 дугаар тушаалаар 22 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус ажлын хүрээнд Удирдлагын академийн ахлах багш Ё.Батсүхтэй Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ болон ахисан түвшний сургалт авсан. Ажлын явцад ажлын хэсгийн гишүүдээс гадна зарим чиглэлийн албан хаагчдыг татан оролцуулж, 9 удаа хуралдаж, ГЕГ-ын удирдах албан тушаалтан нарыг 4 цагийн ахисан түвшний танхимын сургалтад хамруулсан. Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг Засгийн газрын урт хугацааны бодлогын баримт бичиг Алсын хараа 2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн Засгийн газрын 2020 оны 216, ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу боловсруулж, нийт 1 зорилго, 4 зорилтын хүрээнд нийт 11 арга хэмжээг төлөвлөн тусгасан. Мөн зорилго, зорилт, арга хэмжээнд тусгасан ажлын шалгуур үзүүлэлт, түүнийг тооцох арга зүйг тус бүр боловсруулан, төслийг батлуулахад бэлэн болсон. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	

4.7	Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, албаны эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлэх	Урсгал зардал	Эрэлч нохойн тоо, Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоо, Илрүүлсэн зөрчлийн тоо, хувиар	1. Эрэлч нохойн тоог 5-аар нэмэгдүүлж, нийт 48 эрэлч нохойтой	1.Эрэлч нохойн тоог 5-аар нэмэгдүүлж, нийт 49 эрэлч нохойтой болно.	ГЕГ-ын даргын 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн албаны эрэлч нохойн сонголт, нөхөн хангалт, бүртгэлжилтийг зохицуулах журам”-ын дагуу шалгуур хангасан эрэлч нохойн сургалтын төвийн үржлийн хөтөлбөрийн хүрээнд гаргаж авсан 4 нохой, шинээр авсан 1 нохойг гаалийн байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн данс бүртгэлд бүртгүүлэхээр 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр №2024/63 тоот дотоод зурвасаар Санхүү хөрөнгө оруулалтын газар, Аж ахуй, үйлчилгээний албанд хүсэлтийг холбогдох материалуудын хамт хүргүүлсэн. Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар дээрх 5 нохойг гаалийн байгууллагын данс бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэсэн. 5 нохойг шинээр данс бүртгэлд авснаар гаалийн байгууллага нийт 53 эрэлч нохойтой болж 2023 онтой нохойн тоог харьцуулахад 10%-аар нэмэгдсэн. 2024 онд данс бүртгэлд нийт байхаар төлөвлөж байсан нохойн тооноос 8%-аар өссөн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	100 хувь
				2. Гаалийн ерөнхий газрын харьяа 11 газар хороодод 28 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч эрэлч нохойн хамтаар ажиллаж байна.	2. Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоог 5-аар нэмэгдүүлж, сургана.	Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын Б/68, Б/69, 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Б/184, Б/151, Б/152, Б/154, 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Б/495, 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/683 дугаар тушаалуудаар гаалийн байгууллагад эрэлч нохойн чиглэлээр ажиллах 8 гаалийн улсын байцаагч 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Б/572 дугаар тушаалаар хүүхэд асрах чөлөөний хугацаа дууссан 1 албан хаагч томилогдсоноор нийт 9 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч шинээр томилогдсон. Үүнээс: Эрэлч нохойн сургалтын төвд 2, Замын-Үүд дэх гаалийн газарт 2, Дорнод аймаг дахь гаалийн газарт 1, Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газарт 1, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт 1, Ховд аймаг дахь гаалийн газарт 1, Улаанбаатар хот дахь гаалийн газарт 1 тус тус томилогдсон. Тайлант хугацаанд нийт 7 удаагийн эрэлч нохойн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 52 албан хаагчийг суралцуулснаар гаалийн байгууллагад эрэлч нохойн	

						чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нарыг 100 хувь сургалтад хамруулан ажилласан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирлын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б.Наранбадрах, эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч Н.Ганболд нар үнэлгээний ажилтан бэлтгэх сургалтад хамрагдаж албаны нохойн чиглэлээр мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөлтийн үнэлгээ зохион байгуулах эрхтэй болсон. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				3. Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч нарын тоог 5 хувиар нэмэгдүүлж ажилласны үр дүнд албаны эрэлч нохойг ашиглан 20 зөрчил илрүүлэн ажилласан.	3. Эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж, зөрчил илрүүлэлтийг өмнөх оны мөн үеэс 5 хувиар нэмэгдүүлнэ.	2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар гаалийн 13 газар, хороодод ажиллаж байгаа 33 эрэлч нохой нийт 38 зөрчил илрүүлсэн. Үүнд: Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар 17 зөрчил, Замын-Үүд дэх гаалийн газар 8 зөрчил, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар 3 зөрчил, Дорнод аймаг дахь гаалийн газар 2 зөрчил, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар 3 зөрчил, Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газар 5 зөрчлийг тус тус илрүүлэн ажилласан. Илрүүлсэн зөрчлийн тоон үзүүлэлтийг 2023 онтой харьцуулахад 90% -аар өссөн үзүүлэлт болж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.8	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд “Бараа бүртгэлийн нэгдсэн систем”-ийг ашиглах	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, хувиар	1. Ашигт малтмалын экспортын гэрээг “Бараа бүртгэлийн нэгдсэн систем”-д бүртгэн, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд 100 хувь ашигласан. Гаалийн автоматжуулсан КАИС системээс гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг “Бараа	1.“Бараа бүртгэлийн нэгдсэн систем” бүрэн ашиглалтад орсны дараа гаалийн мэдүүлэг тус бүрээр барааны борлуулалтын мэдээг авч, гаалийн хяналт шалгалт болон бүрдүүлэлтийн дараах	Тайлант хугацаанд “Бараа бүртгэлийн нэгдсэн систем” бүрэн ашиглалтад ороогүй. ГЕГ-ын Мэдээллийн технологийн газар, Гааль, татварын мэдээлэл технологийн төвтэй уулзалт хийж, бар код үүссэн барааны борлуулалтын мэдээг авч, хяналт, шалгалтад ашиглах талаар бодлогын даалгавар өгсөн. Санхүү, мэдээллийн технологийн төвөөс “Бараа бүртгэлийн нэгдсэн систем”-ээс барааны борлуулалтын мэдээг Гаалийн байгууллага руу илгээхэд цаг хугацаа шаардлагатай байгаа учир энэ ажлын гүйцэтгэл удаашралтай байна гэсэн тайлбарыг өгсөн. Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас шалгалтад хамруулж, шалгасан нийт 800 гаруй бар кодтой	95 хувь

				бүртгэлийн нэгдсэн систем” рүү өдөр бүр илгээж байна. Тайлант хугацаанд 8 ААН, 350 мэдүүлгийн 10215 бар кодтой бараанд бүрдүүлэлтийн дараах шалгалт явуулсан зөрчил илрээгүй байна.	шалгалтад ашиглаж, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.	барааны 16 буюу 2 хувьд нь зөрчил илэрч, 952.3 сая төгрөгийн зөрчлийн дүн бүхий бараанд нийт 161.2 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийг ногдуулсан. Өмнөх оны суурь түвшинд бар кодтой бараанд зөрчил илрээгүй бөгөөд суурь түвшин нь 0 хувь байсан бол 2024 онд бар кодтой 16 бараанд зөрчил илэрсэн нь суурь түвшнээс 16 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй. Гаалийн байгууллагаас шалтгаалах арга хэмжээ бүрэн авагдсан.	
				2.Гаалийн автоматжуулсан КАИС системээс гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг “Бараа бүртгэлийн нэгдсэн систем” рүү өдөр бүр илгээж байна. Мөн шаардлагатай тохиолдолд “Бараа бүртгэлийн нэгдсэн систем”-ээс гаалийн мэдүүлгийн дугаар болон бүрдүүлэлт хийсэн аж ахуйн нэгж, иргэний регистрээр дуудаж мэдээллийг авах боломжтой веб сервисийг хөгжүүлж нэвтрүүлсэн.	2.Бараа бүртгэлийн нэгдсэн системийг бүх аж ахуйн нэгж, иргэд бүрэн ашиглаж жигдрүүлсэн байна.	Бараа бүртгэлийн нэгдсэн систем нь хилээр орж, гарч буй бараанд баркодоор хяналт хийх зориулалттай систем бөгөөд гаалийн мэдүүлэг нөхөн бичих үед баркодыг оруулах, баркодыг оруулаагүй гаалийн мэдүүлгийг “Бараа бүртгэлийн нэгдсэн систем”-ээс нөхөж оруулах боломжтой. Гаалийн мэдүүлэгт нөхөн бичихэд барааны баркодыг дараах байдлаар оруулах хөгжүүлэлтийг хийж, систем рүү мэдээллийг цахимаар илгээж байна. • Бараа бүртгэлийн нэгдсэн системийн баркодын сангаас татах, • Лабораторийн дүгнэлтээс татах, • Эм, эмнэлгийн хэрэгслийн импортын лицензээс татах, • ОАТ архи, согтууруулах ундааны акц, лицензээс татах, • Автомашин, уул уурхайн бүтээгдэхүүн зэрэг баркодгүй задгай бараанд гаалийн системээс автомат баркод үүсгэх, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар импортын мэдүүлгийн 276,592, экспортын мэдүүлгийн 676,775 бараанд баркодтой бүрдүүлэлт хийж, илгээсэн байна. Нэмэлтээр лабораторийн дээжид харгалзах үр дүнг нөхөн бичих явцад онцгой албан татвар бүхий бараануудын баркодыг Бараа бүртгэлийн нэгдсэн системээс татан авч, шалган харгалзах БТКУС-ийн код байхгүй үед тухайн баркодод харгалзах БТКУС-	

						ийн кодыг баркодын сан руу илгээх хөгжүүлэлт хийсэн. Мөн Онцгой албан татвартай архи, согтууруулах ундааны гаалийн бүрдүүлэлтэд баркодод үндэслэн ХХААХҮЯ-аас олгодог импортын лицензийг цахимаар татах, ТЕГ-ын цахим системд Онцгой албан татварын акцыг захиалахад мэдүүлгийн баркодод үндэслэн захиалах хөгжүүлэлт хийж, нэвтрүүлсэн. Худалдааг хөнгөвчлөх, хил дээрх урсгалд ачаалал өгөхгүйн тулд гаалийн мэдүүлэгт баркод нөхөн бичээгүй тохиолдолд татвар төлөгч системийг ашиглан гаалийн мэдүүлэгт баркод нөхөн оруулах, хэрэглээг ТЕГ-аас жигдрүүлэх шаардлагатай. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн. Аж ахуйн нэгж, иргэдийн ашиглалт хангалтгүй.	
4.9	Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн КАИС системд эрх бүхий албан тушаалтнууд цахим гарын үсгээр нэвтрэх боломжийг бүрдүүлж, бүртгэлийг хийсэн. ГЕГ-ын дарга нар болон бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн ГУАБ, ГУБ нарын 69 тоон гарын үсгийн төхөөрөмжийг холбон, хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Системийн хэмжээнд бүх байцаагч нарт тоон гарын үсэг олгох ажил төсөв хөрөнгөний	1.Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг	-Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга болон ахлах байцаагч, байцаагч нарын нийт 47 ш тоон гарын үсгийн хугацааг сунгаж, шаралт хийж, CAIS системтэй холбосон. -Замын-Үүд дэх гаалийн газрын 121 ш тоон гарын үсгийн 1 жилийн сунгалтыг хийж, шарж, CAIS системтэй холбон хүлээлгэн өгсөн. -Улаанбаатар хот дахь гаалийн газрын 140ш тоон гарын үсгийн шарах ажил хийгдэж байна. Мөн харьяа гаалийн газар, хороодын дарга нарын 14 ш тоон гарын үсгийг шарж бэлэн болгож, тараах ажлыг хийж байна. -ГЕГ-ын дарга болон хэлтсийн дарга нарт тоон гарын үсгийн гэрчилгээ суулгаж авсан бөгөөд гаалийн үндсэн систем болох CAIS системтэй холбож, хэрэглээнд нэвтрүүлсэн. -Замын-Үүд дэх гаалийн газар, Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт тоон гарын үсгийн гэрчилгээг 1 жилийн хугацаатай суулгаж хүлээлгэн өгсөн бөгөөд CAIS, CEPS, CIMS систем рүү нэвтрэн хяналт шалгалтад ашигладаг болсон. Нийт 540 тоон гарын үсгийн төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. -Замын-Үүд боомтын ЗТШНЦ-т ашиглаж байгаа	93.3 хувь

				асуудлаас болж эхний ээлжид ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын дарга, ГУАБ нарт олгохоор болсон.	болсон байна.	ухаалаг гарцын системийн хэвийн ажиллагааг хангуулах, тоон гарын үсгийг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулсан. -Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан хаагчдын тоон гарын үсгийг нэвтрүүлэх, чөлөөт бүсийн зорчигчийн бараа бүртгэлийн бар код хэвлэгчийг шалгах программын түвшний тест хийж, сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангаж ажилласан. -Гашуунсухайт дахь гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газрын материалыг бүрдүүлэх ажил хийгдэж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				2.Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөлтэй танилцаж, хэрхэн хэрэгжүүлэх талаар судалгаа хийсэн.	2.Төрийн болон төрийн бус байгууллагатай харилцахдаа тоон гарын үсгийг ашиглаж эхэлсэн байна.	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй албан бичиг цахимаар солилцох ажлын хүрээнд ДОСХ дундын системтэй архив, бичиг хэргийн систем болох ИДок систем ГЕГ болон харьяа гаалийн 19 газар, хороод бүрэн холбогдсон ба тус дундын системээр дамжуулан төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн 4000 гаруй байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан баталгаажуулалт хийж, албан бичиг солилцох ажлыг бүрэн нэвтрүүлсэн.	
				3.RIBS төслийн хүрээнд хийгдэж байгаа Гаалийн автоматжуулсан мэдээллийн системд Тоон гарын үсэг ашиглан нэвтрэх хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.	3.Олон улсын байгууллагатай харилцахдаа тоон гарын үсгийг ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.	Олон улсын автозамын холбоо IRU-тай ТИР карнейн урьдчилсан мэдээллийг цахимаар солилцох сервис хөгжүүлэлтэд нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад тоон гарын үсгийн токен ашигласан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.10	Гаалийн мэдээллийн системүүдийг боловсронгуй болгож, мэдээллийн сүлжээний аюулгүй	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд хөдөлгөөнт төхөөрөмж худалдан авсан.	1.Гаалийн мэдээллийн системийг хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр бүрэн ашиглах боломжийг	Тоон гарын үсэг ашиглаж буй гаалийн улсын байцаагч нар суурин компьютер бус хөдөлгөөнт төхөөрөмжөөс CAIS системд нэвтрэх шаардлагатай байдаг тул тухайн хөдөлгөөнт төхөөрөмжийг ашиглан CAIS системд нэвтрэхэд заавал тоон гарын үсэг шаардахгүй, нэр, нууц үгээр нэвтрэх боломжоор хангасан. Үнэлгээ: 80 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	76.6 хувь

	байдлыг бий болгох			2.Гаалийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд: - Засгийн газрын 2018 оны 30 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-д багтсан байгууллагуудад шаардлага ирүүлсний дагуу гаалийн системийн хэмжээнд ашигладаг интернэтийн урсгалын гарах гарцыг Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлын газрын “ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ”-нд	бүрдүүлсэн байна. 2.Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын техник, сүлжээ болон программ хангамжийн судалсан шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Дата төвийн сүлжээний дэд бүтэц анх 2009 онд сүлжээний дотоод дамжих дээд хурд 100 Megabit байхаар төлөвлөгдсөн ч одоог хүртэл хэрэглэж байгаа учир өгөгдлийн хэмжээ томорч, сүлжээ удаашрах, гацалт доголдол үүсэх эрсдэлтэй байдалд хүрч байна. Иймээс дата төвийн сүлжээний бүтцийн тоног төхөөрөмжүүдийг шинэчилж сайжруулахаар Cisco, Fortinet компаниудын монголын зах зээлийг хариуцсан мэргэжилтнүүдтэй тус бүр цахим уулзалт хийж, манай байгууллагад нийцтэй тоног төхөөрөмжийн шийдлийн талаарх санал солилцсон ба дата төвийн сүлжээний дэд бүтцийн логик план зургийг сүүлийн үеийн өндөр хурдны 25Gigabit/100Gigabit шилэн кабелийн төлөвлөлттэй байх судалгааг гаргаж, АХБ-нд хүргүүлсэн. Тус хүсэлтийн дагуу дата төвийн үндсэн дэд бүтцийн сүлжээ болон хамгаалалтын төхөөрөмж “Firewall” тоног төхөөрөмж худалдан авч, хуучин тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулж, ажиллагаанд оруулсан. Тус тоног төхөөрөмжийг ажиллагаанд оруулснаар Дата төвийн дотоод болон гадаад хурд нь 1000 дахин нэмэгдэж, систем хооронд мэдээлэл дамжуулах, гадаад урсгалын аюулгүй байдлыг бүрэн хангах тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, ажиллагаанд оруулсан. -Харьяа гаалийн газар, хороодын телехяналтын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах тог тогтворжуулагч гэмтлийг тодорхойлж, засварлуулах боломжгүй төхөөрөмжийн судалгааг хийсэн. -Мөн харьяа гаалийн газар, хороодод ашиглаж байгаа сүлжээ, сервер бусад дагалдах тоног төхөөрөмжүүдэд тогтмол хяналтыг тавьж, эвдрэл гэмтлийг тодорхойлж, шаардлагатай сэлбэг хэрэгслийн судалгааг хийсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
--	--------------------	--	--	--	---	---	--

				холбож аливаа халдлагын улмаас учирч болох эрсдэлээс давхар хамгаалагдсан. 3.Албан хаагчдыг ажлын компьютероос албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах явдлыг хянах боломжийг бүрдүүлж, Гаалийн ерөнхий газрын албан хаагчдын компьютерыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбосон.	3.Албан хаагчдыг ажлын компьютерээс албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах явдлыг хянах боломжийг бүрдүүлж, харьяа 18 гаалийн газар, хорооны албан хаагчдын компьютерыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбоно. Ингэснээр ажилтан, албан хаагчид мэдээллийг ямар зорилгоор системээс авч байгаад хяналт тавих боломж бүрдэнэ.	3. Харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдын компьютерыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбох ажлын хүрээнд газар, хороо тус бүрийн 1 компьютерийг домайнд холбож, тус домайн эрхийг tableau программд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Домайн эрхийг харьяа гаалийн газар, хороодын tableau хариуцсан ажилтанд хариуцуулан өгөхөөр ажиллаж байна. Үнэлгээ: 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай.	
4.11	Гаалийн байгууллагын хууль тогтоомж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах,	Үйл ажиллагаа	Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар	Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой 188 мэдээ, 312 пост мэдээллийг түгээсэн.	Гаалийн байгууллагын олон нийтэд хүргэх мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, улирал бүр нэвтрүүлгийг бэлтгэн гаргаж,	Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон гаалийн холбогдолтой хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, ажлыг зохион байгуулж, тайлант хугацаанд 27 мянган дагагчтай “Монголын гааль” фэйсбүүк пэйж хуудсанд 409 мэдээ, мэдээлэл оруулснаас 91 видео, 38 рийл, 125 фото зурган мэдээ, 148 постер мэдээ, мэдээлэл нийтэлсэн байна. Шинээр 3 лайв, 4 линкээр мэдээ оруулсан. Мөн www.customs.gov.mn веб хуудсанд 180 мэдээ, 103 постер мэдээлэл боловсруулан оруулжээ. Мөн мэдээ	100 хувь

	хүртээмжийг нэмэгдүүлэх				олон нийтэд хүргэх мэдээллийн тоог өмнөх оныхоос 5-аас доошгүй хувиар өсгөнө.	мэдээллийн сайтуудаар 311 мэдээ, өдөр тутмын сониноор 45 мэдээ, телевизийн сувгаар 230 мэдээ, радиогоор 63 мэдээлэл түгээсэн байна. Энэ нь Монголын гааль пэйжид өмнөх онд 312 пост мэдээлэл нийтэлсэн бол энэ онд 409 пост мэдээллийг түгээсэн нь өмнөх оноос 31%-аар өссөн байна. https://www.customs.gov.mn/ веб хуудсанд өмнөх онд 188 мэдээ, мэдээлэл нийтэлсэн бол энэ онд 283 мэдээ, мэдээллийг нийтэлж өмнөх оны мөн үеэс 51% өссөн үзүүлэлттэй байна. Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй ташаа мэдээлэл, нийгмийн үнэлэмжийг бууруулах сөрөг мэдээллүүдэд 8 удаагийн хариу арга хэмжээг авч сөрөг мэдээллийг залруулж олон нийтэд зөв, эерэг мэдээлэл өгөх зорилгоор 4 удаагийн хэвлэлийн бага хурал, 4 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгийг хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулсан нь өмнөх оноос 0,6%-аар өссөн. “Бидний нэг” гаалийн албан хаагчдыг сурталчилсан 4 видео контентыг хийж, олон нийтэд түгээсэн. Дээрх 4 контентыг нийт 19,295 хүн үзсэн байна. Гаалийн байгууллагын олон нийтэд хүргэх мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, улирал бүр 1 нэвтрүүлэг бэлтгэн гаргаж, гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, албан хаагчдын ажил амьдралыг олон нийтэд эерэг талаас нь сурталчилсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.12	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга ёсыг эрхэмлэн ажиллах	Үйл ажиллагаа	ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтын тоо, хувиар, Гаалийн байгууллагын шударга байдлын үнэлгээг өсгөх зорилгоор зохион байгуулах ажлын тоо, хэрэгжилт	1.Өмнөх оны Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих 1456 төрийн тусгай албан хаагчаас 1456 албан хаагч ХАСХОМ-ээ гаргасан бөгөөд бүгдийг 100%	1.Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны	”Авлигын эсрэг хуулийн 10.3-т заасны дагуу Гаалийн байгууллагын нийт 1,447 албан хаагчийн 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж, тайланг нэгтгэн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 01/714 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн энэ хуулийн 10.4-т заасан тайлангийн хугацаанд 3 албан хаагч их хэмжээний өөрчлөлт мэдүүлж, цахим санд баталгаажуулсан. Гаалийн байгууллагад	100 хувь

			гүйцэтгэлээр.	баталгаажуулсан. Мөн сэлгэн ажиллах болон шинээр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 445 албан хаагчийн ХАСУМ-ыг хүлээн авч, АТГ-т хянуулсан. Хугацаа хоцроосон болон ХАСХОМ мэдүүлээгүй албан хаагч байхгүй.	маягтыг хуулийн хугацаанд хүлээн авч, 100 хувь баталгаажуулсан байна.	томилогдохоор шинээр, шилжин болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 502 албан хаагчийн ХАСУМ-ийг шинээр нээж, бүртгэл хөтлөн холбогдох материалын хамт 66 удаагийн албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, 496 ХАСУМ хянагдан ирснээс 3 зөрчилтэй, 17 зөрчил үүсэж болзошгүйг анхааруулсан, 1 мэдүүлгийг буцаасан. Зөрчилтэй дүгнэлт ирсэн 3 албан хаагчаас 2, анхааруулсан 17 албан хаагчаас 2, нийт 4 албан хаагчийг албан тушаалд томилохоос татгалзсан байна. Мөн шинээр томилогдож байгаа ажилтнаас үйл ажиллагаандаа ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах баталгааны хуудас болон Захиргааны ерөнхий хуулиар Захиргааны шийдвэр, албан хаагчдын хүний нөөцийн томилолт, чөлөөлөлттэй холбоотой асуудлаар тухай бүр сонсох ажиллагааг хийж, оролцогчийн саналыг тусгаж байгаа бөгөөд захиргааны шийдвэрийн төсөлд үндэслэл хэсгийг тусган төслийг хянах албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаараа мэдэгдэн гарын үсэг зурж баталгаажуулан ажилласан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			2. АТГ-ын Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтад 131 албан хаагчийг хамруулсан байна	2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Үүнд: -АТГ-ын Олон нийтийн төв / https://iaas.mn/ фэйсбүүк пэйж хуудсанд байршуулсан контентуудаас “Авлигын эсрэг нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилъе” гэсэн уриатай нийт 11 контентыг Гаалийн байгууллагын албан ёсны “Монголын гааль” https://customs.gov.mn/ фэйсбүүк пэйж хуудас болон харьяа 19 гаалийн газар, хороодын фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилсан. ГЕГ, АТГ-тай хамтран Гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 3 минутын видео шторкийг хийж “Монголын гааль” фэйсбүүк пэйж хуудас болон харьяа 19 гаалийн газар, хороодын фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажилласан. Мөн ГЕГ-ын харьяа Орхон аймаг дахь гаалийн газраас “Бид төрийн тусгай албан хаагчид, авлигын эсрэг хамтдаа нэгдье” сэдвийн хүрээнд “Авлигын эсрэг хамтдаа		

		нэгдье” видео контент /42 секунд/ -ыг хийж, https://orkhon.customs.gov.mn/ пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажилласан. -Гаалийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан харьяа гаалийн газар, хороодод 34 нээлттэй хаалганы өдөрлөгөөр гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан, авлигын хор хөнөөлийг ойлгуулсан, авлигын эсрэг нэгдэхийг уриалсан агуулга бүхий нийт 54 төрлийн брошюр, гарын авлага, хэвлэмэл материалыг хийж, нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд тараан ажилласан. Брошюр, гарын авлага, хэвлэмэл материалын арын доод буланд авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан. <u>-ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвд:</u> Гаалийн байгууллагын албан хаагч нарт болон гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт АТГ-ын “Авлигын гэмт хэрэг, шалтгаан, хор хөнөөл” сэдвээр нийт 4 удаагийн 8 цагийн, “Гаалийн улсын байцаагчийн ёс зүй ба авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 40 цагийн буюу нийт 48 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 987 суралцагч /АТГ -ын сургалтад -207/ хамрагдсан. <u>-Харьяа 19 гаалийн газар, хороодод:</u> Харьяа 19 гаалийн газар, хороодод 112 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1401 албан хаагчийг хамруулсан байна. <u>-Албан хаагчаар баталгаа гаргуулсан талаар:</u> Гаалийн байгууллагын хэмжээнд албан хаагчаар бүрээр Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, ЗГ-ын 2009 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм", Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 534 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”, 2016 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт”, 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын	
--	--	---	--

		хөдөлмөрийн дотоод журам"-ыг чанд мөрдүүлэн, хэрэгжилтийг хангуулахаар 1046 албан хаагчаар баталгаа гаргуулан авч нэгтгэсэн. /баталгаа гаргавал зохих 1226 албан хаагчаас баталгаа гаргасан 1046, баталгаа гаргаагүй 180 үүнээс өвчтэй 16, чөлөөтэй 34, ээлжийн амралттай 85, бусад 45/. <u>-Гаалийн байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулах чиглэлээр:</u> Сангийн сайдын 2024 оны 6 дугаар тушаалын дагуу ГЕГ-ын даргын 2024 оны А/123 дугаар тушаалаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийг 7 хүний /ТТ-7/ бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Уг нэгж нь гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй. Гаалийн байгууллагын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой байж болзошгүй асуудлыг шалгуулахаар 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01-5/1279, 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01-5/4873, 11 дүгээр сарын 21-ны өдрийн 02/4849 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт, 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1611 албан бичгээр Цагдаагийн ерөнхий газарт 11 гаалийн улсын байцаагч нарыг шалгуулахаар тус тус шилжүүлэн ажилласан. Дотоод хяналт, аюулгүй байдлын чиг үүргийг харьяа 19 гаалийн газар, хороодын албан хаагчдад танилцуулан ажилласан. 2024 оны эхний 5 сарын байдлаар гаалийн байгууллагын албан хаагчидтай холбоотойгоор Засгийн газрын 11-11, Гаалийн лавлах 1800-1281 утсанд ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар танилцуулга хийж ажилласан. Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байх чиглэлээр харьяа 19 гаалийн газар, хороодод 01-2/447, 01-2/448, 01-2/449 албан бичгүүдээр чиглэл хүргүүлэн ажилласан. Мөн авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдохгүй, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах	
--	--	---	--

						БАТАЛГААНЫ МАЯГТЫН ЗАГВАР боловсруулж, шинээр томилогдож байгаа албан хаагчдаас баталгаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын сорил, хувийн мэдээллээ гаргаж өгөхөд татгалзахгүй гэсэн баталгааг авч, хувийн хэрэгт нь хийж хэвшсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
				3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдан гарсан.	3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна.	УИХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан бөгөөд АТГ-аас 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 03/9364 албан бичгээр ГЕГ-т ирүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т биелэлтийг тайлагнаж байхаар тусгасан байна. Мөн “Хөтөлбөрийн төлөвлөлт, тайлагналтын тухай” АТГ-ын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 08/17576 албан бичиг ГЕГ-т ирсэн.Тус албан бичгээр 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээг тусган, хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг, 2024 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг мэдэгдсэн. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн дагуу “Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө”-г боловсруулж, ГЕГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх албан бичгүүдийн дагуу 2024 оны тайланг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөр тайлагнахаар ажиллаж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.13	Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, эрсдэлд суурилсан дотоод аудит хийх,	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. 2023 оны 3 дугаар сард шинэчлэн хийсэн байгууллагын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн 2023 оны 11 дүгээр сард ГЕГ-ын удирдах ажилтнууд	1.Байгууллагын эрсдэлийн удирдлагын үр нөлөөг сайжруулах чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж,	Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” тушаалаар ГЕГ-ын даргын шууд удирдлага дор Дотоод хяналт, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж байгуулагдаж, дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд: Харьяа гаалийн газар, хороодод Чиглэл хүргүүлэх	95.2 хувь

	холбогдох зөвлөмжийг хүргүүлэх			болон албан хаагчдын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгууллагын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хариуцах гол нэгж, хугацаа, гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлсон үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	өгөгдсөн зөвлөмжийн дагуу илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага дотоод эрсдэлийг тооцож, үр дүнг шийдвэр гаргахад ашиглана.	тухай 01-5/1741 албан бичгийг хүргүүлсний дагуу нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож ажилласан талаарх тайланг авч нэгтгэсэн. Үүнд нийт нэгжийн үйл ажиллагааны үндсэн эрсдэлийг дүгнэхэд 1-т хүний нөөцийн эрсдэл, 2-т гадна орчны эрсдэл гэж тодорхойлж болохоор байна. Замын-Үүд боомтоор улсын хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлд эрсдэл тооцож, бүртгэлгүй 242 тээврийн хэрэгслийг шалгаж, АТТ болон чиг үүргийн ажлаа хуулийн дагуу хэрэгжүүлээгүй 14 гаалийн улсын ахлах байцаагчийг сахилгын хороонд шилжүүлж, эхний 5 гаалийн улсын ахлах байцаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. Улсын хилээр бүргэлгүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн дээрх 14 гаалийн улсын ахлах байцаагчийг шалгуулахаар ЦЕГ, АТГ-т шилжүүлсэн. www.negun.mn сайтын сошиалд тавьсан мэдээллийн дагуу албаны шалгалт хийж, Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын нэр бүхий 3 албан хаагчдын үйл ажиллагаанд албаны шалгалт хийж, гэм буруутай байх үйлдлийг тогтоож, АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн байна. Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч нартай холбоотой брэндийн цүнх, гоёл чимэглэлийн /алтан/ зүйлсийг гаалийн улсын байцаагч хулгайлсан гэх, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын гаалийн улсын байцаагч нар гоо сайхны бараа, гоёл чимэглэлийн зүйлсийг хулгайлсан гэх үйлдлийг тус тус шалгаж, тус албан хаагчид гэм буруугүйг тогтоож, Хэвлэл мэдээллийн төвөөр дамжуулан олон нийтэд танилцуулсан. Уг ажлын хүрээнд тус газрын “гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг эрсдэлтэйд тооцож, хяналт шалгалтын технологи ажиллагаа зөрчигдсөн” талаар мэдээлэл бэлтгэн, гаалийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг өгч, албан тоот хүргүүлж, зөрчлийг арилгуулсан. Гаалийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох зорилго бүхий санал асуулгыг нийт 19 газар, хороодын 1069 төрийн төрийн албан
--	--------------------------------	--	--	---	--	--

					хаагчдаас авч нэгтгэсэн. Санал асуулгаар 1-рт: Хүний нөөцийн эрсдэл, 2-рт: Удирдах албан тушаалтанаас удирдлагын манлайлал, чадвар, хамт олныг багаар нь удирдах чадвар дутуу, 3-рт: Гаалийн хяналт шалгалтын болон бусад тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл гэх мэт эрсдэлүүдийг жагсааж болохоор байна. Мөн албан хаагчдын аюулгүй байдал, хөдөлмөрч, амьдрах нөхцөл, байгалийн давагдашгүй хүчин зүйл ой хээрийн гал түймэр, үерийн усны аюул, албан хаагчдыг болон улсын өмч хөрөнгийг хамгаалах ажлууд тухай бүрт хийгдэж, үр дүнд хүрч байсан. Санал асуулгын дүнд үндэслэн газар, хороодын дарга нарт чиглэл хариуцсан албан тушаалтанд чиглэл хүргүүлж ажилласны үр дүнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. <u>Хүний нөөцийн хүчин зүйлийн эрсдэлийг бууруулах талаар:</u> Орон тооны бүтцийн дагуу дутуу албан хаагчийг томилуулах талаар газар, хороодын дарга нар ГЕГ-т албан тоот хүргүүлж шаардлагатай албан хаагчийг томилуулж байна. <u>Удирдах албан тушаалтнаас удирдлагын манлайлал, чадвар, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх талаар:</u> Судалгаанд хамрагдсан гаалийн газар, хороодын дарга нартай хэлтсийн даргын зүгээс ганцаарчилсан цахим ярилцлагыг хийж, нэгжийн санал асуулгын дүнг танилцуулж холбогдох чиглэл өгч ажилласан. <u>Хяналт шалгалт болон тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах талаар:</u> Судалгаанд хамрагдсан нэгжүүдийн хяналтын тоног төхөөрөмжийн судалгааг өөрсдөөр нь хийлгэж, шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн нэрсийг гаргаж, ГЕГ-ын холбогдох нэгжид хүргүүлсэн. Тус хэлтэс нь албан хаагчдын амьдрах ажиллах орчныг сайжруулах чиглэлээр албан тоотыг нэгжүүдэд хүргүүлсэн бөгөөд харьяа газар, хороодоос өөрсдийн нөөц бололцоонд тохируулан ажлын байранд болон ажилчдын амьдрах байруудад урсгал засвар үйлчилгээг хийсэн тайланг ирүүлсэн. ГЕГ-ын барилга байгууламжийн аюулгүй байдал,	
--	--	--	--	--	---	--

					ажилтан албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ГЕГ-ын харуул хамгаалалтыг хариуцсан ажиллаж буй “Шүтээн уул” ХХК-тай хамтран ажиллах, харуул хамгаалалтын ажилтны хийж гүйцэтгэх үүргийг тодорхой болгож дагаж мөрдөх журмыг боловсруулж баталсан. Өмнөх оны 10 удаагийн дотоод аудитын үр дүнгээр өгөгдсөн нийтлэг болон тусгайлсан 259 зөвлөмжийг ЗДАС программаар хүргүүлж улирал, хагас жилийн хугацаанд хэрэгжүүлсэн биелэлтийг хянахад 87.85%-тай гарсан. Эдгээрээс гүйцэтгэлийн үр дүн гартал үргэлжлүүлэх шаардлагатай 35 зөвлөмжийг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлтийг эргэн хянасан талаар тайланг ГЕГ-ын Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр газрын удирдлагад танилцуулсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			2. ГЕГ-ын 4 бүтцийн нэгжийн 2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэж, “Сайжруулалт шаардлагатай” гэж дүгнэсэн ба ажлын тайланг нэгтгэн, зөвлөмжийг хүргүүлэв. -ГЕГ-ын харьяа нийт 6 газар, хороонд дотоод аудитыг гүйцэтгэж, Хангалттай, Сайжруулалт шаардлагатай гэж дүгнэсэн ба ажлын тайланг нэгтгэн, зөвлөмжийг хүргүүлэв.	2. Гаалийн ерөнхий газрын 2-3 зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон 18 харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийнэ.	2024 онд 7 дотоод аудит хийгдэхээс 6 аудитыг хийж гүйцэтгэв. Үүнээс ГЕГ-ын нэгжүүд болох: <u>-Барааны ангилал, үнэлгээний хэлтэст:</u> “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт гарч 16 зөвлөмжийг хүргүүлж, эргэн хянаж, хэрэгжилт дутуу 4 зөвлөмжийг дахин хүргүүлж, үнэлэхэд 75.37%-ийн биелэлттэй гарав. <u>-Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт:</u> “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт гарч, 23 зөвлөмж, 2 саналыг тус газарт хүргүүлж, эргэн хянахад 73.48%-ийн хэрэгжилттэй гарав. <u>-Хяналт, бүрдүүлэлтийн газарт:</u> “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт гарч 35 зөвлөмжийг хүргүүлсэн. Дүгнэх хугацаа 2025 онд. <u>-Зөрчилтэй тэмцэх газарт:</u> “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт гарч 21 зөвлөмжийг хүргүүлсэн. Дүгнэх хугацаа 2025 онд. <u>Харьяа гаалийн газар, хороодоос:</u> -Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт: “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт гарч 28 зөвлөмжийг хүргүүлсэн. Дүгнэх хугацаа 2025 онд. -Шивээхүрэн дэх гаалийн газарт: “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт гарч 14 зөвлөмжийг хүргүүлсэн. Дүгнэх хугацаа 2025 онд. Үнэлгээ: 85.7 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	

				3.Дотоод аудит хийсэн нэгж, харьяа гаалийн газруудад аудитын үр дүнгээр гарсан зөвлөмжийг хүргүүлэн, алдаа, дутагдлыг арилгуулж, хэрэгжилтийг хангуулав.	3.Дотоод аудит хийсэн нэгжүүдэд тайлан, зөвлөмжийг хүргүүлэн, алдаа, дутагдлыг арилгуулж, хэрэгжилтийг хангуулна.	Дотоод аудитын үр дүнгээр нийт 157 зөвлөмжийг хүргүүлсний 60 зөвлөмжийн биелэлт 76 хувиар үнэлэгдсэн ба үлдсэн 97 зөвлөмжийг 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр үнэлнэ. -Гаалийн байгууллагын эрсдэлд суурилсан 2023-2025 оны дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөний нийт 4 зорилт, 12 зүйл бүхий 18 арга хэмжээний 2023 оны биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн хувь 86.25 буюу Хэрэгжих шатанд, 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг 93.93% буюу Бүрэн хэрэгжсэн гэж үнэлэв. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.14	Байгууллагын төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн сахилга батыг хангах, төлбөр тооцооны цахим системд шилжих	Үйл ажиллагаа	Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, Гэрээний биелэлтийн үнэлгээгээр,	1.2023 онд гаалийн байгууллагын хөрөнгө оруулалтын зардалд 29,0 тэрбум төгрөг урсгал зардалд 85,0 тэрбум төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийг 11 дүгээр сарын 30-ны байдлаар 26.4 тэрбум төгрөгөөр хэмнэж, тайлант хугацаанд өглөг, авлага үүсгэлгүй ажилласан.	1.Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн, батлуулж, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулсны үндсэн дээр үүссэн хэмнэлтийн хувь хэмжээ өмнөх оноос буураагүй байна.	Гаалийн байгууллагын 2024 оны төсвийн төслийн саналд 141.2 тэрбум төгрөгийн саналыг тусган Сангийн яаманд хүргүүлснээс урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 137.5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 62%-аар буюу 52.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Гаалийн байгууллагын батлагдсан төсвийг харьяа гаалийн газар, хороодод хуваарилахдаа 2023 оны төсвийн гүйцэтгэл, ажиллаж буй орон тоо, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах бусад хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилж, Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр, авлага үүсгэхгүй байх чиглэлээр төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан ажиллалаа. Тайлант хугацаанд харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн үндсэн болон нэмэгдэл цалин, унаа хоолны хөнгөлөлт, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлууд, төрийн тусгай албан хаагчийн сэлгэн ажилуулалт болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн тоотой уялдуулан үр дүнгийн урамшууллын зардал, боомтуудын бүтээн байгуулалттай холбоотой байр ашиглалтын зардлууд, автомашинуудын урсгал засвар, тээвэр, шатахууны зардал, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлсэн албан хаагч болон нас барсан албан хаагчийн ар гэрт олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, бичиг хэрэг,	96 хувь

					улсын мэдээллийн маягт хэвлэх зардал, шуудан холбоо, багаж техник хэрэгсэл, дотоод албан томилолт, мэдээлэл технологийн үйлчилгээ, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал, тээврийн хэрэгслийн татвар, даатгалын үйлчилгээ, газрын төлбөр, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах ажилчдын орон сууц, хилийн боомтуудын урсгал засвар, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудын нийт 220 саналыг тооцоо, судалгааг үндэслэн төсвийн хуваарьт 11 удаагийн өөрчлөлт оруулж, 106.3 тэрбум төгрөгийг хуваарилан, зарцуулалтад хяналт тавьж ажилласан. Мөн харьяа гаалийн газар, хороодын туслах үйл ажиллагааны орлогын мэдээг сар бүрийн 01-ний өдрийн дотор, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 05-ны өдрийн дотор гаргуулан авч хянан, нэгтгэж, Гаалийн байгууллагын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Сангийн яаманд цаг хугацаанд нь хянуулан ажилласан. Гаалийн байгууллагын 2024 оны нийт батлагдсан төсвөөс 11 сарын байдлаар 114'617.6 сая төгрөгийн урсгал зардлын төлөвлөгөөтэй ажиллаж 96'639.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 17'978.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. Тайлант оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэл бүрэн санхүүжигдээгүй байгаа тул бодит хэмнэлтийг тооцох боломжгүй байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			2.Гаалийн байгууллага 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөндөө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 3 арга хэмжээ, нээлттэй тендер шалгаруулалтаар 3 арга хэмжээ,	2.Тайлант оны худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулан шинээр өглөг, авлага үүсгээгүй байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай тухай хуулиар Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд шилжих ангиллаар 15,285.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр батлагдсан. Үүнд: • Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилга /Увс, Улаангом сум/ 785.2 сая төгрөг, • Гаалийн шинэчлэл - ГЕГ, харьяа гаалийн газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт /Улсын хэмжээнд/ 14,500.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ батлагдан хэрэгжиж байна. Үүнд: -Гаалийн хяналт шалгалтын “Ухаалаг гарц” иж бүрдэл тоног төхөөрөмж 3,600.0 сая төгрөг,	

				ерөнхий гэрээгээр 8 арга хэмжээ, урсгал зардлаас нээлттэй тендер шалгаруулалтаар 12 арга хэмжээ, харьцуулалтын аргаар 26 арга хэмжээ төлөвлөн, ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу хугацаанд нь хэрэгжилтийг ханган, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны явцад тогтмол цаг үеийн хяналтыг хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнан ажилласан.		-Гаалийн хяналтын /рентген/ систем-10,900,0 сая төгрөгийн Санхүүжилт бүрэн хийгдсэн. Тайлант онд Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр тушаалаар 3,872.7 сая төгрөгийн 4 арга хэмжээний худалдан авах ажиллагаа, 213 дүгээр тушаалаар 3,090.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавих, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх, тайлагнахыг ГЕГ-т үүрэг болгосон. ГЕГ тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаж худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэгчийн нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээг хүлээн авах, гэрээ дүгнэх, санхүүжилтийг олгох зэрэг ажлыг бүрэн зохион байгуулан ажиллаа. Сангийн сайдын эрх шилжүүлсэн нийт 6'962.7 сая хөрөнгө оруулалтаас нийт 6'821.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 141.3 сая төгрөгийн хэмнэлт үүссэн. Гаалийн байгууллагын урсгал төсвөөр 2024 онд нээлттэй 20, харьцуулалтын аргаар 30 нийт 50 тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс нээлттэй 20 тендер зарлагдаж, тендер нээх хугацаа болоогүй 2 тендер, Сангийн яаманд гомдол гаргасан хянагдаж байгаа 1 тендер байна. Бүхэлдээ амжилтгүй болсон тендер байхгүй бөгөөд амжилтгүй болсон 3 багц байна. Амжилтгүй болсон 3 багцын 2 нь 3 удаа тендер зарласан боловч оролцогч байхгүй, 1 багц (албаны костюм) нь Сангийн яаманд гомдол гаргаж, бараа үйлдвэрлэх хугацаагүй болсон тул дахин зарлах боломжгүй болсон. Харьцуулалтын аргаар 30 тендер зарлагдаж 100 хувь амжилттай зохион байгуулагдан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулагдаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, бараа ажил үйлчилгээг хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийг олгох ажлыг зохион байгуулан ажилласан. Худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй тайланг холбогдох журмын дагуу боловсруулж, заасан хугацаанд нь СЯ-д хүргүүлсэн. Үнэлгээ: 88 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
--	--	--	--	--	--	---	--

				3.Гаалийн ерөнхий газрын төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2023 онд 96%-р дүгнүүлсэн. Гаалийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банк хөнгөлөлттэй зээл, БНХАУ-ын буцалтгүй тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Увс аймгийн Боршоо боомт, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт, Хөшгийн хөндий нэг цэгийн барилга, байгууламжийг улсын комисс хүлээн авч 2023 оны жилийн эцсийн байдлаар 100% ашиглалтад орсон.	3.Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт 96 хувиас дээш үнэлэгдсэн байна.	Гаалийн шинэчлэл, Боомтын сэргэлт төслийн хүрээнд 2019 оноос хойш гаалийн байгууллагын хэмжээнд бүтээн байгуулалт хийгдэж үндсэн хөрөнгө 142.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах үүднээс дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд: •Үндсэн хөрөнгийн бүртгэлийг QR кодоор кодлуулан бүртгэх ажлыг санаачлан хэрэгжүүлснээр хөрөнгө эзэнтэй болж, ашиглалт сайжирсан, мөн хөрөнгийн тооллыг цахимаар зохион байгуулдаг болсон. •Барилга байгууламж, үндсэн хөрөнгийн ашиглалт, үйл ажиллагааг сайжруулах үүднээс харьяа гаалийн газар, хороодод бусад хил хяналтын байгууллагуудын ашиглаж буй барилга байгууламжийн зай талбай, үндсэн хөрөнгийг “Ашиглалтын гэрээ” байгуулж, хариуцуулан ашиглуулах, албан хаагчидтай “Орон сууц түр эзэмшүүлэх гэрээ” байгуулах, гаалийн байгууллагын бүртгэлд байгаа газар, үл хөдлөх хөрөнгийн тооллого зохион байгуулах, албан хаагч нартай “Эд хөрөнгийн хариуцлагын гэрээ” байгуулах, мөн газар, хороод бүтэц орон тоондоо хяналтын тоног төхөөрөмж хариуцсан албан хаагчийг томилуулах саналыг холбогдох нэгжид хүргүүлж шийдвэрлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа. Тайлант онд Гаалийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулан хөрөнгө бүртгэлд тусгах, илүүдэлтэй болон ашиглагдахгүй байгаа хөрөнгийг шаардлагатай газар, хороодод шилжүүлэх, харьяа газар, хороодоос ирүүлсэн ашиглалтын шаардлага хангахгүй болсон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн судалгааг тус хурлаар хэлэлцүүлэн акталж данснаас хасах шийдвэр гаргуулахаар дээд шатны төсөв захирагчаар дамжуулан ТӨБЗГ-т уламжлах зэрэг асуудлыг шийдвэрлэн ажиллаа. Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 96 %-аар үнэлсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.15	Автозамын	БНХАУ-ын	Хэрэгжилт, хувиар	1.Алтанбулаг	1.Алтанбулаг	Ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмж: Монгол	77.4

	хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх	буцалтгүй тусламж, АХБ-ны хөнгөлөлттэй зээл, бусад хөрөнгө оруулалт		боомтын бүтээн байгуулалтын барилга байгууламж, автозам зогсоолын барилгын ажлын нийт гүйцэтгэл 92%-тай. Улсын комисс 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр, 1-р ээлжийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан.	боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.	Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд боомт руу орох, гарах хаалга болон боомт доторх замын эгнээнүүд дээр RFID-г суурилуулж, боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулахаар ажиллаж байна. -Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын экспортын хэсгийн 4, импортын хэсгийн 3 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн өдөртөө хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Тус боомтын шинэчлэл, бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор өнөөдрийн байдлаар нүүрсний гарах хэсэгт хяналтын бүс рүү орох 2, хяналт шалгалтын саравч доор суурилуулсан 4 ухаалаг гарцыг тогтмол ашиглаж байна. Гашуунсухайт боомтод 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нүүрс, зорчигч, зэсийн баяжмалын хэсэгт нийт 59 эгнээ, замд RFID-г суурилуулахаас 57 гарцад суурилуулсан төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас хүлээж авсан. Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын 7 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэж байна. -Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл /RIBS/-ийн хүрээнд АХБ-аас зохион байгуулах <u>Алтанбулаг боомтод</u> суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмж нийлүүлэх багцын тендер сонгон шалгаруулалтын ажил хүлээгдэж байна. -<u>Баянхошуу боомтын</u> техник эдийн засгийн үндэслэлийн /ТЭЗҮ/ тайлан магадлалаар хянагдаж баталгаажсан, төсөв нь экспертизээр хянагдаж байна. Тус боомтод суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн байршлыг тодорхойлохоор ГЕГ-аас 2024 оны 12 дугаар сард ажлын хэсэг ажиллахаар төлөвлөсөн байсан боловч хойшлогдсон. -“Монкон” ХХК-аас бүтээн байгуулалтын төслийн гэрээний хугацаа болон нэмэлт санхүүжилтийг шийдвэрлээгүй зэрэг асуудлуудыг үндэслэл болгон 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 2-р ээлжийн	хувь
--	---	--	--	--	---	---	--------------------

						барилгын ажлыг зогсоосон. Гүйцэтгэл 95% Боомтын доторх 2-р ээлжийн зам талбайн ажлыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр Улсын комисс хүлээн авсан. Гүйцэтгэл 100%. Үнэлгээ: 70 хувь, өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан.	
				2.Бичигт боомтын авто замын барилгын ажлын гүйцэтгэл 25%, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 5%.	2.Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 50%-д хүрсэн байна.	Бичигт боомтын авто замын ажил 25%, барилгын ажил 10%. Бичигт боомтын ой хээрийн түймэр, гадаргын ус зайлуулах зураг төслийг хянаж, баталсан. Үнэлгээ: 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай.	
				3.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 64.8%-ийн гүйцэтгэлтэй.	3.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.	Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалт дууссан. Барилга байгууламж, зам талбайн ажлыг Улсын комисс 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авсан. Гүйцэтгэл 100%-тай байна. Боомтын барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөл бүрэн хангагдсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй	
				4. Шивээхүрэн, боомтын ТЭЗҮ, БОТБҮ, нарийвчилсан зураг төслийн ажил 100%-д хүрсэн.	4.Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлсэн байна.	Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас хүлээгдэж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй. Гаалийн байгууллагаас шалтгаалаагүй ажил.	

				5.ЭЗХЯ-ны захиалгаар ТХААГ-аас Эрэнцав, Арцсуурь боомтын ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын тендер зарлагдаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Зураг төслийн ажлын явц Эрэнцав боомт 30%, Арцсуурь боомт 45%-ын гүйцэтгэлтэй.	5.Даян, Байтаг, Тэс, Арцсуурь, Эрэнцав, Бага-Илэнх, Зэлтэр боомтуудыг хөгжүүлэх, дэд бүтцийг өргөтгөж шинэчлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний нарийвчилсан зураг төслийн ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулан гүйцэтгэгч байгууллагад өгч хамтран ажилласан байна. Зураг төсөл Барилгын хөгжлийн төвөөр баталгаажсан байна.	Арцсуурь боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний нарийвчилсан зураг төсөлд барилга байгууламж, авто зам, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн байршлыг тусгуулж, хянаж зөвшилцсөн. Арцсуурь боомтын зураг төсөл БХТ-өөр хянагдаж, баталгаажсан бөгөөд төсөв хянагдаж байна. Гүйцэтгэл 98%-тай байна. -Эрэнцав боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлтэй танилцаж, холбогдох саналыг гүйцэтгэгчид өгсөн. Саналын дагуу гүйцэтгэгчээс өөрчлөлтийг хийж зургаа дахин танилцуулсан бөгөөд зураг төслийг хянаж баталгаажуулсан. Эрэнцав боомтын ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл Барилгын хөгжлийн төвөөр хянуулахад бэлэн болсон бөгөөд гүйцэтгэл 70%-тай байна. Үнэлгээ: 42 хувь, эрчимжүүлэх шаардлагатай.	
				6.Гашуунсухайт боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулах ажлыг бүтээн байгуулалттай уялдуулан гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 35% байна. Боршоо, Алтанбулаг боомтод суурилуулах ухаалаг гарцын	6.Алтанбулаг, Баянхошуу, Гашуунсухайт боомтуудад ухаалаг гарцын системийг нэвтрүүлсэн байна.	-Замын-Үүд, Гашуунсухайт, Ханги боомтуудад ухаалаг гарцуудыг бүрэн суурилуулсан. Гүйцэтгэл 100%-тай байна. -Баянхошуу боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулах ажил санхүүжилттэй холбоотойгоор 2025 онд хийгдэхээр болсон. -Алтанбулаг, Боршоо боомтуудад суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн тендер шалгаруулалт зарлах зөвшөөрөл АХБ-аас RIBS төслийн нэгж дээр хүлээгдэж байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй. Гаалийн байгууллагаас шалтгаалах ажил хийгдсэн.	

				гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдсан ба эцэслэгдээгүй байна. Ханги боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулахаар байршлыг тодорхойлохоор ажлыг хэсэг газар дээр нь ажиллаж санал боловсруулсан.			
				7.Цагаандэл уул боомтын зураг төслийн ажлын гүйцэтгэл 85%-тай. Боомтын түр гарц нээж гадна хашаа барих ажлын явц 90%-ийн гүйцэтгэлтэй.	7.Цагаандэл уул боомтын БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн буцалтгүй тусламжаар бүтээн байгуулах төсөл хэрэгжүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан тохиолдолд түр гарц нээх, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.	Цагаандэл уул боомтын зураг төсөл болон төсвийг 2 үе шатанд хувааж хийхээр өөрчлөлт оруулсан. Эхний шатны зураг төслийн ажлын даалгаврыг хянаж, баталгаажуулсан. Гүйцэтгэл 92%-тай байна. Боомтын ТЭЗҮ нь Барилгын хөгжлийн төвийн магадлалаар хянагдаж баталгаажсан. Гүйцэтгэл 100%-тай байна. Боомтын түр гарцыг нээж, гадна хашаа барих ажил 100% хийгдсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.16	Гаалийн төв болон салбар лабораторийн чадавхыг бэхжүүлэх	БНХАУ-ын буцалтгүй тусламж, АХБ-ны хөнгөлөлттэй зээл, бусад хөрөнгө оруулалт	Дээжийн тоо, хувиар, Магадлан шинжилгээнд зарцуулах хугацаа, хоногоор	1-2."Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лаборатори болон Увс аймгийн Боршоо дахь гаалийн салбар	1.Булган, Цагаандэл-Уул, Бургастай боомтод шинээр салбар лабораторийг байгуулан нүүрс, эрдэс түүхий	-Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газарт байрлах Гаалийн салбар лабораторийн барилгын засвар бүрэн дуусаагүй бөгөөд 2024 оны 01 дүгээр сараас 5 Шинжээч-гаалийн улсын байцаагчийг томилон химийн, хорио цээрийн шинжилгээний 30 төхөөрөмжийн тохиргоог хийж, хэвийн ажиллагаанд оруулсан. -Увс аймаг дахь гаалийн газрын Гаалийн салбар	87.5 хувь

				лабораториудыг хэвийн үйл ажиллагаанд оруулж эхлүүлж ажилласан.	эдийн шинжилгээний тоног төхөөрөмжийг суурилуулж, үйл ажиллагаанд оруулснаар магадлан шинжилгээнд хамрагдах нийт дээжийн тоог 5-10 хувиар нэмэгдүүлнэ. 2.Булган, Цагаандэл-Уул, Бургастай боомтод шинээр салбар лабораторийг байгуулснаар тус гаалийн газрын хяналтад байгаа барааны магадлан шинжилгээнд хамрагдах хугацааг 3-4 хоногоор бууруулна.	лабораторийн барилгыг ашиглалтад авч, нефть, хорио цээрийн шинжилгээний 34 төхөөрөмжийг суурилуулсан. 2024 оны 03 дугаар сараас Шинжээч-гаалийн улсын байцаагчийг томилж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Нийт 222 дээж шинжилж, 5,1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. -Ховд аймаг дахь гаалийн газрын Гаалийн салбар лабораторид 2024 оны 05 дугаар сараас Шинжээч-гаалийн улсын байцаагчийг томилон ажиллуулж, хүнс, хорио цээрийн 22 төрлийн багаж нийлүүлэгдэн шинжилгээ хийгдэж эхлээд байна. Нийт 3 дээж шинжилж, 94700 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. -Цагаан Дэл-Уул боомтод бараа нэвтрүүлэлтийн мэдээг үндэслэн нүүрсний шинжилгээний чиглэлээр гаалийн салбар лаборатори байгуулах зураг төсөл, судалгааг гаргасан. -Боомтын бүтээн байгуулалттай уялдуулан Бургастай боомтод төмрийн хүдэр, баяжмалын шинжилгээний чиглэлээр гаалийн салбар лаборатори байгуулах талаар санал хүргүүлсэн. -Гашуунсухайт дахь гаалийн газарт байрлах гаалийн салбар лабораторийг 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нүүрс, хүнс, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр 46 тоног, төхөөрөмж нийлүүлэгдсэнээс хорио цээрийн 23 багажийг суурилуулсан, харин лабораторийн барилгыг нүүрсний шинжилгээний чиглэлээр болгон зураг төсөл, холбогдох судалгаа, мэдээллийг гаргаж, ҮБХГ-т хүргүүлж, санхүүжилтийг 2025 онд шийдвэрлэхээр тусгасан. -Гашуунсухайт дахь гаалийн газрын “Оюутолгой” гаалийн салбар лабораторийн барилгын агааржуулалтыг засаж, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хэвийн ажиллагаанд оруулсан. тус гаалийн салбар лаборатори нь нийт 742 дээжид шинжилгээ хийж, улсын төсөвт 118,7 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн. -Шивээхүрэн дэх гаалийн газрын гаалийн салбар лаборатори ГЕГ-ын МАК ХХК-тай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ий дагуу МАК ХХК-ийн	
--	--	--	--	--	--	---	--

					Нарийнсухайт уурхайн нүүрсний шинжилгээний лабораторид 2024 оны 10 дугаар сараас эхлэн сар тутамд Гаалийн төв лабораториос 2 Шинжээч-ГУБ-ийг томилон, ажиллуулж байна. 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 183 дээжид шинжилгээ хийж, шинжилгээний хураамжаар 31,1 сая төг оруулсан. -Замын-Үүд дэх гаалийн газрын Гаалийн салбар лабораторид нүүрсний 20, ноос ноолуурын шинжилгээний 5 төхөөрөмж нийлүүлж, сургалтыг явуулсан. Нүүрсний шинжилгээний чиглэлээр хуучин лабораторийн зургийг өөрчилж, хүргүүлсэн. -Гаалийн төв болон салбар лабораториудад нийт магадлан шинжилгээнд ирүүлсэн дээжний 93% буюу 36793 дээжийг шинжилснээр дээжний тоо өмнөх онтой харьцуулахад 22,3%-иар нэмэгдэн, магадлан шинжилгээнд хамруулах хугацааг 2-3 хоногоор бууруулсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй. Гаалийн байгууллагаас шалтгаалах арга хэмжээнүүд авагдсан.	
			3.Гаалийн төв лаборатори болон Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын Цагаан нуур дахь салбар лабораторид хорио цээрийн шинжилгээг нэвтрүүлсэн.	3.Гаалийн төв лабораторид импортын зарим хүнсний бүтээгдэхүүнд нян судлал, хор судлал, ургамлын хорио цээрийн шинжилгээ хийж эхэлнэ.	Замын-Үүд дэх гаалийн газар, Ховд аймаг дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Гаалийн салбар лабораториудад хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуй, чанар аюулгүйн үзүүлэлтүүд болох нян судлал, хими хор судлал, ургамал хорио цээрийн шинжилгээ хийгдэж байгаа бөгөөд нийт 17'008 нэр төрлийн дээжид магадлан шинжилгээ хийж гүйцэтгэсэн байна. Замын-Үүд дэх гаалийн газар нь хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар аюулгүйн үзүүлэлтүүдийн шинжилгээний чиглэлээр 2026 оныг хүртэл Үндэсний иртгэмжлэлд хамрагдсан бөгөөд Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Ховд аймаг дахь гаалийн газрын Гаалийн салбар лабораториуд нь итгэмжлэлийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын Гаалийн салбар лабораторид хүнсний	

						бүтээгдэхүүнийн магадлан шинжилгээний тоног төхөөрөмжийг суурилуулсан, барилгын засварын ажил хийгдэж байна. 2024 онд улсын төсвийн урсгал зардлаар худалдан авах Гаалийн төв болон салбар лабораториудын шинжилгээнд шаардлагатай урвалж бодис, стандарт дээж, шил сав, туслах хэрэгслүүдийн жагсаалтыг нэгтгэн гаргаж, ГЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/252 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулан, ГЕГ/20240102013 дугаартай нээлттэй зарлан, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр гэрээ байгуулан, 2024 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүнсний шинжилгээний урвалж бодис, стандарт дээж, шил сав болон туслах хэрэгслүүд нийлүүлэгдсэн. -Гаалийн төв лабораторид импортын зарим хүнсний бүтээгдэхүүнд нян судлал, хор судлал, ургамлын хорио цээрийн туршилтын шинжилгээг хийж байна. Үнэлгээ: 75 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
4.17	Гаалийн хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цахимжуулах	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Алтанбулаг, Замын-Үүд, Боршоо боомтуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангасан.	1.Хилийн Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангагдсан	Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтууд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангах судалгааг гаргасан. Гашуунсухайт боомтын шалган нэвтрүүлэх цогцолбор 2024 онд шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан шаардлага хангасан сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөг ашиглалтад оруулсан. “Хөгжлийн хөтөч” төслийн хүрээнд нүүрсний ачаа тээврийн 6 ширхэг, зорчигчийн чиглэлд 3 ширхэг нийт 9 халдваргүйжүүлэлтийн байгууламжийг ашиглалтад оруулж, халдваргүйжүүлэлтийг хийж байна. Ачааны тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх зориулалтын байгууламжийг ашиглалтад оруулж, Шивээхүрэн терминал ХХК-тай түрээсийн гэрээгээр Хүслийн хийморь ХХК халдваргүйжүүлэлтийг гүйцэтгэж байна. Тус боомтод 2 өрөө бүхий сэжигтэй зорчигчийг түр	100 хувь

				байна.	тусгаарлах өрөөг ашиглаж байна. Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ээлжит хуралд Бичигт боомтын ерөнхий төлөвлөгөөг ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах болон хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй шаардлагатай барилга байгууламж, талбай, техник тоног төхөөрөмжийг үндэслэн төлөвлөх, байгаль орчны үнэлгээг хийлгэх саналыг дэвшүүлсэн. Мөн Бичигт боомтод ариутгалын байгууламжийг 2022 онд шинээр анх барьж, 2024 онд тохижуулалт хийж, ашиглалтад оруулсан, 3 өрөө бүхий сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөг бий болгосон. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Шивээхүрэн-Сэхэ боомтын төсөл”-ийг хэрэгжүүлэгч “Нарийн сухайтын төмөр зам” ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлын зурагтай танилцаж, хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын асуудлаар санал хүргүүлсэн. ГЕГ-ын даргын 2024 оны 130 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хороо батлуулах тухай” ажлын хэсэгт ажиллан, хүний халуун хэмжигч төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулан, 7 газарт 8 термокамер олгуулах саналыг Хорио цээрийн хэлтсээс Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлж, нээлттэй тендерийг шалгаруулж, нийлүүлэгч компанийг сонгон, худалдан авалт хийлгэж, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн зэрэг 7 газрыг 8 термокамераар хангасан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
		2.ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээтэй боомт байхгүй байна.	2.ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээ авах бэлтгэл ажлыг Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь гаалийн газар	ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээ авах бэлтгэл ажлыг Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар зорилгоор ДЭМБ-ын Хөндлөнгийн үнэлгээний зөвлөх багийн зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:		
				-Агаарын хилийн боомтод нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин илэрсэн, химийн осол болсон үед авах хариу арга хэмжээ, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал		

					хангасан байна. үүссэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”, “Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө”, “Мал амьтны гоц халдварт, халдварт өвчин илэрсэн үед хэрэгжүүлж ажиллах бэлэн байдлын төлөвлөгөө”-д тодотгол хийж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын даргын А/43 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. ГЕГ-ын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/452 дугаар тушаалаар “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ийг шинэчилж, нийт 2 сая төгрөгийн санхүүжилт олгон 20000 ширхэг эрүүл мэндийн мэдүүлгийг хэвлүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангасан. Хөрш зэргэлдээ болон бусад орнуудад дэгдсэн Улаанбурхан өвчний тохиолдол Монгол улсад нууц үедээ зөөвөрлөгдөж, батлагдсантай холбогдуулан Казакстан улсаас шууд нислэгээр ирсэн 30 агаарын хөлгийн 2658 зорчигчдод термокамерын тандалт хийж, хил нэвтрүүлсэн. Хилийн нэвтрэх цэгт халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, халдвараас сэргийлэх хариу арга хэмжээг зөв, оновчтой, шуурхай хэрэгжүүлэх талаар ээлжийн ахлах, гаалийн улсын байцаагчдад мэдлэг олгох, чадамжийг дээшлүүлэх зорилгоор “Чингис хаан олон улсын нисэх буудлын “Хилийн нэвтрэх цэгт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдал” сэдэвт ширээний дасгал сургуулилтыг 2024 оны 11 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд 4 ээлжид 120 гаалийн улсын байцаагч, ариутгагчдыг хамруулан зохион байгуулсан. Олон улсын зорчигчийн урсгалыг нэмэгдүүлэх, зорчигчийн биеийн дулааныг хэмжих термокамерын байнгын байрлалд байрлуулах ажлыг төсвийн 1126000 төгрөгний зардлаар хийж гүйцэтгэсэн. Захиргааны албанд шаардлагатай хүний нөөцийн саналыг хүргүүлж, Мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч 2, Эрүүл ахуй, халдвар	
--	--	--	--	--	---	--

					хамгааллын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч 1, ариутгагч 5, нийт 8 сул орон тоог нөхөж хүний нөөцөө бүрдүүлсэн. Шинээр томилогдсон гаалийн улсын байцаагчид нь гаалийн хэргийн мэдлэг олгох сургалтад, 5 ариутгагчийг Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан “Халдваргүйтгэлийн тухай ойлголт” сэдэвт чадавхжуулах сургалтад хамруулж, гэрчилгээ авсан. МИАТ ТӨХК, НУБИА ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хамтран "Цацрагийн үүсгүүрийн алдагдал" сэдэвт ширээний дасгал сургуулилт хийж, тус газрын цөмийн болон цацрагийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг оролцуулсан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			3.ГЕГ-ын даргын 2023 оны 62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг Экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх мэдэгдлийг цахимаар олгох судалгаа хийсэн.	3.Экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх мэдэгдлийг цахимаар олгох бэлтгэл ажлыг хангаж, нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.	АХБ-аас хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ГЕГ-ын даргын А/115 дугаар тушаалаар ажлын хэсэг шинэчлэн байгуулагдан хорио цээрийн хяналтын чиглэлээр 16 модуль бүхий төлөвлөгөө боловсруулж, экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх мэдэгдлийг цахимаар олгох тусгайлсан модулийг бий болгосон. ГЕГ-ын arqs.gaali.mn цахим системээр мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бараа экспортлох, импортлох 1524 аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан хүсэлтийг хүлээн авч, импортын мэдэгдэл 186 ААН, 186 ш, экспортын гэрчилгээ 2336 ААН-д 5508 ш-ийг цахимаар олгосон. ГЕГ болон гаалийн харьяа газар, хороодоос ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нийт 2150 ширхэг экспортын гэрчилгээ олгосноос ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 1686 ширхэг, БНХАУ-д хивэг экспортлох гэрчилгээ 164 ширхэг, гэрийн мод, модон материалд 212, БНХАУ-д буудайн гурил экспортлох гэрчилгээ 88 ширхэгийг тус тус олгосон. Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бараанд дамжин өнгөрүүлэх мэдэгдэл 140 ширхэг, импортын мэдэгдэл 2489 ширхэгийг цахимаар олгоход	

					мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан. ХХААХҮЯ болон Хүнс, хөдөө аж ахуй Хөдөө аж ахуйн биржтэй хамтран төрийн болон төрийн бус байгууллагын экспортын нэг цонхны систем /Export.mofa.gov.mn/-д гаалийн хорио цээрийн системийн холболтын үйл ажиллагааг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэн гаалийн хорио цээрийн Caps.gaali.mn системийг холбож, ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсээс олгож буй “Экспорт, импорт хорио цээрийн гэрчилгээ, мэдэгдлийн систем”, “Экспортын нэг цонхны систем”-тэй уялдуулан шинэчлэгдэж, аж ахуйн нэгжийн экспортод зарцуулах цаг, хугацааг багассан. Export.mofa.gov.mn цахим нэгдсэн системээр итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож, гаалийн мэдээллийн систем рүү дамжуулан мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээг 2-4 цаг зарцуулж, өдөрт нь шийдвэрлэж ажилласан. Мал эмнэлгийн ерөнхий газарт. Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль"-д 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж, 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс Гаалийн байгууллагаас олгож буй экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох, баталгаажуулах чиг үүрэг ХХААХҮЯ, МЭЕГ-т шилжиж буйтай холбогдуулан 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр тус яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, Хорио цээрийн хэлтсээс холбогдох баримт бичгийн жагсаалт, гэрчилгээ, мэдэгдлийн загварыг дээрх байгууллагуудад хүргүүлж, бусад шаардлагатай мэдээллийг өгч ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/534 дүгээр тушаал гарч, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн дотор чиг үүргийг шилжүүлэн, мэдээ, мэдээлэл харилцан солилцох ажлууд хийгдсэн.	
--	--	--	--	--	--	--

					1.Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтууд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангах судалгааг гаргасан. Гашуунсухайт боомтын шалган нэвтрүүлэх цогцолбор 2024 онд шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан шаардлага хангасан сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөг ашиглалтад оруулсан. “Хөгжлийн хөтөч” төслийн хүрээнд нүүрсний ачаа тээврийн 6 ширхэг, зорчигчийн чиглэлд 3 ширхэг нийт 9 халдваргүйжүүлэлтийн байгууламжийг ашиглалтад оруулж, халдваргүйжүүлэлтийг хийж байна. Ачааны тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх зориулалтын байгууламжийг ашиглалтад оруулж, Шивээхүрэн терминал ХХК-тай түрээсийн гэрээгээр Хүслийн хийморь ХХК халдваргүйжүүлэлтийг гүйцэтгэж байна. Тус боомтод 2 өрөө бүхий сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөг ашиглаж байна. Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ээлжит хуралд Бичигт боомтын ерөнхий төлөвлөгөөг ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах болон хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй шаардлагатай барилга байгууламж, талбай, техник тоног төхөөрөмжийг үндэслэн төлөвлөх, байгаль орчны үнэлгээг хийлгэх саналыг дэвшүүлсэн. Мөн Бичигт боомтод ариутгалын байгууламжийг 2022 онд шинээр анх барьж, 2024 онд тохижуулалт хийж, ашиглалтад оруулсан, 3 өрөө бүхий сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөг бий болгосон. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Шивээхүрэн-Сэхэ боомтын төсөл”-ийг хэрэгжүүлэгч “Нарийн сухайтын төмөр зам” ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлын зурагтай танилцаж, хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын асуудлаар санал хүргүүлсэн. ГЕГ-ын даргын 2024 оны 130 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хороо батлуулах тухай” ажлын хэсэгт ажиллан, хүний халуун хэмжигч төхөөрөмжийн	
--	--	--	--	--	---	--

					техникийн тодорхойлолтыг боловсруулан, 7 газарт 8 термокамер олгуулах саналыг Хорио цээрийн хэлтсээс Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлж, нээлттэй тендерийг шалгаруулж, нийлүүлэгч компанийг сонгон, худалдан авалт хийлгэж, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн зэрэг 7 газрыг 8 термокамераар хангасан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			4.ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний баг Монгол Улсад 2023 оны 11 дүгээр сарын 17-24 ний өдрүүдэд ажилласантай холбогдуулан 18 гаалийн газар, хороодоос судалгаа авч, 5 боомтод мэргэжлийн байгууллагатай хамтран газар дээр нь үнэлгээг хийж, үнэлгээний нэгдсэн дүнг Шадар сайдын түвшинд танилцуулж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг гаргасан.	4.ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний багаас Засгийн газарт хүргэгдсэн нэгдсэн зөвлөмжид тусгагдсаны дагуу 18 Газар, хороодын “Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар баталсан журмын үйл явдал бүрээр нарийвчлан боловсруулж, батлуулах	ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрэмийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний багаас гаргасан 5 зөвлөмжийн 1 болох Бэлэн байдлын төлөвлөгөөнд Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын үйл явдал (хүний олон улсын хөл хориот болон малын гоц халдварт өвчин, ургамлын хорио цээр, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт, хими, цацрагийн осол, хордлого) тус бүрээр тодотгол хийх ажлын хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр цахим хуралдаанаар, 2024 оны 06 дугаар сарын 14-ний 02-1.2/2450, 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 02/3100 албан бичгээр тус тус холбогдох чиглэлийг өгсөн. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/85 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс гаргасан “Нэг эрүүл мэнд” зарчимд тулгуурлан бэхжүүлэх зорилго бүхий Эрүүл мэндийн аюулгүй байдлын төлөвлөгөөний үндсэн агуулгатай харьяа гаалийн газар, хороодын Бэлэн байдлын төлөвлөгөөг уялдуулсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 19 гаалийн газар, хороо “Бэлэн байдлын төлөвлөгөө”-гөө шинэчилж, баталгаажуулсан байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
			5.Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй	5.Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй	АХБ-ны санхүүжилтээр Шадар сайдын ажлын алба болон Интерактив ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй	

				“Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь” төслийн хүрээнд ГЕГ-ын даргын 2023 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг гаалийн хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах 16 модулийг боловсруулж, энэ хүрээнд одоогийн үйл ажиллагааны /AS-IS/ болон ирээдүйн үйл ажиллагааны системийн зорилтот /To-Be/ загварчлалыг бэлэн болгосон.	“Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь” төслийн хүрээнд “Хилийн хяналт удирдлагын систем”-ийн хөгжүүлэлтийн хүрээнд www.gaali.mn цахим системээр дамжуулан гаалийн харилцаанд оролцогчдын өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах нэгдсэн сувгийг бий болгох, хорио цээрийн эрсдэл тооцох аргачлалыг программчлах, гаалийн автоматжуулсан цахим системийн зарим модулийг гар утасны программд шилжүүлэн ашиглах апплейкшныг боловсруулж, нэвтрүүлнэ.	байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” төслийн хүрээнд гаалийн хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр ГЕГ-ын даргын А/115 тушаалаар шинэчлэн батлуулсан. Ажлын хэсэг нь: -16 модулийн хүрээнд төлөвлөгөө гарган Хорио цээрийн эрсдэлийг, гаалийн эрсдэлийн удирдлагын модультай уялдуулах зорилгоор эрсдэлийн нэгдсэн журамд дурдсан эрсдэл тооцох өгөгдлүүдийг цахимжуулах, -Төрийн байгууллагуудтай өгөгдөл солилцох, -Лабораторийн модулийн шаардлагын тодорхойлолт, -Гар утасны апплейкшнийн загвар, -Хорио цээрийн модулийн цацраг, шарил, зорчигч, тээвэр, -Халдваргүйжүүлэлтийн дэд модульд засвар, сайжруулалт, -Хорио цээрийн хяналтын явцад буцаах мэдэгдлийн модуль, -Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудаст нэмэлт, өөрчлөлт оруулах модуль, -Халдваргүйжүүлэлт, шарилын бүртгэл, түр тусгаарлалтын модуль, -Зорчигч, тээврийн хэрэгслийн эрүүл мэндийн хяналтыг захиргааны статистикийн бүртгэлийн мэдээнд оруулах модулийг тус тус боловсруулан хөгжүүлж, Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /CAIS/-д холбоход бэлэн болгосон. Уг төсөл 2025 оны 04 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл үргэлжилнэ. Мөн “Хилийн хяналт удирдлагын систем”-ийн хөгжүүлэлтийн хүрээнд гаалийн харилцаанд оролцогчдын өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах нэгдсэн сувгийг бий болгох шаардлагын тодорхойлолтыг боловсруулан хөгжүүлэлтийг дараах байдлаар хийж, тестийн орчинг бий болгосон. Үүнд: -Хэрэглэгч gaali.mn болон гар утасны аппликейшнид бүртгүүлэн тоон гарын үсэг болон “ХУРДАН” системээр дамжуулан гаалийн байгууллагын системд нэвтрэн “Иргэдээс төрийн байгууллага, албан
--	--	--	--	---	---	--

						тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн шаардлага хангасан өргөдөл, гомдол гаргах, түүний хүлээн авч хувиарлах, шийдвэрлэх “Өргөдөл, гомдол”; -Гаалийн байгууллагаар үйлчлүүлэгч иргэн, аж ахуйн нэгжид зориулсан цаг үеийн шинж чанартай яаралтай зөвлөмж, мэдээ, мэдээлэл түгээх “Зөвлөмж, Мэдээлэл”; -Гаалийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой нийтлэг асуулт хариултыг бий болгох “Түгээмэл асуулт/хариулт” -Гаалийн хяналт шалгалттай холбоотой санал, хүсэлт хүлээн авах хялбаршуулсан “Санал / Хүсэлт” дэд модулийн хөгжүүлэлтийг тус тус хийсэн. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.18	Дотоод хяналт, шалгалт, гомдол мэдээлэл болон гаалийн байгууллагын дотоод эрсдэлийн түвшинд тулгуурласан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн шалгалтуудыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой нийт 56 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж, хуулийн хүрээнд бүрэн шийдвэрлэсэн байна.	1.Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагчидтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл шалгагдаж шийдвэрлэгдсэн байна.	2024 оны байдлаар ГЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс нь иргэн болон байгууллага, ГЕГ-ын 1800-1281 гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай дугаар, Засгийн газрын 1111 төвөөс нийт 72 гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч, дотоод хяналт, шалгалт явуулсан бөгөөд шалгагдсан албан хаагчдын талаар мэдээллийн сан бүрдүүлж, шалгалтын материалыг архивын нэгж болгон хадгалж байна. Тус 72 гомдол, мэдээллийг ангилан авч үзвэл: - Засгийн газрын 1111 төвөөс ирүүлсэн 13, - Гаалийн лавлах 1800-1281 дугаарт ирүүлсэн 7, - ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас дотоод зурвасаар ирүүлсэн 13, - Албан бичиг, өргөдөл, гомдлоор ирүүлсэн 49 байна. Тус 72 гомдол, мэдээлэлтэй холбогдуулан 142 албан хаагчдад /давхардсан тоогоор/ албаны дотоод шалгалтыг явуулж, тайлбар, тодруулга авч ажилласан. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	100 хувь
				2.ГЕГ-ын ЗБББНДБ, харьяа гаалийн газар, хороодын гэмт хэрэг зөрчилд	2.Гаалийн албан хаагчдын сахилга, ёс зүйн зөрчилд хариуцлага	2024 оны байдлаар сахилга, ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчдад дараах байдлаар сахилгын шийтгэл ногдуулсан. Үүнд: - Хүлээн авсан гомдол, мэдээлэл 72, - Шалгагдсан албан хаагч 172,	

				холбогдсон, сахилга ёс зүйн зөрчил гаргасан гэх 56 гомдол, мэдээллийг хүлээн авч, нийт 172 албан хаагчийг холбогдуулан шалгаж, 49 албан хаагчийн үйлдлийг ГЕГ-ын сахилгын хороогоор хэлэлцүүлэн хариуцлага тооцсон.	тооцсон байна.	- Сахилгын хороонд шилжүүлсэн 33, - Шууд тушаалаар арга хэмжээ авсан 4, - Сахилгын хорооноос арга хэмжээ авсан 8, - Харьяа гаалийн гаалийн газар, хороодод шилжүүлэн арга хэмжээ авсан 6 байна. Нийт арга хэмжээ авагдсан 18 /Сахилга хариуцлага чиглэлээр/. Үүнээс ёс зүйтэй холбоотой 6 албан хаагчид арга хэмжээ авсан. Сахилгын шийтгэлийн төрөл нь: - Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар 20 хувиар бууруулах 10, - Сануулах 1, - Албан тушаалыг 3 сарын хугацаагаар бууруулах 4, - Гаалийн улсын байцаагчийн эрхийг 6 сарын хугацаатай хасах 3 байна. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.19	Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх, зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 17 удаагийн үйлдлийг таслан зогсоож, зөвлөмж чиглэлээр харьяа гаалийн газар, хороодыг ханган ажилласан. Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан 5 нэр төрлийн 2630 хүн тун мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэн шийдвэрлэсэн.	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хууль хяналтын байгууллагуудтай 2024оны хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, харьяа гаалийн газар хороодыг хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, мөнгө угаахтай	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг илрүүлэх, таслах зогсоох чиглэлээр хамтарсан хяналт, шалгалт хийх төлөвлөгөөг ГЕГ-ын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсээс Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай 2024 оны 03 дугаар сард, Тагнуулын ерөнхий газрын Нийслэл дэх газрын Хоёрдугаар хэлтэстэй 2024 оны 06 дугаар сард тус тус батлан хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 14 удаагийн үйлдлийг таслан зогсоож, эзэн холбогдогч болон нотлох баримтын хамт эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу шилжүүлэн өгөхтэй холбоотой зөвлөмж, чиглэлээр харьяа гаалийн газар, хороодыг ханган ажилласан. Дээрх зөрчлөөс дурдвал: 1.Эфедрин (Efedrin) – 500 мл (ЧХОУНБГГ) 2.5-Fluoro ADB (cannabinoid)- 7.32 грамм (Монгол шуудан дахь гаалийн хяналтын бүс) 3.Бүфотенин О-Метил – 7.32 грамм (Ди Эйч Эл дэх гаалийн хяналтын бүс) 4.Шаттер – 94.4 грамм (Монгол шуудан нисэх гаалийн хяналтын бүс)	100 хувь

				Үүнд: 5 удаагийн үйлдлээр 933 грамм метамфетамин, 2 удаагийн үйлдлээр 133 мл морфин, эфедрин тариа, 6 үйлдлээр 4045 грамм Каннабисын давирхайны орцтой бүтээгдэхүүн, 4 үйлдлээр мансууруулах төрлийн бодис агуулсан ТНС төрлийн шингэн хэлбэрийн 1100 грамм мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг тус тус гаалийн хяналт, шалгалтаар илрүүлсэн.	холбоотой авагдсан гомдол мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил, арга зүйн удирдамжаар ханган ажилласан байна.	5.Метамфетамин – 5 грамм (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) 6.Экстази – 11 ширхэг (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) 7.АВ-PINACA – 30 мл (Ди Эйч Эл дэх гаалийн хяналтын бүс) 8.Мефедрон – 25 грамм (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) 9.ЛСД, Экстази – 50 ширхэг, 152.5 грамм (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) 10.Экстази – 60 ширхэг (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) 11.ЛСД – 25 дусал (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) 12.Метамфетамин – 36 грамм (ЧХОУНБГГ) 13.ADB-CHMINACA /K2/- 659.1 грамм (Монгол шуудан нисэх гаалийн хяналтын бүс) 14.Каннабис – 42.40 грамм (СЭГГ) Дээрх зөрчлүүдээс Монгол Улсад бүртгэгдэж байгаагүй шингэн ЛСД, Eboly Meth буюу Халтар мөс, K2 буюу Spice гэх шинэ төрлийн мансууруулах бодисуудыг илрүүлж ажилласан. Уг бодисуудаас дээж авч, Шүүх шинжилгээний ерөнхий газарт хүргүүлэн шинжлүүлэхэд урьд өмнө нь бүртгэгдэж байгаагүй бодисууд болох нь тогтоогдсон. Үнэлгээ: 100 хувь, үр дүнтэй.	
4.20	IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТAM) –той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээж мэдээллээ солилцож эхлэхээр тохиролцсон. -Гаалийн автоматжуулсан мэдээллийн КАИС системд TIR-EPD мэдээллийг хүлээн	IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТAM) –той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох программыг туршиж, нэвтрүүлэх.	Олон улсын автотээврийн холбооны программ хангамжийн багтай Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг уялдуулж, холбох ажлыг 2021 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн. ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож, 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээлгэж, IRU-ийн зөвлөх Вахтанг Зарандиятай 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр харилцан санал солилцож, тохиролцсоны дагуу 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн IRU-тай TIR-EPD-ийн 6 элементийг туршиж, дараа нь CAIS-т нарийн үйлдлүүдийг хийсэн. ГЕГ-ын Мэдээллийн технологийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзоригор ахлуулсан ажлын хэсэг	100 хувь

				авах, боловсруулах программыг хөгжүүлэлтийг хийж, тест хийж ажилласан.		2024 оны 11 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд Алтанбулаг, Замын-Үүд боомтод томилолтоор ажиллаж, CAIS-т ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбох туршилтыг хийж, амжилттай нэвтрүүлсэн. Дээрх ажилтай холбоотойгоор Мэдээллийн технологийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр CAIS-т ТИР-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг Замын-Үүд дэх гаалийн газарт зохион байгуулж, Замын-Үүд дэх гаалийн газрын 15 албан хаагчийг танхимаар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Ховд аймаг дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан. Мөн Мэдээллийн технологийн газраас нийт гаалийн улсын байцаагч нарт зориулан “ТИР карней бүхий бараа тээврийн хэрэгслийг CAIS-д бүртгэх, хяналт тавих гарын авлага” боловсруулан CERP-д байршуулсан. ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал Олон улсын автотээврийн холбооны ТИР болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Зарандиятай 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр уулзаж, CAIS-д ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн ажлын явцыг дүгнэсэн. ГЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Хяналт бүрдүүлэлтийн газар, Олон нийттэй харилцах албаны албан хаагч нар Замын-Үүд боомтод 2024 оны 11 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд ажиллаж, Олон улсын автотээврийн холбооны ТИР болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Зарандия, МАТНХ-ны гүйцэтгэх захирал Д.Наранпүрэв нарт Замын-Үүд боомтын ачааны терминалд ТИР, транзит тээвэрлэлтийг нэвтрүүлэх замын эгнээ, гаалийн байгууллагын бүртгэл, хяналтыг танилцуулж, ТИР-ын самбарыг байршуулахтай холбоотой асуудлаар санал солилцсон. Цаашид Замын-Үүдээс бусад боомтоор ТИР карней бүхий бараа, тээврийн	
--	--	--	--	---	--	--	--

						хэрэгслийг нэвтрүүлсэн мэдээг CAIS-д хүлээн авах хугацааг тодруулах, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор ГЕГ-ын Хяналт бүрдүүлэлтийн газар, Мэдээллийн технологийн газрын албан хаагч нар IRU-ын программ хангамжийн багийнхантай хамтарч ажиллах боломжийг цаг алдалгүй зохион байгуулахтай холбоотой саналаа 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02-1/5010 албан бичгээр НАРТМД-д хүргүүлсэн. Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS-д 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн. IRU-ийн ТИР болон транзит хариуцсан ахлах зөвлөх Вахтанг Зарандиятай хамтран TIR-EPD холболтын гүйцэтгэлийн үнэлгээ, CAIS дахь ТИР карней статусыг шалгах, EGIS шалгалтыг хэрхэн хийсэн тухай, EPD028/EPD016 мессежийг автоматжуулахтай холбоотой техникийн асуудлуудыг хамтран хянасан. БНХАУ-ын ГЕГ-ын ХШГ-ын дарга Жанг Тао-д 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02-1/4999 албан бичгээр Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн тухай мэдээллийг хүргүүлсэн. Үнэлгээ 100 хувь үр дүнтэй.	
4.21	Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын КАИС системд илгээх,	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1-2.Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг CEPS-д нөхөж бичээд, гаалийн байгууллагын КАИС-т илгээж бүртгүүлж байна.	1.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын КАИС системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн	Улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл хил нэвтрэх хүсэлтийг ceps.gaali.mn вэб сайтад хандаж, илгээж байна. Тус бүртгэлийг илгээх тээврийн хэрэгслийн жолооч, тээвэрлэгч байгууллага нь хил дээр зөөврийн компьютер байнга ашиглах хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх, гар утаснаас холбогдсон тохиолдолд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн серийн дугаарын үсгийг латин болон крилл үсэг холих зэрэг шалтгаанаар бүртгэлийг алдаатай илгээж, хил нэвтрэлтийг удаашруулах, улмаар гаалийн байгууллага дээрх бүртгэлийг хийх зэрэг нөхцөл байдал үүсээд байна. Иймд улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа гадаад, дотоодын тээврийн хэрэгслийн улсын хилээр нэвтрэх бүртгэлийн хүсэлтийг гаалийн байгууллагад	75 хувь

	мобайл аппликейшн шинээр хийлгэх				технологийн төвд хүргүүлнэ. 2.Мобайл аппликейшн туршилтаар ашигласан байна.	илгээх гар утсанд зориулсан программ хангамжийн хөгжүүлэлт хийлгэх шийдлийг судалж, СМТТ УТҮГ-т саналаа 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 02-1/3895 албан бичгээр хүргүүлж, хамтран ажилласан. Дээрх асуудлыг ГЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн газарт шийдвэрлэх боломжгүй тул И-Монгол Академи УТҮГ-ын систем нэгтгэлийн газрын төслийн менежер С.Цэвээнсүрэн, системийн шинжээч А.Эрдэнэцэцэг, цахим засаглалын хэлтсийн процесс аналит Г. Будням, шинжээч Г.Оюунгэрэл нартай уулзалт зохион байгуулж, Е-Монголиа аппликейшнд улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, гаалийн байгууллагатай холбогдох модуль гаргуулахаар тохиролцсон. Үүний дагуу тээвэрлэгчээс хил нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн хүсэлт илгээх асуудлыг гар утасны программ хангамжид суурилсан хэлбэрээр цахим төлбөрийн баримтын ebarimt системээс шийдвэрлэх технологийн гарц, шийдлийг судалж, И Монгол Академи УТҮГ-т захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлэн хамтран ажиллаж байна. 1.Цаашид боомтын орох, гарах хаалганы эгнээ замууд дээр бүртгэлтэй холбоотой асуудлаар бөөгнөрөл үүсгэхгүйн тулд тээврийн хэрэгслийн жолооч нар гар утаснаасаа бүртгүүлэх хүсэлтээ илгээх боломжийг бүрдүүлэхээр гар утасны апп шинээр хийлгэхийн тулд үнийн дүнгээс шалтгаалаад цахим хуудсаар дамжуулан тендер зарлах гэх мэтээр улсын төсвөөс тодорхой хэмжээний зардал гарах тооцоолол судалгаа хийсэн. 2.И-Монгол Академи УТҮГ-ын шинжээч нартай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлсэн. 3.Апп-аар тээврийн хэрэгслийг бүртгүүлэхэд: -Иргэн регистрийн дугаараар хүсэлтээ илгээхэд 5 минут, ХУР системээс мэдээлэл харуулахад 1 мин буюу нийт 6 минут зарцуулдаг болно. 4.Дээрх программыг улсын төсвөөс зардал	
--	---	--	--	--	---	--	--

						гаргахгүйгээр төлбөргүй хийлгэж 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс туршилтаар нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үнэлгээ: 75 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
4.22	Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ		Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1-2.Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалттай уялдуулан ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж эхэлсэн. Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна	1.Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна. 2.Ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг ижилсгэсэн байна.	-Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү гаргахгүй, мөн хилийн хяналтын байгууллагуудын давхардсан шалгалтыг багасгаж, хяналтаа сайжруулахын тулд автозамын хилийн боомтууд дээр гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулахаар хамтран ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, гаалийн байгууллагаас: 1.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг өгөгдөл дамжуулах байдлаар илгээж, танай байгууллагаас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарын тодорхой мэдээллийг хүлээн авах; 2.Хилээр түр хугацаагаар тээврийн хэрэгсэл оруулсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хилээр гарах үед нь түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгаж, нягтлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан. Үүний үр дүнд улсын хилээр орох болон гарах талд хил нэвтэрсэн авто тээврийн хэрэгслийн дугаараар ХХЕГ-аас сервисээр мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн. Тус мэдээлэлд жолооч, зорчигчийн овог, нэр, регистрийн дугаар, гадаад паспортын дугаар, төрсөн он, сар, өдрөөр ХХЕГ-ын баталгаажуулсан мэдээллийг хүлээн авч, гаалийн хяналт, шалгалтад ашиглах, эрсдэл тооцох боломжтой болгосон. Мөн цаашид төмөр зам, агаарын тээврийн хэрэгслээр хил нэвтэрсэн зорчигчийн Хил хамгаалах байгууллагын баталгаажуулсан мэдээллийг авахаар ажиллаж байна. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хилийн удирдлагын нэгдсэн систем ХУН” төслийн хүрээнд ХХЕГ, ГЕГ-ын мэдээллийг нэгтгэх ажил хийгдэж байна. Уг ажлын хүрээнд:	85 хувь

						-Хилээр орох чиглэлд эхэлж ХХЕГ-т тээврийн хэрэгслийн орох бүртгэлийг бүртгэж, цахимаар гаалийн байгууллагад илгээнэ. -Хилээр гарах чиглэлд эхэлж Гаалийн байгууллага тээврийн гарах бүртгэлийг КАИС системд бүртгэж, ХХЕГ-руу цахимаар илгээнэ. Үүний дараа ХХЕГ-аас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчийн мэдээллийг бүртгэж, гаалийн байгууллагад илгээнэ. “ХУН” системийн холболтын модуль ашиглан чөлөөт бүсийн дэлгүүр, үйлдвэрийн газар нэг талаас нөгөө талаас Хил хамгаалах ерөнхий газар, ГЕГ, Замын-Үүд Чөлөөт бүсийн захирагчийн алба нэг цогц болж, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем CAIS-д нэмэлт, өөрчлөлт оруулах, Хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд холбох программын хөгжүүлэлтийг гүйцэтгэж, туршилтаар нэвтрүүлэхээр 2024 оны 11 дүгээр сарын 11-14-ний өдрүүдэд Замын-Үүд дэх Чөлөөт бүсэд ГЕГ, ХХЕГ, Гэрэгэ системс ХХК, Аствишн ХХК гэсэн 4 байгууллагын ажлын хэсэг томилогдон ажилласан. Үнэлгээ: 85 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
4.23	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, “Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендерийн стратегийн дунд хугацааны баримт бичгийн 2020-2024 он буюу II үеийн	Үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Монгол Улсын сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендерийн стратеги баримт бичгийн 2023 оны хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг Сангийн яаманд тухай бүр хүргүүлж ажилласан.	Монгол Улсын сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендерийн стратеги (2016-2024) баримт бичгийн II үеийн хэрэгжилтийг хангасан байна.	Жендерийн стратеги (2016-2024) баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд: -Жендерийн эрх тэгш байдлыг хангах гаалийн байгууллагын дэд салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээтэйгээр төлөвлөн батлуулж, биелэлтийг ханган ажилласан. -Гаалийн байгууллагын албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан Жендерийн талаарх мэдээлэл болон Ажлын байрны бэлгийн дарамт, жендерийн тэгш байдал, ялгаварлан гадуурхахтай холбоотой гомдлыг хүлээн авах талаарх мэдээллийг Гаалийн захиргаа, дотоод ажлын систем программд байршуулсан. -Жендерийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад хэрэгжүүлэх жендерийн стратегийн үнэлгээ”-ний талаар техникийн зөвшилцөх сургалтад 15 албан хаагч, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024	90 хувь

	хэрэгжилтийг хангах				оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)”-г танилцуулах арга хэмжээнд 10 албан хаагч тус тус оролцсон. Мөн Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгууллага, агентлагийн “Жендерийн стратеги 2019-2024” дунд хугацааны стратеги нь энэ онд дуусаж байгаатай холбогдуулан Жендерийн үндэсний хорооноос “Жендерийн стратегийн үнэлгээ”-г хийж байгаа бөгөөд тус үнэлгээний хүрээнд Улаанбаатар хот дахь гаалийн газрын 10 албан хаагчтай Жендерийн үндэсний хорооны зөвлөх ажилтан фокус ярилцлага хийсэн. Энэхүү үнэлгээ хийгдсэнээр тус стратегийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, хийгдээгүй үлдсэн зорилт арга хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. -Татварын ерөнхий газрын Жендерийн бодлого, төлөвлөлтийн талаар туршлага судалсан. -Харьяа гаалийн газар, хороодод Жендерийн асуудлыг хариуцах албан хаагчдын судалгааг гаргасан. Үнэлгээ: 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн.	
Нийт дундаж үнэлгээ: 90.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.						